



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛЖ, ЗОРИЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/16-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Н.Анхбаяр

Утас: 262451, Цахим хаяг: ankhbayarn@audit.gov.mn

Ахлах аудитор М.Наранжаргал

Утас: 262451, Цахим хаяг: naranjargalm@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Өлзийдэлгэр

Утас: 329876, Цахим хаяг: ulziidelgerg@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Билэгт

Утас: 261745, Цахим хаяг: bilegtb@audit.gov.mn

Аудитор: Б.Золбаяр

М.Баяртогтох

Б.Буянхишиг

Н.Нарантуяа

Б.Мөнхтуяа

М.Номин-Эрдэнэ

Г.Сарангоо



Улаанбаатар хот
2024 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.2, 29.3, 29.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), төсвийн ерөнхийлөн захирагч нарт, албан шаардлагыг хэрэгжүүлэн, биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор ирүүлэхийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3-4
Хүснэгтийн товъёг	5
Дүрслэлийн товъёг	5
Зургийн товъёг	6
Хавсралтын товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	7
Ерөнхий мэдээлэл	8-9

БҮЛЭГ I. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2021-2023 ОНЫ БИЕЛЭЛТ 70.5 ХУВЬТАЙ БУЮУ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫГ БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА

- <i>Нэг. “ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хэрэгжилт 83 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна</i>	10-11
- <i>Хоёр. Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт 67 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна</i>	12-18
- <i>Гурав. Эдийн засгийн бодлогын хэрэгжилт 59 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна</i>	19-39 39-48
- <i>Дөрөв. Засаглалын бодлогын хэрэгжилт 74 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна</i>	48-52
- <i>Тав. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт 67 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна</i>	52-56
- <i>Зургаа. Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт 73 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.</i>	

БҮЛЭГ 2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРСЭН ТҮВШНИЙ ҮНЭН, ЗӨВ ЭСЭХИЙГ НЯГТЛАН ШАЛГААГҮЙ, НОТЛОХ БАРИМТАД ҮНДЭСЛЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

- <i>“Шилэн дансны хөтөлөлтийн нэгдсэн үнэлгээ”-ний тайланг Сангийн яамнаас гаргасан байна</i>	57-58 58-59
- <i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг бодитой тайлагнаагүй, арга хэмжээний хэрэгжилтийг баримт нотолгоонд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ дүгнэлтийг гаргаж хэвшээгүй байна</i>	60-61
- <i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн нотлох баримтын 76.2 хувийг “Төрийн мэдээллийн нэгдсэн цахим сан”-д байршуулаагүй, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлтийг нотолгоонд үндэслэж гаргаагүй байна</i>	62-63
- <i>Засгийн газраас хөтөлбөрийн биелэлтийг нотлох баримтад үндэслэж гаргаагүй, хүрсэн түвшний мэдээллийн үнэн, зөв эсэхийг бодитоор нягтлан шалгаагүй, үе шаттайгаар цогт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, арга хэмжээний үр дүн зорилтоо хангахад чиглэгдсэн эсэхийг нэгтгэн дүгнээгүй байна</i>	

ДҮГНЭЛТ	64
ЗӨВЛӨМЖ	65
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	66-76
Үндэсний аудитын газрын тайлбар	77-78
Хавсралт	79-159

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААН	Аж ахуйн нэгж
АБДХ	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АЕГ	Архивын ерөнхий газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНЗДТГ	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
АНУ	Америкийн нэгдсэн улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БТСУХ	Биеийн тамир спортын улсын хороо
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БУА	Барилга угсралтын ажил
БХУА	Батлан хамгаалахын удирдлагын академи
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГҮА	Засгийн газрын үйл ажиллагаа
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТХЯ	Зам тээвэр, хөгжлийн яам
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МБанк	Монголбанк
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
МБСДС	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НЦС	Нарны цахилгаан станц
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
СЦС	Салхин цахилгаан станц
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХҮБ-2030	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УА	Удирдлагын академи
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ҮИТ	Үндэсний итгэмжлэлийн төв
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ШШЕГ	Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар
ШУТЗ	Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
ШС	Шадар сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
МИДСК	Монголын их дээд сургуулийн консерциум

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 6 бодлогын 1046 арга хэмжээний хэрэгжилтийн түвшин, бодлогын үнэлгээний нэгтгэл	8
Хүснэгт 2	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн 2021-2023 оны хүрсэн түвшний нэгтгэл	9
Хүснэгт 3	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1 бодлогын 37 арга хэмжээний хэрэгжилтийн түвшин, бодлогын үнэлгээний нэгтгэл	10
Хүснэгт 4	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	11
Хүснэгт 5	Хүний хөгжлийн бодлогын 6 зорилгын 44 шалгуур үзүүлэлт, 54 зорилтын 261 арга хэмжээний үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээний нэгтгэл	12
Хүснэгт 6	Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	18
Хүснэгт 7	Эдийн засгийн бодлогын 7 зорилгын 52 шалгуур үзүүлэлт, 87 зорилтын 392 арга хэмжээний үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээний нэгтгэл	19
Хүснэгт 8	Экспортын хэмжээ	27
Хүснэгт 9	Хэрэгжүүлсэн төсөл	28
Хүснэгт 10	Евро-5-ын нийлүүлэлт	29
Хүснэгт 11	Мах, махан бүтээгдэхүүний гаалийн мэдээ	30
Хүснэгт 12	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдрах нийт өрхийн эзлэх хувь	37
Хүснэгт 13	Эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	38
Хүснэгт 14	Эдийн засгийн бодлогын үндсэн чиглэлийн хүрсэн түвшин	38
Хүснэгт 15	Үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлт	39
Хүснэгт 16	Засаглалын бодлого	39
Хүснэгт 17	Засаглалын бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	48
Хүснэгт 18	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	48
Хүснэгт 19	Шалгуур үзүүлэлтийн арга хэмжээний биелэлт	51
Хүснэгт 20	Ногоон хөгжлийн бодлогын үндсэн чиглэлийн хүрсэн түвшин	51
Хүснэгт 21	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	51
Хүснэгт 22	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт	52
Хүснэгт 23	Нийслэл ба бүс нутгийн хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлт	54
Хүснэгт 24	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө	56
Хүснэгт 25	Шилэн дансны хөтөлбөрийн үнэлгээ	57

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдэл олгосон байдал	10
Дүрслэл 2	Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	14
Дүрслэл 3	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	18
Дүрслэл 4	ДНБ, бодит өсөлт	20
Дүрслэл 5	Инфляц	20
Дүрслэл 6	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	23
Дүрслэл 7	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь	24
Дүрслэл 8	Зэсийн баяжмалын экспорт	24
Дүрслэл 9	Газрын тос олборлолтын хэмжээ	25
Дүрслэл 10	Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажлын явц	26
Дүрслэл 11	Нүүрсний экспортын хэмжээ	26
Дүрслэл 12	Тусгай хэрэгцээний отрын бэлчээр	29
Дүрслэл 13	Махны нөөц	30
Дүрслэл 14	Тослог ургамал	31
Дүрслэл 15	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал	32
Дүрслэл 16	Импортын эрчим хүчний хэмжээ	32
Дүрслэл 17	СЭХ-ний суурилагдсан чадлын эзлэх хувь	33
Дүрслэл 18	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	33
Дүрслэл 19	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал	34
Дүрслэл 20	Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадал	35
Дүрслэл 21	Байнгын ашиглалтад оруулах хатуу хучилттай авто замын хүчин чадал	36
Дүрслэл 22	Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн 2025 онд хүрэх түвшний 2023 оны гүйцэтгэлийн харьцуулалт	39
Дүрслэл 23	Цахим засаглалын хөгжлийн индекс	40
Дүрслэл 24	ДБ-ны засаглалын үзүүлэлт	46
Дүрслэл 25	Салбар хоорондын зөвлөлдөх уулзалтын тоо	47
Дүрслэл 26	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	48
Дүрслэл 27	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	49
Дүрслэл 28	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	50
Дүрслэл 29	Төрийн мэдээллийн системд арга хэмжээний нотох баримтыг байршуулаагүй судалгааны нэгтгэл	61

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Цахим гарын үсэг	40
Зураг 2	Шинэчлэгдсэн иргэний үнэмлэх	40
Зураг 3	Оюутан цэрэг	42
Зураг 4	Албан бичиг солилцооны дундын систем /docx.gov.mn/	44
Зураг 5	Газрын зураг /жишээ/	45

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021-2023 оны хооронд хэрэгжүүлсэн "эрчимжүүлэх шаардлагатай" арга хэмжээний жагсаалт	80-136
Хавсралт 2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021-2023 оны хооронд хэрэгжүүлсэн "үр дүнгүй" арга хэмжээний жагсаалт	137-156
Хавсралт 3	"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 61 шалгуур үзүүлэлтээс 2021-2023 оны үр дүнгээр	157-159

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, УИХ-ын 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв”, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг дүгнэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго бүрэн биелсэн үү?</i> 2. <i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийг бодитой үнэлж, тайлагнасан уу?</i>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” дунд хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 6 бодлого, 23 зорилго, 261 зорилт, 1046 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах үүрэгтэй хэрэгжүүлэгч байгууллага, улсын хэмжээнд нэгтгэн үнэлгээ, дүгнэлт гаргах, тайлагнах төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадын 2021-2023 оны үйл ажиллагаа хамрагдсан болно.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудит” стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, “Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх” заавар, аргачлалыг ашиглаж, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар тодруулга авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, аудитын менежер Н.Анхбаяр үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Наранжаргал, Г.Өлзийдэлгэр, Б.Билэгт, аудитор М.Баяртогтох, Б.Золбаяр, Ц.Мөнхтуяа, М.Номин-Эрдэнэ, Б.Буянхишиг, Н.Нарантуяа, Г.Сарангоо нар 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.</p>
<p>Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:</p>	<p>Аудит гүйцэтгэх хугацаа богино, хүний нөөцийн хангалтгүй байдал, зарим арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нотлох баримт хангалтгүй гаргаж өгсөн нь хүндрэл учруулж байсан.</p>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2021-2023 оны хооронд 6 бодлого, 23 зорилго, 261 зорилтын хүрээнд 1046 арга хэмжээг 154 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй, үндсэн хэрэгжүүлэгч 16 яам, 8 тохируулагч, 2 хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, зарим төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 6 бодлогын хэрэгжилт 2021-2023 оны байдлаар үр дүн 70.5 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Хүснэгт 1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 6 бодлогын 1046 арга хэмжээний хэрэгжилтийн түвшин, бодлогын үнэлгээний нэгтгэл /тоо.хувь/

Бодлогын дугаар	Бодлогын нэр	Зорилго	Зорилт	Арга хэмжээний	Хэрэгжилтийн түвшин /тоогоор/				Бодлогын биелэлт, үнэлгээ /хувь/
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Нэг	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	15	38	22	13	0	3	83
Хоёр	Хүний хөгжлийн бодлого	6	55	263	77	86	71	29	67
Гурав	Эдийн Засгийн бодлого	7	82	391	100	107	115	69	59
Дөрөв	Засаглалын бодлого	6	70	275	98	95	65	17	74
Тав	Ногоон Хөгжлийн бодлого	1	12	34	13	8	7	6	67
Зургаа	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	2	27	45	16	15	13	1	73
Нийт дүн		23	261	1046	326	324	271	125	70.5

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д нийт 6 бодлогын 48 зорилгын хүрээнд 154 шалгуур үзүүлэлтийг тусгахдаа “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын “Цар тахлын үеийн хүн, амын эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшингүй баталсан байна.

Харин “Хүний хөгжлийн бодлого”-ын 6 зорилго, Эдийн засгийн бодлогын 7 зорилго, Засаглалын бодлогын 6 зорилго, Ногоон хөгжил бодлогын 1 зорилго, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 2 зорилгын хүрээнд нийт 153 шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшинг баталсан бөгөөд 2021-2023 оны хооронд 80 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин хангагдаж 52.3 хувь, 72 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин хангагдаагүй буюу 47.1 хувийг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн 2021-2023 оны хүрсэн түвшний нэгтгэл

Бодлогын дугаар	Бодлогын нэр	Зорилгын тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	2021-2023 онд хүрсэн түвшин /тоогоор/	
				хүрсэн	хүрээгүй
Хоёр	Хүний хөгжлийн бодлого	6	44	20	23
Гурав	Эдийн Засгийн бодлого	7	52	31	21
Дөрөв	Засаглалын бодлого	6	30	15	15
Тав	Ногоон Хөгжлийн бодлого	1	14	6	8
Зургаа	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	2	13	8	5
Нийт дүн		23	153	80	72

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан 153 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дэх заалтаар "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг 95 шалгуур үзүүлэлтээс 61 шалгуур үзүүлэлт буюу 64.2 хувь нь уялдсанаас 2021-2023 оны үр дүнгээр 17 шалгуур үзүүлэлтийн үр дүн нь хангагдаж 27.9 хувийн хэрэгжилттэй, 44 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин хэрэгжих шатанд байна. /Хавсралт 3/

БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2021-2023 ОНЫ БИЕЛЭЛТ 70.5 ХУВЬТАЙ БУЮУ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫГ БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА

НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

1.1 “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд 1 зорилго, 15 зорилтын 38 арга хэмжээнээс үр дүнтэй хэрэгжсэн 22 буюу 57.9 хувь, тодорхой үр дүнд хүрсэн 13 буюу 34.2 хувь, үр дүнгүй арга хэмжээ 3 буюу 7.9 хувийг эзлэж, нийт бодлогын хэрэгжилт 83.0 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.


Хүснэгт 3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1 бодлогын 37 арга хэмжээний хэрэгжилтийн түвшин, бодлогын үнэлгээний нэгтгэл

Бодлогын нэр	Зорилго	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин			
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй
“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	15	38	22	13	0	3

Эх сурвалж: УАГ-ын нэгтгэл судалгаа

Дүрслэл 1.

1.2 “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно” арга хэмжээний хүрээнд 2021 онд 1,220,158 хүүхдэд улсын төсвөөс 1,336.3 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 118.9 тэрбум төгрөг, нийт 1,455.2 тэрбум төгрөг олгож, 2022 онд 1,237,490 хүүхдэд улсын төсвөөс 1,484.9 тэрбум төгрөг олгож, 2023 онд 1,305,322 хүүхдэд улсын төсвөөс 1,520.1 тэрбум төгрөг буюу 2021-2023 онд нийт 4,460.3 тэрбум төгрөгийг олгосон байна. /үр дүнтэй 100, Сангийн яам/



Эх сурвалж: Сангийн яам

- 1.1.1.2. “Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг 2020 оны 10 дугаар сараас хойш хэсэгчлэн үргэлжлүүлнэ” арга хэмжээний хүрээнд 33,854 ажил олгоогчийн 410,678 албан журмын даатгуулагчийн 602.4 тэрбум төгрөг, 169,174 сайн дурын даатгуулагчийн 29.3 тэрбум төгрөг, давхардсан тоогоор 199,404 даатгуулагчийн 19.7 тэрбум төгрөгийг ажилгүйдлын даатгалсан сангийн дэмжлэг буюу нийт 651.5 тэрбум төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт болон хөнгөлөлтийг үзүүлсэн байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 1.1.1.3. “Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2020 оныг дуустал үргэлжлүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2020 онд жилийн 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой жижиг, дунд 15171 аж ахуйн нэгжийг 2020 он дуустал хугацаанд 116.9 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлсөн байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 1.1.1.4. “Түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод 2020 оныг дуустал татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэн үзүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2021 онд

- 4165 аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод 2021.07.01-ний өдөр хүртэл 1.1 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлтийг үзүүлсэн байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 1.1.2.1. "Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ" арга хэмжээний хүрээнд нөөц сангийн хөрөнгөнөөс 2021 онд 64.9 тэрбум, 2022 оны 14.5 тэрбум, 2023 онд 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
 - 1.1.2.4. "Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна" арга хэмжээний хүрээнд 2021 онд 2-11 насны 347763 хүүхэд, 2022 онд 1-5 насны 248562 хүүхэд, 2023 онд 2-5 насны 154042 хүүхэд вакцинд хамрагдсан байна. /тодорхой үр дүнд хүрсэн 94%, ЭМЯ/
 - 1.1.7.1 "Шилжин ирэгчдийг КОВИД-19-ийн хариу арга хэмжээнд хамруулахад чиглэсэн судалгаа хийх, нутагтаа шилжиж ирсэн хүмүүсийн нөхцөл байдлыг үнэлэх, нийгмийн ажилтнуудад сургалт явуулах, төрийн бус байгууллагуудын үйлчилгээг дэмжих, мэдээллийн кампанит ажил явуулна" арга хэмжээний хүрээнд 2021 онд 325.0 тэрбум төгрөг, Гадаадын зээл, тусламж /НҮБ (ОУШХБ)/-ийг олгогдсон байна. /үр дүнтэй 100%, Шадар сайд/

1.3 Тус бодлогын 1.1.3 "Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана" зорилтын дараах 3 арга хэмжээ, 1.1.10 зорилтын 1 арга хэмжээ санхүүжилт батлагдаагүй, эрх хүлээн авагч татан буугдсан, зохион байгуулалт хангалтгүй шалтгаанаар зорилтот үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

- 1.1.3.2. "Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна." 2021 онд Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод коронавируст халдварын идэвхтэй тандалтын нэгж байгуулсан. /2 боомт/ 2022 онд тооцоо судалгаа хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч буцаагдсан байна. Тооцоо судалгаа дутуу хийгдсэн. /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 1.1.3.5. "Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна" Арга хэмжээний хүрээнд 2022 онд тендерийг зарласан боловч тендерт оролцогч нар тендерийн шаардлага хангаагүй, 2023 оны улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй тул хэрэгжээгүй. /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 1.1.10.4. "Анод, Зоос банкуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлнэ" арга хэмжээний үр дүн гараагүй, Анод банк, Зоос банкны эрх хүлээн авагч татан буугдсан шалтгаанаар Сангийн яамнаас Засгийн газрын авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй. /үр дүнгүй 0, Сангийн яам/

1.4 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 4,837.2 тэрбум, гадаадын зээл тусламжаас 245.7 тэрбум нийт 5,142.3 тэрбум төгрөг баталсан байна. Үүнээс улсын төсвөөс 4,687.1 тэрбум, гадаадын зээл тусламжаас 590.5 тэрбум нийт 5,321.2 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 4. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө

№	эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	19	4,837.2	94.1	20	4,687.1	88.1
2	Гадаадын зээл, тусламж	11	245.7	4.8	17	590.5	11.1
3	ЗГТС	2	59.4	1.2	2	43.6	0.8
	Нийт	32	5,142.3		39	5,321.2	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.5 “Хүний хөгжлийн бодлого”-ын 6 зорилго 55 зорилтын хүрээнд 44 шалгуур үзүүлэлт, 263 арга хэмжээг 2021-2023 онд хэрэгжүүлэхдээ 6 зорилгын 77 буюу 29.3 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 85 буюу 32.3 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 5 зорилгын 21 шалгуур үзүүлэлтийн 71 буюу 27.0 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 30 буюу 11.4 хувь нь үр дүнгүй, бодлогын нийт хэрэгжилт 67 хувьтай байна.

Хүснэгт 5. Хүний хөгжлийн бодлогын 6 зорилгын 44 шалгуур үзүүлэлт, 54 зорилтын 261 арга хэмжээний үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээний нэгтгэл /тоогоор/

№	Зорилгын нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Зорилтын тоо	ТАХ-ний тоо	Үр дүнгийн үнэлгээ				
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
1	2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	10	14	81	19	18	24	20	
2	2.2. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	1	3	16	3	6	1	6	
3	2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	8	16	68	25	29	13		
4	2.4. Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна	5	3	15	4	6	4	3	
5	2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ	12	15	49	17	16	16		
6	2.6. Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно	8	3	32	8	11	13		
6 зорилгын нийт үр дүн		44	54	263	77	86	71	29	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.6 Зорилго 2.1. “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна”-ийн 14 зорилтын хүрээнд баталсан 10 шалгуур үзүүлэлт бүхий 81 арга хэмжээнээс 19 үр дүнтэй, 18 тодорхой үр дүнд хүрч, 24 эрчимжүүлэх шаардлагатай, 20 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

1.7 Зорилт 2.1.3. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна”-ын 2.1.3.5 дахь арга хэмжээний хүрээнд Түлэнхийн төвийн барилга ашиглалтад орж иргэдэд төрөлжсөн эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.

- 2.1.3.5 “Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна” арга хэмжээ нь 2 блок хэсгээс бүрдэх бөгөөд А блокыг Барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссын 2022 оны БА-119/2022, Б блокыг 2023 оны БА-045/2023 тоот дүгнэлтээр тус тус хүлээн авч, үйл ажиллагааг эхлүүлсэн байна. /үр дүнтэй 100%, ЭМЯ/

1.8 Зорилт 2.1.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ”-ын 2.1.6.7 дахь арга хэмжээний хүрээнд эмнэлгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Үүнд:

- 2.1.6.7 “Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд 1800-0119 тусгай утсаар үзлэгийн цаг авах үйлчилгээ, E-Mongolia цахим системээр дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээ авах цагийг онлайнаар захиалах үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бүрэн ашиглалтад оруулсан байна. /үр дүнтэй 100%, ЭМЯ/

1.9 Зорилт 2.1.7. “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна”-ын 2.1.7.10 арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- 2.1.7.10. “Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулна” арга хэмжээний хүрээнд иргэд даатгуулагчдад зориулсан 1818.mn болон e-daatgal гар утасны программд бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбосноор үйлчлүүлэгч хэзээ, хаана, ямар үйлчилгээ авсан болон иргэний бүртгэлийн мэдээллийг харах, хянах тогтолцоог бүрдүүлж, 3.3 сая даатгуулагчийн мэдээлэл эрүүл мэндийн даатгалын цахим системд бүртгэгдэж, 21 аймагт цахим систем үйлчилгээ нэвтэрсэн байна. /үр дүнтэй 100%. ЭМЯ, Сангийн яам/

1.10 Зорилт 2.1.14. “Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно”-ийн 2.1.14.2 дахь арга хэмжээний хүрээнд сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийн нэг маягийн зургийг баталжээ.

- 2.1.14.2 “Сумдын эмнэлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ” арга хэмжээний хүрээнд Боловсролын байгууллагын барилгын ариутгах татуургын “Цэвэрлэх байгууламж /шингээх/” нэг маягийн батлагдсан зураг төслийг ашиглахаар 2021.06.22-ны ЭМЯ-нд 3/2476 тоот албан бичгээр хүргүүлсэн. Зураг төслийн дагуу ЭМСайдын багцад нийт 24 тэрбум, үүнээс 2022 онд 3.0 тэрбум төгрөгийн санхүүжүүлэхээр батлагдсан. 1 хоногт 6м3, 12м3 бохир ус цэвэрлэх бага хүч чадлын цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төслийг боловсруулж, 2021.06.22-ны 3/2476 тоот албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн байна. /үр дүнтэй 100%, БХБЯ/

1.11 Зорилт 2.1.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ”-ын 2.1.6.8 дахь арга хэмжээний хүрээнд 272 сумын эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн байна.

1.12 Зорилт 2.1.9. “Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ”-ийн 2.1.9.6 “Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2021 онд 46 сувилахуйн сургагч багш, 24 чиглүүлэгч багш бэлтгэгдсэн. 2022 онд 17 сувилагч, эх баригч нарыг 2 ээлжийн сургалтад хамруулсан байна. 2023 онд эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтад нийт 120 сувилагч, 70 эх баригч бэлтгэгджээ. /тодорхой үр дүнд хүрсэн 92.3, ЭМЯ/

1.13 Зорилт 2.1.1. “Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ”-д туссан 4 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- 2.1.1.4. ““Хавдрын эсрэг” арга хэмжээ хэрэгжүүлнэ” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 50%, ЭМЯ/
- 2.1.1.5. ““Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлнэ” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 50%, ЭМЯ/

- 2.1.1.6. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 56%, ЭМЯ/
- 2.1.1.7. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлнэ” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 61%, ЭМЯ/

1.14 Харин дараах арга хэмжээнүүд санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй, хамтран хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаа, холбоогүй байдал, худалдан авах ажиллагаатай холбоотой зохион байгуулалт хангалтгүй зэрэг шалтгаанаар зорилтын үр дүн хангагдаагүй байна. Тухайлбал:

- 2.1.3.1. “Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна” арга хэмжээ /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.3.2. “Зүрх судасны төв байгуулна” арга хэмжээ /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.3.6. “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна” арга хэмжээ /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.3.7. “Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна” арга хэмжээ /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.3.8. “Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина” арга хэмжээний хүрээнд зураг төсөл гүйцэтгэгчтэй 2021 оны 09 дүгээр сард гэрээ хийсэн боловч газрын байршил өөрчлөгдсөн, газар чөлөөлөлттэй холбоотойгоор ажил удааширсан байна. /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.3.3. “Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна” арга хэмжээний хүрээнд 2019 онд зураг төсөл, ТЭЗҮ батлагдаж худалдан авах ажиллагааг зарласан ч маргаан гарч шүүхийн эцсийн шийдвэр 2023 оны 04 дүгээр сард гарсан байна. /үр дүнгүй 25, ЭМЯ/
- 2.1.2.1. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ” арга хэмжээний хүрээнд үр ашгийн судалгаа хийгээгүй байна. /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.5.7. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна” арга хэмжээ хэрэгжээгүй буюу 2021-2023 онд Нийгмийн эрүүл мэндийн төвийг шинээр байгуулаагүй байна. /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.9.5. “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ” арга хэмжээ /үр дүнгүй 0, ЭМЯ/
- 2.1.11.2. “Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина” арга хэмжээний хүрээнд “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл”-ийн зургийн зөвлөх компани “Татах хүч” ХХК шалгарснаас өөр тодорхой ажил хийгдээгүй байна. /үр дүнгүй 0, ЭМЯ/

1.15 **Зорилго 2.2.** “Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ”-ын 3 зорилтын хүрээнд баталсан 1 шалгуур үзүүлэлт бүхий 16 арга хэмжээнээс үр дүнтэй 3, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 1, үр дүнгүй хэрэгжсэн 6 арга хэмжээ байна. Тухайлбал:

1.16 “Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)” шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин хангагдсан байна.

Дүрслэл 2.

- 2.2.1.1. “Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2021 онд ковид-19 цар тахлаас шалтгаалан иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорил явагдаагүй. 2022 онд иргэдийн 78.5% буюу 272,726 иргэн А, В, С үнэлгээтэй, 2023 онд иргэдийн 68.3 % буюу 98,857 иргэн А, В, С буюу хангалттай үнэлгээ авсан нь хүрэх үр



Эх сурвалж: УАГ

- дүнг хангасан байна. /үр дүнтэй 100, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.1.2. “Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлнэ” арга хэмжээний хүрээнд сумдад нийт 137 орон тооны арга зүйчдийг нэмэгдүүлж ажилласан байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.3.5. “Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна” ажлын хүрээнд Баянгол дүүргийн спорт цогцолбор 2022 онд ашиглалтад орсон. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.2.2. “Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна” арга хэмжээний хүрээнд 2022-2023 онд “Монголын Оюутаны спортын наадам”, Монголын үндэсний спортын наадам”, “Монголын бүх ард түмний спортын XV зуны спортын наадам”-ыг тус тус зохион байгуулж, 2023 онд иргэдийн спортын наадмыг 9 төрлөөр зохион байгуулсан байна. /үр дүнтэй 100%, ЗГХЭГ, БТСУХ/

1.17 Зорилтын 2.2.3. “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина”-ын дараах арга хэмжээний хэрэгжилт санхүүжилт шийдэгдээгүй, яриа хэлэлцээрийн түвшинд байгаа шалтгаанаар хэрэгжилт хангалтгүй байна.

- 2.2.2.3. “Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно” арга хэмжээ зохион байгуулалтын ажил удаашралтай байгаагаас шалтгаалж хэрэгжилт хангалтгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.3.2. “Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ” арга хэмжээ зохион байгуулалт хангалтгүй, санхүүжилт шийдэгдээгүй /үр дүнгүй 0, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.3.3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна” арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүрэгт 10 га газрын асуудлыг шийдвэрлэсэн хэдий ч БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх яриа хэлэлцээний түвшинд байна. /үр дүнгүй 25, ЗГХЭГ, БТСУХ/
- 2.2.3.4. “Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна” арга хэмжээ санхүүжилт шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй байна. /үр дүнгүй 0, ЗГХЭГ, БТСУХ/

1.18 **Зорилго 2.3.** “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ”-ын 16 зорилтын хүрээнд баталсан 8 шалгуур үзүүлэлт бүхий 68 арга хэмжээнээс үр дүнтэй 25, тодорхой үр дүнд хүрсэн 25, эрчимжүүлэх шаардлагатай 14, үр дүнгүй хэрэгжсэн 4 арга хэмжээ байна. Тухайлбал:

1.19 Зорилт 2.3.4. “Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ”-ийн хүрээнд 4 арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна. Үүнд:

- 2.3.4.2 “Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг шинэчилж, сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгоно” арга хэмжээ
- 2.3.4.3 “Үндэстний цөөнхийн хүүхдүүд, лам хүүхдүүд болон гадаадад гацсан хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлж, шаардлагатай сурах материалаар хангана.” арга хэмжээ
- 2.3.4.4. “Сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ” арга хэмжээ
- 2.3.4.7 “Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлнэ арга хэмжээ.

1.20 Дараах 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрчээ. Тухайлбал:

- 2.3.8.2. “Багш мэргэжлээр их, дээд сургуульд суралцагчдад дэмжлэг үзүүлнэ” арга хэмжээ 2023 оны эхний хагас жилд 15 их, дээд сургуулийн 592 багш мэргэжлээр суралцагчид 0.8 тэрбум төгрөг, багш бэлтгэгчид 9 их, дээд сургуулийн 200 оюутанд багшлах дадлагын тэтгэлэгт 141.3 сая төгрөгийн олгосон байна /тодорхой үр дүнд хүрсэн 90%, БШУЯ/

- 2.3.12.2. "Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүлнэ" арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 70%, БШУЯ/

1.21 Харин дараах 5 арга хэмжээний хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд.

- 2.3.2.6 "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дунд хамтын ажиллагааг бэхжүүлнэ" арга хэмжээний хүрэх түвшинг 2023 онд "Үйл ажиллагааны төлөвлөгөөний 60 хувийг хэрэгжүүлсэн байна" гэж тодорхойлсон боловч үйл ажиллагааны 30 хувийг хэрэгжүүлсэн нь хүрэх түвшний өссөн үр дүнг хангаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БШУЯ/
- 2.3.2.4 Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ" арга хэмжээнд "10 бүлэг нээж 250 хүүхдийг хамруулсан байна" гэж хүрэх түвшинд тодорхойлсон боловч хүрэх түвшин хангаагүй, санхүүжилт шийдэгдээгүй. /эрчимжүүлэх шаардлагатай 3%0, БШУЯ/
- 2.3.5.4. "Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгоно" арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БШУЯ/
- 2.3.10.3 "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ" арга хэмжээний хүрээнд тайлагнал оновчгүй, 2021, 2022 онд "310 сургуулийг цэвэршүүлэгчтэй төхөөрөмжөөр бүрэн хангасан байна" гэсэн хүрэх түвшинг хангасан эсэх нь тодорхойгүй /үр дүнгүй 0, БШУЯ/
- 2.3.16.1. "Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ" арга хэмжээ нь "Ерөнхий боловсролын 10 сургуулийн сургалтын хөтөлбөрийг олон улсын хөтөлбөрт шилжүүлсэн байна" гэсэн хүрэх түвшинд хүрээгүй ч, олон улсын хөтөлбөрт шилжүүлэх эрхээ авсан, бэлтгэл шатандаа байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БШУЯ/

1.22 **Зорилго 2.4.** "Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна"-ийн 3 зорилтын хүрээнд баталсан 5 шалгуур үзүүлэлт бүхий 15 арга хэмжээнээс 4 үр дүнтэй, 6 тодорхой үр дүнд хүрч, 4 эрчимжүүлэх шаардлагатай, 1 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

- 2.4.3.5. "Шинжлэх ухааны мэдлэг, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, танин мэдэхүйн агуулга бүхий контент бүтээх ажлыг дэмжих замаар шинжлэх ухаанч соёлыг төлөвшүүлнэ" арга хэмжээний хүрээнд иргэд, олон нийтийн нийгмийн инновацийн санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх "МОН ИКС" хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, БШУЯ/
- 2.4.2.3. "Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина" арга хэмжээний хүрээнд цогцолборын инженерийн дэд бүтцүүдийн техникийн нөхцөлүүдийг холбогдох байгууллагуудаар батлуулж, зураг төслийн магадлалын дүгнэлтийг Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Санхүүжилтээс шалтгаалж хүрэх түвшинд хүрээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БШУЯ/

1.23 **Зорилго 2.5.** "Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ"-ын 15 зорилтын хүрээнд баталсан 12 шалгуур үзүүлэлт бүхий 49 арга хэмжээнээс 17 үр дүнтэй, 16 тодорхой үр дүнд хүрч, эрчимжүүлэх шаардлагатай 16 арга хэмжээ байна. Тухайлбал:

- 2.5.4.4. "Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгоно" арга хэмжээний хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021.07.02-ны өдөр баталсан. /үр дүнтэй 100%, ХНХЯ/
- 2.5.5.2. "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ" арга хэмжээний хүрээнд Засгийн газраас 2022.02.01-

ний өдрөөс тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлснээр дундаж тэтгэвэр 0.5 сая төгрөгт, 2023.7.01-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлснээр дундаж тэтгэвэр 0.7 сая төгрөгт хүрсэн байна. /үр дүнтэй 100, ХНХЯ/

- 2.5.15.1 “Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2021 онд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. /үр дүнтэй 100, ХНХЯ/
- 2.5.6.2. “Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ” арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээнээс 28 үйлчилгээг цахимжуулсан. 16 үйлчилгээг E-Mongolia цахим системд холбосон байна. /тодорхой үр дүнд хүрсэн 80%, ХНХЯ/
- 2.5.4.1 “Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар ХЗДХЯ-нд 2023.12.01-ний өдрийн 01/3132 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. /Эрчимжүүлэх шаардлагатай 50%, ХНХЯ/
- 2.5.8.4. “Хүн амын амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн Хүний амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд Хөтөлбөрийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн ч буцаагдсан байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ХНХЯ/

1.24 **Зорилго 2.6.** “Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно”-ын хүрээнд зорилгын 3 зорилтын хүрээнд баталсан 8 шалгуур үзүүлэлт бүхий 32 арга хэмжээнээс 8 үр дүнтэй, 11 тодорхой үр дүнд хүрч, эрчимжүүлэх шаардлагатай 13 арга хэмжээ байна. Тухайлбал:

1.25 Зорилт 2.6.1.” Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн 4 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- 2.6.1.2. “Байгалийн түүхийн шинэ музей” арга хэмжээ ХАА-тай холбоотойгоор удааширсан, БУА 40 хувийн гүйцэтгэлтэй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, СоЯ/
- 2.6.1.6. Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв” арга хэмжээний хүрэх түвшинг БУА дууссан байхаар тодорхойлсон ч ажил эхлээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, Соёлын яам/
- 2.6.1.7 “Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр” арга хэмжээний хүрээнд зураг төсөл, төсвийн МЭД-ээр баталгаажуулсан. Хүүхэлдэйн театр, хүүхдийн номын сангийн барилга угсралтын ажил 60 хувь байхаар хүрэх түвшинг төлөвлөсөн ч 2023 оны байдлаар БУА эхлээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, СоЯ, БХБЯ/
- 2.6.1.11 “Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ” арга хэмжээний хүрээнд барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлсэн байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БХБЯ/

1.26 Харин 2.6.2 зорилтын хүрээнд арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.

- 2.6.2.5. ““Монгол өв ба дэлхий дахин” олон улсын арга хэмжээ” “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд. ОХУ-ын Эрмитаж музейд хадгалагдаж байгаа Монгол өв, Норвег улсад буй өв гэх мэт 10 цуврал бүтээл хэвлэн нийтэлсэн. “Монгол өв ба дэлхий дахин” төлөвлөгөөний төсөл, “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны бодлогын төслийн тус бүр боловсруулж батлуулсан. /үр дүнтэй 100%, СоЯ/


1.27 “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд “Хүний хөгжлийн бодлого”-ын

6 зорилгын 44 шалгуур үзүүлэлтээс 20 нь хүрэх түвшинд хүрсэн, 24 нь Ковид-19 цар тахал, хуульд өөрчлөлт орсон, иргэдийн идэвх оролцоо зэрэг шалтгаанаар хүрэх түвшинг бүрэн хангаагүй байна.

1.28 Зорилго 2.1, 2.3, 2.6-ийн 3 шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хүрсэн байна. Тухайлбал:

- 2.1.2. “Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь”-ийг 2021 онд 91.2, 2022 онд 91.7, 2023 онд 92.7 хувьд хүргэх шалгуур үзүүлэлт төлөвлөж 2021 онд 91.0, 2022 онд 93.8, 2023 онд 99.0 хувьд хүргэж шалгуур үзүүлэлт хангагдсан байна.

- 2.3.13 “Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /3-5 нас/” зорилгын хүрэх түвшин 2021 онд 87.3 хувь, 2022 онд 89.9 хувь, 2023 онд 88.5 хувь байхаар тодорхойлж, 2021 онд 80 хувь, 2022 онд 90.4 хувь, 2023 онд 92.8 хувь, 2023 байдлаар 4,3-аар өсөж зорилтод үр дүнг хангасан байна.



Эх сурвалж: УАГ

- 2.6.43 “Музейгээс зохион байгуулсан үзэсгэлэнгийн тоо”-ын 2021 онд 50, 2022 онд 55, 2023 онд 60 гэсэн хүрэх түвшин тодорхойлж, 2021 онд 187, 2022 онд 1731, 2023 онд 1731, 2023 оны байдлаар 1671 буюу 96.5 хувиар өсөж зорилтод үр дүнг хангасан байна.

1.29 Харин 2.1, 2.3, 2.4, 2.5, 2.6 дугаар зорилгын 3 шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хүрээгүй байна.

- 2.1.4. “1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин” 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2021 онд зорилтот түвшиндээ хүрсэн байна. 2022, 2023 онд түвшинд хүрээгүй ч 2023 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:

- Перинаталь үед үүссэн эмгэг- 2022 онд 503 (60.7%), 2023 онд 421 (51.7%);
- Төрөлхийн хөгжлийн гажиг- 2022 онд 133 (16%), 2023 онд 140 (17.2%);
- Амьсгалын тогтолцооны өвчин- 2022 онд 49 (5.9%), 2023 онд 84 (10.3%);
- Осол гэмтэл- 2022 онд 42 (5.1%), 2023 онд 51 (6.3%);

- 2.1.7. “Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь”-ийг 2021 онд 77.9, 2022 онд 80.3, 2023 онд 82.7 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч 2021 онд 82.4, 2022 онд 74.8, 2023 онд 79.1 хувьтай биелж, шалгуур үзүүлэлтээ хангаагүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна;

- 2.3.15 “5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт”-ын хүрэх түвшин 2021 онд 93.3 хувь, 2022 онд 95.0 хувь, 2023 онд 96.7 хувиар тодорхойлж, 2021 онд 91.2, 2022 онд 93.3, 2023 онд 94.8 хувийн хэрэгжилт нь 1.9 хувиар буурсан;

- 2.6.40 “Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж”-ын 2021 онд 10.1, 2022 онд 12.1, 2023 онд 14.1 гэсэн хүрэх түвшин тодорхойлж, 2021 онд 4.8, 2022 онд 23.9 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 6. Хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө

№	Эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	126	6,761.3	76.1	104	4,274.4	62.2
2	Гадаадын зээл, тусламж	28	349.5	3.9	31	162.3	2.4
3	Орон нутгийн төсөв	1	15.5	0.2	1	9.1	0.1
6	ЗГТС	26	1,762.9	19.8	37	2,430.1	35.3
	Нийт дүн	181	8,889.2		173	6,875.9	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

1.30 “Эдийн засгийн бодлого”-ын 2021-2023 оны хэрэгжилт 59 хувьтай, зорилтот үр дүнд хүрээгүй байна.

1.31 “Эдийн засгийн бодлого”-ын 7 зорилго 87 зорилтын хүрээнд 31 шалгуур үзүүлэлт, 391 арга хэмжээг 2021-2023 онд хэрэгжүүлэхдээ 2 зорилгын 13 шалгуур үзүүлэлтийн 100 буюу 25.6 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 107 буюу 27.4 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 5 зорилгын 21 шалгуур үзүүлэлтийн 115 буюу 29.4 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 69 арга хэмжээ буюу 17.6 хувь нь үр дүнгүй, бодлогын нийт хэрэгжилт 59 хувьтай буюу эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Хүснэгт 7. Эдийн засгийн бодлогын 7 зорилгын 52 шалгуур үзүүлэлт, 87 зорилтын 392 арга хэмжээний үр дүнгийн хэрэгжилт, үнэлгээний нэгтгэл /тоогоор/


№	Зорилгын нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин			
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд	Эрчимжүүлэх	Үр дүнгүй
1	Санхүү, төсвийн зохицуулалт 3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	3	22	47	10	15	13	7
2	Уул уурхай, хүнд үйлдвэр 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	12	9	66	3	20	23	20
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр. 3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	15	15	61	25	29	6	1
4	3.4.” Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ”,	1	9	18	5	5	6	2
5	Эрчим хүч.3.5.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.	6	7	38	9	11	11	7
6	3.6.”Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна”	8	11	100	21	20	31	28
7	3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	7	14	61	27	6	25	3
7 зорилгын нийт үр дүн		52	87	391	100	107	115	69

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.32 **Зорилго 3.1.**”Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ” зорилгын 22 зорилтын хүрээнд баталсан 3 шалгуур үзүүлэлт бүхий 47 арга хэмжээнээс 10 үр дүнтэй, 16 тодорхой үр дүнд хүрч, 13 эрчимжүүлэх шаардлагатай, 7 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

1.33 "Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ" зорилтын хүрээнд ДНБ-ий бодит өсөлт" 2020 онд -4.4 хувийн уналттай, 2021 онд 1.6 хувийн өсөлттэй гарч зорилтот үр дүнг хангаагүй нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр логистикийн үйл ажиллагааны саатал, экспортын орлогын бууралт, төлбөрийн тэнцлийн алдагдлаар дамжсан ханшийн бууралт, импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөл, инфляцын дарамт зэрэг нөлөөлсөн бол, 2022 онд 5.0 хувийн, 2023 онд 7.1 хувийн өсөлттэй эерэг үзүүлэлтийг бий болгосон байна.


Дүрслэл 4. ДНБ, бодит өсөлт



Эх сурвалж: УАГ

1.34 "Инфляц"-ийн түвшин 2021 онд 3.8 хувь, 2022 онд 13.2 хувь, 2023 онд 7.9 хувьтай гарч 2021 онд 7 хувь, 2022 онд 6 хувь, 2023 онд 6 хувьтай зорилтот үр дүнг хангаагүй "Инфляц" 2021-2023 онд хүрэх түвшинд хүрээгүй байгаа нь Ковид-19 цар тахал, импортын үнийн өсөлт, ханшны сулрал зэргээс шалтгаалсан байна байна. / ЗГ, МБанк, ҮСХ/

Дүрслэл 5. Инфляц



Эх сурвалж: УАГ

1.35 Зорилт 3.1.9 "Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ"-ийн 3.1.9.1 дэх арга хэмжээний хүрээнд 2022 онд 2022-2023 онд эргэн төлөгдөх "Гэрэгэ" бондын 16.3 сая ам.доллар, "Чингис" бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгээр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргаж, зорилтын үр нөлөөг бий болгосон байна. Үүнд:

- 3.1.9.1."Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т тусгасны дагуу Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлнэ" арга хэмжээний хүрээнд ЗГ-ын 2020.09.09-ний өдрийн 102 дугаар тогтоолын дагуу олон улсын санхүүгийн зах зээлд Номад бондыг /жилийн 5.125% -ийн купонтой 5.5 жилийн хугацаатай 600.0 сая ам.доллар/ 2020.09.28-ны өдөр арилжаалж, Мазаалай бонд /2021.04 сард төлөх, /Чингис бонд /2022.12 сард төлөх/-ын тодорхой хэсгийг буцаан худалдан авч, Засгийн газар нь 2021 онд эргэн төлөгдөх 10.875 хувийн хүүтэй Мазаалай бондыг 5.125 хувийн бага хүүтэй шинэ бондоор сольж, жил бүр Засгийн газрын гадаад бондын хүүгийн зардлаас 26.7 сая ам.долларыг хэмнэх боломжийг бүрдүүлсэн. 2023 онд Засгийн газраас олон улсын зах зээлд 2023.01.19-нд "Сенчири-2" үнэт цаасыг /бондыг 5 жилийн хугацаатай, 2028 онд төлөгдөх, 8.65 %-ийн хүүтэй/, 2023.12.05-нд "Сенчири-3" үнэт цаасыг /бондыг 5.5 жилийн хугацаатай, 7.875

%-ийн хүүтэйгээр 2023 онд төлөгдөх нөхцөлтэй/ гаргаж "Хуралдай" бондын /2024 онд төлөгдөх нөхцөлтэй/ үндсэн төлбөрөөс 557.5 сая ам.долларыг дахин санхүүжүүлж, "Гэрээг" бондын үндсэн төлбөрөөс 435.2 сая ам.доллар санхүүжүүлж, 2022 онд Чингис бондын үлдээгдэл төлбөр болох 136.8 сая ам.доллар, 2023 онд Гэрээг бондын үлдээгдэл төлбөр 82.0 сая ам.долларыг төсөө, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүй хэмжээгээр төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулсан байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/

1.36 Зорилт 3.1.11 "Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ"-ийн 3.1.11.1 дэх арга хэмжээний хүрээнд татварын үйлчилгээг ил тод, бүрэн цахим болгосноор татвар төлөгчийн цаг, зардлыг хэмнэх, татварын үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцлийг бий болгож, зорилтоо хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- 3.1.11.1."Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно" арга хэмжээний хүрээнд Татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлан, татварын төлөлт зэрэг татварын албаны үйл ажиллагаа нь бүрэн цахимжсан бөгөөд татварын үйлчилгээг ил тод, бүрэн цахим болгосноор татвар төлөгчийн цаг, зардлыг хэмнэх, татварын үйлчилгээг түргэн шуурхай авах, цар тахлын үед халдвараас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. НӨАТ-ын буцаан олголтгоор татвараа төлөх боломж бүрдсэн ба 2021 оны 3, 4 дүгээр улиралд давхардсан тоогоор 108,136 татвар төлөгч 1,182.2 тэрбум, 2022 онд 165,493 татвар төлөгч 1,808.2 тэрбум, 2023 онд 201,911 татвар төлөгч 1,974.9 тэрбум төгрөгийн татварыг төлсөн байна. /үр дүнтэй 100 %, Сангийн яам/.

1.37 Зорилт 3.1.12 "Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ"-ын 3.1.12.5, 3.1.12.6 дахь арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөө гарч, зорилтоо хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- 3.1.12.5."Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож төсөл, арга хэмжээний үр ашиг, хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулна" арга хэмжээний хүрээнд 2022.12.09-ний өдөр "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдаж, Төсвийн тухай хуулийн 27¹, 28¹, 29¹ дугаар зүйлд УТХО-тай холбоотой нэмэлт өөрчлөлт орж, Төсвийн хэмнэлтийн тухай хуульд УТХО-д тусгахгүй хориглосон заалтыг хуульчилж өгсөн байна. Сангийн сайдын 2023.07.04-ний өдрийн 137 дугаар тушаалаар Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлалыг баталсан байна. ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг Засгийн газрын 2023.07.19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 3.1.12.6."Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хяналт, зөвшөөрлийн процессыг хялбаршуулах, автоматжуулах программ хангамж хөгжүүлнэ" арга хэмжээний хүрээнд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан odamis.mof.gov.mn цахим системийг 2020 оны 12 дугаар сард нэвтрүүлж, 2021 онд сайжруулалт зүгшрүүлэлтийг хийж, системийг 2022.01.20-ны өдөр хүлээн авсан /odamis.mof.gov.mn цахим системийг 82.0 мянган.ам.доллар буюу 8,263.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн/ авсан нь зорилтыг хангасан байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/

1.38 Зорилт 3.1.21."Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1 хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно"-ийн 3.1.21.1 арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөө гарч, зорилтоо хангахад чиглэгдсэн байна. Тухайлбал:

- 3.1.21.1."Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болно" арга хэмжээний хүрээнд 2021-2022 онд 50%-иар хөнгөлөлт үзүүлэх ААН-үүдэд нийт 3,872.9 сая төгрөг, 90%-

иар хөнгөөгөлт үзүүлэх ААН-үүдэд нийт 994.6 сая төгрөгийн татварын хөнгөлөлт /2021 онд Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан 7 аймгийн 28 ААН-д 2,319.8 сая төгрөг, 1000 км-ээс хол алслагдсан 4 аймгийн 27 ААН-д 449.5 сая, 2022 онд 7 аймгийн 46 ААН-д 50%-иар буюу 1,553.1 сая, 12 аймгийн 39 ААН-д 90%-иар буюу 545.1 сая/ үзүүлсэн байна. /үр дүнтэй 100.Сангийн яам/

1.39 Зорилт 3.1.22. “Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ”-ын 3.1.22.1 дэх арга хэмжээний хүрээнд 2020 онд 407916 иргэний нийт 209.4 тэрбум төгрөгийн татварыг ХХОАТ-аас чөлөөлсөн нь зорилтоо хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- 3.1.22.1. “2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд хувийн хэвшилд ажилладаг иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлнө” арга хэмжээнд “Хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх тухай” хуулийн /2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөх/ хүрээнд 2020 онд 407916 иргэний нийт 209.4 тэрбум төгрөгийн татварыг ХХОАТ-аас чөлөөлсөн байна. /үр дүнтэй 100.Сангийн яам/

1.40 Харин 3.1.6. “Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно”, 3.1.14. “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно” зорилтын дараах 2 арга хэмжээ нь байгууллагын чиг үүрэгт хамааралгүй гэсэн үндэслэлээр арга хэмжээний хэрэгжилтийг хангуулаагүй, холбогдох ажлын хэсэг байгуулагдсан ч ямар ажил хийсэн нь тодорхойгүйгээс зорилтын үр дүн бүрэн хангагдаагүй байна. Тухайлбал:

- 3.1.14.3. “Хувийн хэвшлийн санхүүгийн санаачлагын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ” арга хэмжээний хүрээнд хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг /ажлын хэсгийн гишүүнээр Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга/ хуулийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлээгүй, ямар ажил хийж байгаа нь тодорхойгүй байна. /үр дүнгүй 0, Сангийн яам/
- 3.1.6.1. “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулна” арга хэмжээний хүрээнд 2021 онд Монголбанкны ерөнхийлөгчийн 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А-6 тоот тушаалаар Ажлын хэсгийг байгуулсан /ажлын хэсэгт Сангийн яам оролцоогүй/ ч Сангийн яам нь тус яаманд хамааралгүй ажил гэсэн нэрийдлээр хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах талаар тодорхой ажлыг зохион байгууллаагүйгээс 2022 онд Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг батлуулсан байна... зорилт биелээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 69, Сангийн яам/

1.41 Мөн УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д заасан хугацааг баримтлаагүй, холбогдох ажлыг хэсэг байгуулагдсан ч ямар ажил хийсэн тодорхойгүй, байгууллага хоорондын хамтран ажиллах ажлыг зохион байгууллаагүй, санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолоогүйгээс 3.1.4¹, 3.1.14², 3.1.15³ зорилтын 5 арга хэмжээ нь зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ байна. Үүнд:

- 3.1.4.1. “Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна”, 3.1.5.1. “Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг сайжруулна” гэсэн 2 арга хэмжээний хүрээнд 2023 онд Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан” гаргасан нь УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 49 дүгээр зүйлд ...2022 онд багтаан

¹ 3.1.4. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.

² 3.1.14. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно.


³ 3.1.15. Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.

- боловсруулж, өргөн мэдүүлэх... гэж заасан хугацаанд хэрэгжээгүй, эрх зүйн орчныг сайжруулах ажлын үр нөлөө гараагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, Сангийн яам/
- 3.1.14.6. "Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF) нэвтрүүлнэ" арга хэмжээний хүрээнд 2021 онд Засгийн газраас СЯ болон ЭЗХЯ хамтран "Монгол Улсын хөгжлийн бодлогыг санхүүжүүлж буй эх үүсвэрүүдэд үнэлгээ хийж Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF)-ийг" батлах тухай чиглэлийн дагуу Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF)-д мониторинг, хяналт шинжилгээний хүрээнд нэмэлт оруулахаар санал солилцох хэлэлцүүлгийг 2023.12.07-ны өдөр хийсэн байна. 2021 онд "INFF-ийг бий болгох арга замыг хөгжүүлнэ" зорилтот түвшин хүрээгүй, боловсруулалтын шатанд байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, Сангийн яам/
 - 3.1.15.1. "Даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай зэрэг хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулна" арга хэмжээний Сангийн сайд болон ХЗДХ-ийн сайд хамтран 2021 оны 12 дугаар сард хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг УИХ-д өргөн бариагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 60%, Сангийн яам/
 - 3.1.13 "Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ" зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаанаас шалтгаалсан. /үр дүнгүй 0, ЭЗХЯ/
 - 3.1.17. "Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана" Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсноор Шадар сайдаас Чөлөөт бүсийн захиргаа нь ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнээр санхүүжилт шийдэгдээгүй орхигдсон байна. /үр дүнгүй 0, ЭЗХЯ/

1.42 **Зорилго 3.2.** "Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ"-ын 9 зорилтын хүрээнд 12 шалгуур үзүүлэлт бүхий 66 арга хэмжээнээс 3 үр дүнтэй, 20 тодорхой үр дүнд хүрч, 23 эрчимжүүлэх шаардлагатай, 20 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

1.43 Зорилт 3.2.1. "Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ"-ийн хүрээнд 3.2.52. "Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь"-ийн эзлэх хувь 2021 онд 0.8 хувиар, 2022 онд 3.8 хувиар буурсан дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал нөлөөлж, харин 2023 онд зорилтот үр дүнг хангасан байна. /УУХҮЯ/

Дүрслэл 6. Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Эх сурвалж: 1212.mn

1.44 Зорилт 3.2.2. "Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ"-ын 3.2.2.1. "Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана" арга хэмжээг 2023 оны 3 дугаар улиралд "Баяжуулах-2 үйлдвэр"-ийг ашиглалтад оруулж /үр дүнтэй 100/, 3.2.2.2. "Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна" арга хэмжээний хүрээнд Зүүн цагаан дэлийн далд уурхайн 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч, бүрэн хүчин чадлаар ажлуулж эхэлсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 95%, УУХҮЯ/


Дүрслэл 7. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

1.45 "Зэсийн баяжмалын экспорт"-ийн хүрээнд 2021 онд 1282.5 мян.тонн буюу 89.7 хувийн, 2022 онд 1453.3 мян.тонн буюу 91.4 хувийн, 2023 онд 1524.8 мян.тонн буюу 87.1 хувийн биелэлттэй байгаа нь зорилтот үр дүнг 2021-2023 онд 10.3-12.9 хувиар хангаагүй нь Ковид-19-ын цар тахлын нөлөө болон Оюу толгойн далд уурхай ашиглалтад орох хугацаа хойшилсонтой холбоотойгоор экспорт буурсан байна.

Дүрслэл 8. Зэсийн баяжмалын экспорт



Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

1.46 Харин дээрх 3.2.1⁴ зорилтын 8 арга хэмжээ нь үйлдвэрлэлийн хүчин чадал ямар хэмжээгээр нэмэгдсэн, үйлдвэрлэлийн бүтээмж, үр өгөөжийг нэмэгдүүлсэн нь тодорхойгүй, бодлогын шийдвэр гараагүй, сонгон шалгаруулалт удаашралтай зэрэг шалтгаанаар зорилтын үр нөлөө гараагүй байна. Тухайлбал:

1.47 Арга хэмжээ 3.2.1.2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ"-ыг 4 хэсэгт хувааж хэрэгжүүлэхдээ 2021-2023 онд үйлдвэрлэлийн хүчин чадал ямар хэмжээгээр нэмэгдсэн, үйлдвэрлэлийн бүтээмж, үр өгөөжийг нэмэгдүүлсэн нь тодорхойгүй, бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байна. /эрчимжүүлэх шаардлагатай 69%, УУХҮЯ/

1.48 "Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь"-ийг 2021 онд 9.7 хувь, 2022 онд 9.8 хувь, 2023 онд 9.9 хувь гэж тодорхойлсон ч мөн онуудад ДНБ-ий

⁴ 3.2.1. "Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ" зорилтын хүрээнд Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ"


“Боловсруулах аж үйлдвэрийн салбар”-т эзлэх хувь 2021 онд 2.6 хувиар, 2022 онд 2.7 хувиар, 2023 онд 3.0 хувиар тус тус буурсан дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хөл хорио болон төслийн санхүүжилт шийдвэрлэгдээгүйгээс зорилтот түвшинд хүрээгүй байна.

1.49 Тухайлбал: 3.2.1.5. “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ” арга хэмжээг 4 хэсэгт хувааж хэрэгжүүлэхдээ 2021-2022 онд тодорхой бодлогын шийдвэр гараагүй, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2023.06.20-ны өдрийн №48 тогтоолоор “Асгатын төслийн нэгж”-ийг байгуулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны төсөвт “Асгатын мөнгөний ордын ашиглах ордыг олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад үйл ажиллагааны санхүүжилт нийт 11,090.5 сая төгрөг тусгасан.

1.50 Улмаар 2023.11.13-ны өдөр ТХААГ-ын системд “Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах” сонгон шалгаруулалтын урилгыг байршуулсан нь 2023 оны хүрэх түвшин “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 95 хувь” гэсэн зорилтыг хангаагүй байна. /үр дүнгүй 0, УУХҮЯ, “Эрдэнэс Монгол” ХХК/.

1.51 Мөн 3.2.1.3. “Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулна” арга хэмжээний хүрээнд 2021 онд төслийн бүтээн байгуулалтын ажил суурь түвшнээс 69 хувьтай гэж тайлагнасан ч 2021 онд бүтээн байгуулалт 22 хувьтай /нотлох баримтыг аудитын багт үзүүлээгүй/, Засгийн газрын 2015 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс “Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр” төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх тухай гэрээг 2023 оны 05 сарын 09-ний өдөр байгуулсан ч 2021-2023 онд Бүтээн байгуулалтын ажил 100 хувьтай байх гэсэн зорилтот түвшинд хүрээгүй. /үр дүнгүй 29%, УУХҮЯ/

Дүрслэл 9. Газрын тос олборлолтын хэмжээ



Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

1.53 Дээрх байдал нь Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бүтээн байгуулалтын ажлын явцад төрийн захиргааны төв байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс газрыг улсын тусгай хэрэгцээнд авах холбогдох шийдвэр чиглэл гараагүй, тус яамнаас дараах ажлын санхүүжилтэд хяналт тавих нөхцөл үүсээгүй, концесс эзэмшигч автозамын ажлыг дуусгаагүйгээс эрчимжүүлэх шаардлагатай дараах төслүүд байна. Үүнд:

- 3.2.8.2."Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ" арга хэмжээний хүрээнд 2020-2023 онд "Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90%... гэсэн хүрэх түвшингийн 40 хувийг гүйцэтгэж байна. /эрчимжүүлэх шаардлагатай 40%, Сангийн яам/.
- 3.2.8.3."Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна" арга хэмжээний хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-аас 2023.09.25-ны 01/549 тоот УУХҮЯ-д хүргүүлсэн албан бичигт ... газрын тос дамжуулах хоолой барих төсөл"-ийн хүрээнд ашиглах газар⁵ нь Улсын тусгай хэрэгцээнд авах шаардлага үүссэн, тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг Засгийн газрын 2023.06.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулсан ч Нууцын зэрэглэлийг буруу тогтоосон гэсэн үндэслэлээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан. 2021 онд "Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулсан байна. 100%..." гэсэн хүрэх түвшингийн 34.5 хувийг гүйцэтгэж, зорилтот үр дүнг 65.5 хувиар хангаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 34.5%, Сангийн яам/


Дүрслэл 10.

1.54 Мөн Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийн ажлын явц"-ийн хүрэх түвшин 2021 онд 25 хувь, 2022 онд 60 хувь, 2023 онд 90 хувьд гэж тодорхойлсон ч 2021 онд 0 хувь, 2022 онд 7 хувь, 2023 онд 32 хувьтай буюу зорилтот үр дүнг 2021 онд огт хангаагүй, 2022-2023 онд 88.3-64.4 хувиар хангаагүй нь ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зохион байгуулалтаас шалтгаалсан байна.



Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

Дүрслэл 11. Нүүрсний экспортын хэмжээ



Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

1.55 Харин нүүрсний экспортын хэмжээ нь 2021 онд 16.1 сая.тонн буюу 55.3 хувь, 2022 онд 31.8 сая.тонн буюу 16.3 хувийн үр дүнг хангаагүй нь цар тахлаас шалтгаалсан хэдий ч 2023 онд 69.6 сая тн буюу 174 хувийн биелэлттэй байна.

1.56 Гэтэл 3.2.1.4-д хамаарах 2 арга хэмжээ, 3.2.1.6-ын 1 арга хэмжээний үр дүн хангагдаагүй, эрчимжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээ байна. Үүнд:

- 3.2.1.4."Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна" арга хэмжээг 3.2.1.4.1, 3.2.1.4.2 гэсэн 2 хэсэгт хувааж хэрэгжүүлэхдээ "Багануур" ХК нь үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 2021-2023

⁵ Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13 заалт "Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар"-т хамаарч байгаа

оны хооронд хийгдээгүй нь 2021 онд ..."Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100 хувь, 2023 онд ..."Багануур" ХК-ийн ил уурхайн хүчин чадал 5.0 сая.тн-д...зорилт хангагдаагүй байна. "Шивээ-Овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хүрээнд 2021 онд 7, 2022 онд 3, 2023 онд 2 нийлүүлж /2021 онд Автосамосвал 5ш, Гидро экскаватор 2ш, 2022 онд технологийн автомашин 2ш, автокран 1ш, 2023 онд цооног цэнэглэгч машин 1ш, 1 гинжит бульдозер/, техникүүдийг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр технологийн автомашины шинэчлэл 30%-тай нь 2023 онд... "Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 70 хувьд хүргэнэ... зорилтот түвшинг 40 хангаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 60%/

- 3.2.1.6." Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна." арга хэмжээг 3.2.1.6.1, 3.2.1.6.2 гэсэн 2 хэсэгт хувааж хэрэгжүүлэхдээ "Нүүрс баяжуулах үйлдвэр"-ийн 2023 онд Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 100 хувь... хүргэх зорилтоос 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 64.4 хувьтай байгаа нь 35.6 хувийг хангаагүй, "Ачилтын нэгдсэн төв байгуулах" ажил 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар төслийн бодит гүйцэтгэл 78%-ийн явцтай, хугацааны хувьд хоцрогдолтой байгаа нь 2023 онд ...Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 100 хувь...зорилтыг 15.8 хувийг хангаагүй, Нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвөөс 2023.10.02-ны өдрийн албан бичгээр төслийн ажлын гүйцэтгэлийг 89 хувьтай гэж баталгаажуулсан нь техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын нийт ажлын гүйцэтгэл 90 хувьтай, Конвейерийн системийн хөрөнгө оруулалтын ажил 2023 онд Цанхийн баруун уурхайн хөрсний конвейерийн систем нэвтрүүлэлт 43 хувь... хүргэх зорилтыг хангаагүй байна.

1.57 Мөн Төмрийн хүдэр, баяжмалын экспорт"-ийн хэмжээ 2021 онд 7.1 сая.тонн буюу 79.8 хувийн, 2022 онд 4.7 сая.тонн буюу 51.1 хувийн, 2023 онд 5.7 сая.тонн буюу 60 хувийн биелэлттэй байгаа нь зорилтот үр дүнг 2021-2023 онд 20.2-48.9 хувиар хангаагүй байна.

Хүснэгт 8. Экспортын хэмжээ

Хариуцагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	агуулга	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	55.Төмрийн хүдэр, баяжмалын экспорт	Хүрэх түвшин	сая тонн	8.2	8.9	9.2	9.5
		Хүрсэн түвшин			7.1	4.7	5.7
		зөрүү			-1.8	-4.5	-3.8

Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

- 3.2.7.3. "Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна" арга хэмжээний суурь түвшин 75.8%-тэй бөгөөд 2022-2023 онд "Бэрэн групп" ХХК⁶ болон түүний хамаарал бүхий компаниуд нь бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх төлбөрийн чадваргүй, Хөгжлийн банкнаас авсан зээл, өрийн асуудал нь шийдвэрлэгдээгүй шалтгаанаар төслийн ажил зогссон нь "Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгэнэ. 100%"... зорилтот үр дүнг хангаагүй байна.
- "Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна" арга хэмжээний хүрээнд цар тахлын хорио цээр болон төслийн санхүүжилт бүрэн шийдэгдээгүйн улмаас төслийн бүтээн байгуулалт 2020-2023 оны 10 дугаар сар хүртэл зогссон, 2023 онд 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн төхөөрөмжийн захиалга хийгдсэн ба угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа ч "Түүхий эдийн татан авалт, тоног төхөөрөмжийн туршилт тохиргоо хийж, үйлдвэрийг 100% ашиглалтад оруулна" гэсэн зорилтот түвшинд хүрээгүй байна.

1.58 Дээрх байдал нь УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн Эдийн засгийн бодлогын 4.2.11."эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн

⁶ Бэрэн групп" ХХК нь 2014 оноос 200 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх домен зуух-хүчилтөрөгчийн конвертор-цахилгаан нуман зуух-шанаган зуух-тасралтгүй цутгах машин-цувих гэсэн тасралтгүй ажиллагаатай ган үйлдвэрлэлийн циклийг бий болгох зорилгоор Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байсан

бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ” арга хэмжээний үр нөлөө бүрэн хангагдаагүй нь 2025 оны зорилтот үр дүнд хүлээлт үүсгэж байна.

1.59 Улмаар УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2. “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” зорилтын 4.2.14-т “Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна” гэж тусгасан дараах бүтээн байгуулалтын үр дүн хангалтгүйгээс урт хугацааны бодлогын эхний 10 жил буюу 2030 оны үр дүн хангагдаагүй байх нөхцлийг бий болгож байна. Тухайлбал:

- Хүнд үйлдвэрийн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Ган төмөрлөгийн үйлдвэр”, “Алт цэвэршүүлэх үйлдвэр”-ийн бүтээн байгуулалт хангалтгүй,
- Уул уурхайн ордууд болох “Таван толгойн нүүрсний орд”, “Цагаан суваргын орд”, “Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ” 2030 оны үр дүн хангагдаагүй байх үр дагавартай байна.

1.60 “Геологийн зураглалын ажил гүйцэтгэн нутаг дэвсгэрийн гүний тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол”-ийн төслийн хүрээнд 2021 онд 33 төсөл, 2022 онд 33 төсөл, 2023 онд 25 төсөл хэрэгжүүлсэн нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу шинээр эхлэх төслүүд хэрэгжээгүйтэй холбоотой байна. Үүнд:

Хүснэгт 9. Хэрэгжүүлсэн төсөл

Хариуцагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	агуулга	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	57.Геологийн зураглалын ажил гүйцэтгэн нутаг дэвсгэрийн гүний тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол	Хүрэх түвшин	төслийн тоо	33	36	37	37
		Хүрсэн түвшин			33	33	25
		зөрүү			-3	-4	-12

Эх сурвалж: УУХҮЯ-ын салбарын статистик

1.61 Зорилт 3.2.5. “Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна”-ын 3 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- 3.2.5.1. “Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө” арга хэмжээний хүрээнд хэтийн төлөвтэй талбайнуудыг шинээр илрүүлсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, УУХҮЯ/
- 3.2.5.2. “Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө” арга хэмжээний хүрээнд 7 илрэлийг тогтоож, хэтийн төлөв бүхий 13 алтны хүдрийн талбайг ялган хэтийн төлөвийн үнэлгээ өгсөн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, УУХҮЯ/
- 3.2.5.3. “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө” арга хэмжээний хүрээнд Ашигт малтмалын хайгуулын 60-80 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 209 тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанаас 47.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, УУХҮЯ/

1.62 “Экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахууны хэрэглээ”-г 2021 онд 0.5 хувиар, 2022 онд 2 хувиар, 2023 онд 24 хувиар зорилтот үр дүнг хангаагүй нь ОХУ-ын дотоод зах зээл дээр шатахууны хэрэглээ өссөн, дайны нөхцөл байдал, шатахууны экспортын татвар нэмэгдсэн, 2023 оны 09 дүгээр сард ОХУ-ын Засгийн газраас гаргасан Автобензин, дизель түлшний экспортыг түр хориглох шийдвэртэй холбогдуулан Монгол

Улсад нийлүүлэх шатахуун тэр дундаа Евро-5 шатахууны нийлүүлэлт багасаж, иргэдийн худалдан авах чадвар муу, хэрэглээний соёл хэвшээгүй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Евро-5-ын нийлүүлэлт

Хариуцагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	агуулга	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	60.Экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахууны хэрэглээ	Хүрэх түвшин	Хувь	13	15	25	35
		Хүрсэн түвшин			15.5	23	11
		зөрүү			0.5	-2	-24


Эх сурвалж: УУХҮЯ-ны статистик мэдээ

1.63 **Зорилго 3.3.** "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ"-ын 15 зорилтын хүрээнд 15 шалгуур үзүүлэлт бүхий 62 арга хэмжээнээс 26 үр дүнтэй, 29 тодорхой үр дүнд хүрч, 6 эрчимжүүлэх шаардлагатай, 1 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

- "Хүнсний ногооны хангамж"-ийг 2023 онд 87 хувиар хангасан нь зорилтот үр дүнг 17 хувиар өсгөж зорилтот үр дүнг хангасан;
- "Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж"-ийн шалгуур үзүүлэлтийг 2021-2023 онд 30 нэгж байгуулахаар төлөвлөж, "Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ" арга хэмжээний хүрээнд 2021 онд 14, 2022 онд 24, 2023 онд 4 нийт 42 нэгж байгуулж, нийт 300.1(87.7) мянган бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс хээлтүүлгийн бус үед ялган төвлөрүүлсэн;
- 2021-2023 онд шинээр 3600 тун үр авч, 70700 тун үртэй болохоос импортоор шинээр 20340 тун үр авч, 26781 тун үр дотоодод үйлдвэрлэж, нийт 47121 тун үртэй болсон нь суурь түвшин 64.7 мянган тун үр дээр 2022-2023 онд импорт болон дотоодод үйлдвэрлэсэн 47.1 мянган тун үрийг нэмсэнээр нийт 111.8 мянган тун үр /үүнээс 36.1 мянган үрийг зарцуулсан/.
- 2021 онд 9.3 мянган толгой хуц, 8.5 мянган толгой ухна, 2022 онд 12.3 мянган толгой хуц, 8.8 мянган толгой ухна, 2023 онд 13.4 мянган толгой хуц, 9.6 мянган толгой ухна шинээр тавьсан. Нийт 2021-2023 онд нийт 61.8 мянган толгой хуц, ухна шинээр тавьсан байна.

1.64 "Отрын тусгай хэрэгцээний нөөц нутаг" шалгуур үзүүлэлтийг 2023 онд 3.9 сая га байхаар хүрэх түвшинг тогтоосон ба 2023 оны байдлаар 4.7 сая га байгаа нь зорилтод түвшинг хангасан нь 2020-2021 онд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээрийн хил заагийг шинэчлэх, давхардлыг арилгах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн отрын нөөц бэлчээрт зөрчил тогтоогдож, тус аймгийн отрын нөөц бэлчээрийн хэмжээг 995.2 мянган га болгон сумдын ИТХ-ын тогтоолоор шинэчлэн баталсан.

Дүрслэл 12. Тусгай хэрэгцээний отрын бэлчээр



Эх сурвалж: ХХААХҮЯ

1.65 Дээрх байдал нь улсын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн хэмжээ 2021 оны эцэст 1.99 сая га болж буурсан. 2021-2023 онд 7 аймаг /Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл/-т аймгийн болон харьяа сумын ИТХ-ын тогтоолоор сум дундын болон сумын отрын бэлчээрийн талбайг 2.76 сая га талбайгаар нэмэгдүүлснээр өссөн дүнгээр 4.7 га болсон нь зорилтот түвшинг хангасан байна. /үр дүнтэй 100%, ХХААХҮЯ/

1.66 “Мал, амьтны зоонозын халдварт өвчний голомт, тохиолдлын бууралт” шалгуур үзүүлэлтийн галзуу өвчний суурь түвшинг 216 голомт, 284 тохиолдлоор тогтоож 2021-2023 онд хүрэх түвшинг нийт 4 хувиар бууруулахаар төлөвлөсөн ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2023 онд 137 голомт, 204 тохиолдол бүртгэгдсэн нь зорилтод үр дүнд хүрсэн байна.

1.67 Харин “Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ” шалгуур үзүүлэлтийг 2021-2023 онд 280 мянган тонн байхаар төлөвлөсөн ч 119.2 мянган тонн-ыг экспортолсон нь Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин зэргээс шалтгаалан 2020-2022 онд дунджаар 35% буурах шалтгаан болж зорилтот үр дүнд хүрээгүй ба 2021 онд 22.8 мянга, 2022 онд 16, 2023 онд 80.4 мянган тонн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ХХААХҮЯ/


Хүснэгт 11. Мах, махан бүтээгдэхүүний гаалийн мэдээ /мянган тонн/

№	Он	Хонь, ямааны мах	Адууны мах	Үхрийн мах	Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах	Дайвар	Нийт
1	2021	0.5	8	-	13.4	0.9	22.8
2	2022	3.9	6.9	0.1	4.9	0.2	16
3	2023	12.6	32.9	0.2	32.9	1.7	80.3
	Нийт	17	47.8	0.3	51.2	2.8	119.1

Эх сурвалж: ХХААХҮЯ

1.68 “Махны нөөц бүрдүүлсэн хэмжээ” шалгуур үзүүлэлтийг 2021 онд 20 мянга, 2022 онд 20 мянга, 2023 онд 20 мянган тонн байхаар төлөвлөсөн ч зорилтот үр дүнд хүрээгүй нь 3.3.3.1 “Махны нөөц бүрдүүлнэ” арга хэмжээний хүрээнд 2021 онд 10356.5 мянга, 2022 онд 12773.0 мянга, 2023 онд 7932.0 мянга, нийт 31061.5 мянган тонн махны нөөц бүрдүүлсэн ч санхүүжилт арилжааны банкны эх үүсвэр, зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх замаар арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд банкнаас тавьж буй зээлийн шаардлага, нөхцөлийг ААН хангахгүй, оролцоо буурсан зэргээс шалтгаалж байна. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ХХААХҮЯ/

Дүрслэл 13. Махны нөөц




Эх сурвалж: ХХААХҮЯ

1.69 “Сэрүүний улиралд нийлүүлсэн сүү” шалгуур үзүүлэлтийг 2021 онд 20 сая, 2022 онд 22 сая, 2023 онд 25 сая литрийг нийлүүлэхээс 2021 онд 22.5 сая, 2022 онд 19.5 сая, 2023 онд 24.8 сая литрийг нийлүүлсэн нь Төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор 1190 үхэртэй 3 сүүний кластер байгуулж, 2024 оны өвөл, хавар буюу сэрүүний улиралд нийлүүлэх сүүний хэмжээг 15%-иар нэмэгдүүлэхээр төлөвлөж, урт хугацаанд үр дүн гарахаар тооцоолсон байна. /ХХААХҮЯ/

1.70 “Тослог ургамлын дотоодын хангамж, дотоодын үйлдвэрийн хэрэгцээний хангалт”-ын шалгуур үзүүлэлтийг 2021-2023 онд 168 мянган тонн байхаар төлөвлөсөн ч, үр дүнг бүрэн хангаагүй нь 3.3.3.7 “Тослог ургамлын дотоодын хангамж, дотоодын үйлдвэрийн хэрэгцээний хангалт” арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд тосны ургамлын үр шахаж боловсруулах хүчин чадал бүхий бүрэн автомат 1 үйлдвэр Сэлэнгэ аймгийн Баянгол суманд үйл ажиллагаа явуулж ба 2021 онд 46.8 мян.тн, 2022 онд 43.9 мян.тн, 2023 онд 47.9 мян.тн, нийт 138.6 мян.тн тосны ургамал хураан авсан нь цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан тариалалтын талбайг хураан авах ургацын хэмжээ буурч, зорилтод түвшинг хангаагүй байна. /тодорхой үр дүнд хүрсэн 80%, ХХААХҮЯ/

Дүрслэл 14. Тослог ургамал



Эх сурвалж: ХХААХҮЯ

1.71 **Зорилго 3.4.** “Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ”-ийн 9 зорилтын хүрээнд 1 шалгуур үзүүлэлт бүхий 18 арга хэмжээнээс 5 үр дүнтэй, 5 тодорхой үр дүнд хүрч, 6 эрчимжүүлэх шаардлагатай, 2 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

1.72 “Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/” арга хэмжээний хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2022 оны 119 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг⁷ ...“Монголын сансрын судалгаа хөгжүүлэлтийн төв” ТББ нь хамтын ажиллагааны санамж бичгийг Марсын нийгэмлэгтэй 2023 оны 04 сард, АНУ-ын Колорадогийн их сургуультай 2023 оны 09 сард байгуулсан, Марс Нийгэмлэгтэй хамтран 11 дүгээр сарын 26-аас 12 дугаар сарын 9-ний хооронд АНУ-ын Юта мужид байрлах Марсын Цөлийн Судалгааны төвд Альфа хөтөлбөрийн хүрээнд 6 хүний бүрэлдэхүүнтэй баг геологи, инженер, сэтгэл зүй, эрүүл мэнд, ботаникийн даалгавар гүйцэтгэж... тодорхой үр дүнд хүрсэн байна. /үр дүнтэй 70%, ЦХХХЯ/

1.73 Харин 3.4.1 “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх”, 3.4.3.”Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ”, 3.6.1 “Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ” зорилтын дараах арга хэмжээний санхүүжилт шийдвэрлэгдээгүй, бүтээн байгуулалтын ажил эхлээгүй, зохион байгуулалтын удаашралтай зэрэг шалтгаанаар зорилтот үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- 3.4.1.3 “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийг Архангай, Өвөрхангай аймагт хэрэгжүүлнэ” арга хэмжээ нь санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна. /үр дүнгүй 0, БОАЖЯ/
- 3.4.6.4. “Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/” гэсэн арга хэмжээг Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Нэмэхтийн хонгил гэдэг газарт байгуулахаар судалгаа хийсэн ч үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын авах арга хэмжээ удаашралтай байгаагаас MARS-V Академийн бүтээн байгуулалтын ажил эхлээгүй байна. /үр дүнгүй 0, БОАЖЯ/
- 3.4.3-ын 1. Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ гэсэн төсөл арга хэмжээ “Манзушир хийдийн

⁷ 2023.10.13-ны өдөр зохион байгуулж 3 дахь удаагийн хурал


түүхэн дурсгалт цогцолбор, соёл, шашин, аялал жуулчлалын төв” төслийн явц, техник эдийг засгийн үндэслэлийн хүрээнд уг төсөл хэрэгжих боломжтой эсэх дээр санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан байна. Тус цогцолбор байгуулах 40,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөвт тусгах саналаа хүргүүлсэн ч батлагдаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БОАЖЯ/

- 3.6.1.10.10. Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Завхан голын төмөр бетон гүүр. гэсэн арга хэмжээ 2023 онд хүрэх түвшин “Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь”-д хүрээгүй. Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээ удаашралтайгаас шалтгаалан хэрэгжээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БОАЖЯ/

1.74 **Зорилго 3.5.** “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана” зорилгын 7 зорилтын хүрээнд 6 шалгуур үзүүлэлт бүхий 38 арга хэмжээнээс 9 үр дүнтэй, 11 тодорхой үр дүнд хүрч, 11 эрчимжүүлэх шаардлагатай, 7 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:


1.75 “Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал” шалгуур үзүүлэлтийн дагуу 2021 онд 1543.6 МВт, 2022 онд 1553.6 МВт, 2023 онд 1568.9 МВт, 2023 байдлаар 0.9МВт-ээр өсөж зорилтод үр дүнг хангасан нь “Дулааны дөрөвдүгээр цахилгаан” станц, “Эрдэнэтийн ДЦС”-ын суурилагдсан хүчин чадлыг өргөтгөн, “Ховдын Мянгад”-ын 10МВт-ын НЦС, Завханы Алдархаан сумын 5МВт-ын НЦС, Говь-Алтайн Есөнбулагийн 10МВт-ын НЦС тус тус ашиглалтад орж эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадал 1568.9МВт болсон цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдүүлэх төслийн үр дүнд хүрсэн байна. /үр дүнтэй100%, ЭХЯ/

Дүрслэл 15. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал



Эх сурвалж: ЭХЯ

Дүрслэл 16. Импортын эрчим хүчний хэмжээ




Эх сурвалж: ЭХЯ

1.76 “Импортын эрчим хүчний хэмжээ” шалгуур үзүүлэлтийн дагуу 2021 онд 1869 сая кВт.ц, 2022 онд 2141.5 сая кВт.ц, 2023 онд 2420.7 сая кВт.ц-ын импортын эрчим хүчний хэмжээ өссөн нь Тавантолгойн ДЦС, Багануурын ДЦС ашиглалтад ороогүйгээс жил бүр 8-10 хувиар өсөж, хэрэглээний өсөлтийг хангах боломжгүй болж, импортын эрчим хүчний хэмжээ өссөн.

1.77 “Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлын эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 17.6 хувь, 2022 онд 18.1 хувь, 2023 онд 18.9 хувийн гүйцэтгэлтэй нь зорилтот үр дүнгээс 3.4-3.1 хувиар буурсан байна.

Дүрслэл 17. СЭХ-ний суурилагдсан чадлын эзлэх хувь




Эх сурвалж: ЭХЯ

- Дээрх байдалд 2021 онд сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр шинээр ашиглалтад ороогүй, 15МВт-ын салхин цахилгаан станцын салхины хэмжилт, судалгааны ажил удааширснаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд Баянхонгор аймгийн Байдрагийн гол төсөл хэрэгжээгүй нь СЭХ-ний суурилагдсан хүчин чадлын эзлэх хувь зорилтот түвшинд хүрэхгүй байхад нөлөөлсөн байна. 15МВт-ын салхин цахилгаан станцын салхины хэмжилт, судалгааны ажил удааширч, судалгааны үр дүнгээр сонгосон байршлуудад салхины нөөц бага, СЦС барихад үр дүнгүй зорилтод үр дүнг хангаагүй байна. /ЭХЯ/

1.78 “Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн дагуу 2021 онд 99.5 хувь, 2022 онд 99.2 хувь, 2023 онд 99.2 хувийн биелэлттэй нь 2023 байдлаар 3.9 хувиар өсөж зорилтод үр дүнг хангасан 2020 онд 897427 өрх байсан бол 2023 онд 979360 өрх цахилгаан эрчим хүчээр хангагдаж 9.1 хувиар өссөн нь “Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд

Дүрслэл 18. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь



Эх сурвалж: ЭХЯ

холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж”, “Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станц”, “Багийн төвийн цахилгаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний холболт” арга хэмжээний хэрэгжилт, үр дүн нөлөөлсөн байна

1.79 “Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал” зорилгын хүрэх түвшин 2021 онд 2998 Гкал/ц, 2022 онд 3200 Гкал/ц, 2023 онд 3350 Гкал/ц хүчин чадал нэмэгдүүлэхээр тодорхойлж, 2021 онд 3406 Гкал/ц, 2022 онд 3218.5 Гкал/ц, 2023 онд 3724.6 Гкал/ц, 2023 байдлаар 11.2 хувиар өсөж зорилтод үр дүнг хангасан байна.

Дүрслэл 19.



Эх сурвалж: ЭХЯ

1.80 Харин “Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрээс хангах дулааны эрчим хүчний хэмжээ” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 10500 мян.Гкал, 2022 онд 10800 мян.Гкал, 2023 онд 18300 мян.Гкал хүрэх түвшинг тодорхойлж, 2021 онд 10756.6 мян.Гкал, 2022 онд 11543.7 мян.Гкал, 2023 онд 10825.2 мян.Гкал, 2023 байдлаар 4.2 мян.Гкал-аар буурч зорилтод үр дүнг хангаагүй байна.

1.81 Гэтэл 3.5.1. “Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.5.5. “Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно” зорилтын дараах арга хэмжээнд санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолоогүйгээс зорилтот үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- 3.5.1.8. Монгол Улсын эрчим хүчний системд түргэн маневрлах чадвартай турбингенератортой болох зорилгын хүрээнд 50*2 МВт-ын хийн генератор бүхий 100 МВт-ын цахилгаан станцыг ДЦС-2-ыг түшиглэн барьж байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулан 2020 оны 02 дугаар сард ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр гадаадын хөрөнгө оруулагч хэд хэдэн байгууллагад хүсэлт хүргүүлсэн боловч сонирхсон хөрөнгө оруулагч байхгүй. Засгийн газрын 2022 оны 309 дүгээр тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан.
- 3.5.5.1. “Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина” арга хэмжээнд БУА-ыг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй. /үр дүнгүй 0, ЭХЯ/

1.82 Мөн 3.5.1. “Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 13 арга хэмжээний хэрэгжилт зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, уялдаагүйгээр зорилтот үр дүнд хүрээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 61.3%, ЭХЯ/


1.83 **Зорилго 3.6.** “Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна”-ын 11 зорилтын хүрээнд 8 шалгуур үзүүлэлт бүхий 100 арга хэмжээнээс 21 үр дүнтэй, 20 тодорхой үр дүнд хүрч, 31 эрчимжүүлэх шаардлагатай, 28 арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

1.84 Зорилт 3.6.1. “Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ”-ийн хүрээнд дараах 4 төсөлд улсын төсвөөс концессын эргэн төлөлтийг хийж дууссан байна. Үүнд:

- 3.6.1.4.1. "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хүрээнд 2020-2023 оны хооронд нийт 298.5 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгагдаж, ЭЗХЯ-ын албан бичгийг үндэслэн мөн онуудад нийт 297.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг /2020 онд улсын төсвөөс 62.9 тэрбум, 2021 онд 45.0 тэрбум, 2022 онд 93.4 тэрбум төгрөг, 2023 онд 96.1 тэрбум төгрөгийн санхүүжилт/ олгож, концессын эргэн төлөлт дууссан байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 3.6.1.4.2. "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам" Концессын "барих-шилжих" төрлийн төсөлд нийт 218.9 тэрбум төгрөг батлагдсанаас 218.9 тэрбум төгрөгийг /2021 онд 131.4 тэрбум, 2022 онд 87.6 тэрбум төгрөг олгож/ санхүүжүүлж, концессын эргэн төлөлт дууссан байна. /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- 3.6.1.4.3. "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам" төсөлд нийт 237.8 тэрбум төгрөг батлагдаж, 237.8 тэрбум төгрөгийн /2020 онд 130.0 тэрбум, 2021 онд 45.0 тэрбум, 2022 онд 62.8 тэрбум төгрөг/ санхүүжилт олгож концессын эргэн төлөлт дууссан. /үр дүнтэй 100%, Сангийн яам/.
- 3.6.1.4.4. "Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих" төсөлд 2022 оны төсвийн тухай хуульд 1.8 тэрбум төгрөг батлагдаж, төсөлд 1.6 тэрбум төгрөгийг санхүүжилт олгож, концессын эргэн төлөлт дууссан. /үр дүнтэй 100%, Сангийн яам/

1.85 Харин "Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна" зорилгын 8 шалгуур үзүүлэлтээс үр дүн хангаагүй 1, зорилтот үр дүнд хүрсэн 7 байна. Тухайлбал:

1.86 Зорилт 3.6.1 "Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ"-ийн хүрээнд Ховд аймгийн Дөргөн сумын Чоно харайхын голын 36.8 у/м төмөр бетон гүүр, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онги голын 54.8 у/м төмөр бетон гүүр, Говь-Алтай аймгийн Шарга сумын Эвийн голын 32 у/м төмөр бетон гүүр, Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.36 у/м төмөр бетон гүүрийг тус тус 2021 онд 531.8 км, 2022 онд 414.89 км, 2023 онд 841.87 км гүүрийг байнгын ашиглалт хүлээн авч зорилтот үр дүнг хангасан ч дараах арга хэмжээний үр дүн гараагүй байна. Тухайлбал:



Эх сурвалж: ЗТХЯ


- 3.6.2.2 "Онги, Түргэн, Байдраг, Хэрлэн, Ерөө, Орхон, Гичгэнэ, Чигэстэй голуудын нийт 1306.8 урт метр төмөр бетон гүүрэнд их засварын ажлыг хийнэ"-ын "2.2 Увс аймгийн Түргэн сумын Түргэний голын 160.8 у/м төмөр бетон гүүр", "2.3 Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Байдрагийн голын 108 у/м төмөр бетон гүүр", "2.4 Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Усан хоолойн 36 у/м төмөр бетон гүүр", "2.5 Дорнод аймгийн Хэрлэн сумын Хэрлэн голын төмөр бетон гүүрийн их засвар, 264 у/м", "2.6 Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөөгийн голын 192 у/м төмөр бетон гүүр", "2.7 Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүр", "2.8 Архангай аймгийн Тариат сумын Гичгэнийн голын 90 у/м төмөр бетон гүүр" гэсэн арга хэмжээнүүд нь 2021-2023 онд хүрэх түвшинд хүрээгүй, гэсэн арга хэмжээнд 2021-2023 онд хүрэх түвшинд хүрээгүй, санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна. /Үнэлгээ 0-30%, ЗТХЯ/

1.87 "Ашиглалтад оруулах төмөр замын урт" шалгуур үзүүлэлтийн дагуу 2021-2023 онд нийт 681.6 км төмөр замыг ашиглалтад оруулсан нь 6.1.1.1 Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барина", "1.2 Өмнөговь аймгийн

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замыг барина” арга хэмжээний үр дүнд бий болсон байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ЗТХЯ/

Дүрслэл 21.

1.88 “Байнгын ашиглалтад оруулах хатуу хучилттай авто замын хүчин чадал” шалгуур үзүүлэлтийн дагуу 2021 онд 164.48 км, 2022 онд 292.03 км, 2023 онд 318.92 км хатуу хучилттай автозамын ашиглалтад оруулсан ч 2021-2023 онд хүрэх түвшнийг 628.34 км-ээр хангаагүй буюу 2023 оны хэрэгжилт 52.2 хувиар хангаагүй байна.



Эх сурвалж: ЗТХЯ

- Дээрх байдал нь 3.6.1.4 “Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаанбаатар-Дархан, Дархан-Алтанбулаг, Налайх-Баян чиглэлийн авто замыг 4 эгнээтэй болгож, Азийн авто замын сүлжээний АН-4 буюу Цагаан нуур-Улаан байшинт, Өлгий хотыг тойрсон хатуу хучилттай авто замыг барьж дуусган, Мянгааны замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замыг үргэлжлүүлнэ”-ын “4.3 Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ”, “4.4 Налайх- Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ”, “6.1 Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина”, “8.9 Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг МөрөнТариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлнэ”, “8.1 Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замыг барина”, “8.13 Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг барина”, “8.15 Баян-Өлгий аймгийн Өлгий хот-Улаанхус сум-Алтай таван богд уул чиглэлийн 118 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ” гэсэн арга хэмжээнд 2021-2023 онд хүрэх түвшинд хүрээгүй, санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна. /Үнэлгээ 0-30%, ЗТХЯ/

1.89 Зорилго 3.7. ”Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ”-ын 14 зорилтын хүрээнд 7 шалгуур үзүүлэлт бүхий 61 арга хэмжээнээс үр дүнтэй 27, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 25, үр дүнгүй 3 арга хэмжээ байна. Тухайлбал:

1.90 “Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн хувь” шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг 2021 онд 50 хувь, 2022 онд 70 хувь, 2023 онд 90 хувь гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 50 хувь, 2022 онд 90 хувь, 2023 онд 90 хувиар зорилтот үр дүнг хангасан байна.

1.91 “Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдрах нийт өрхийн эзлэх хувь”-ны хүрэх түвшинг 2021 онд 34 хувь, 2022 онд 35 хувь, 2023 онд 36 хувь гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 34 хувь, 2022 онд 34,8 хувь, 2023 онд 36 хувиар зорилтот үр дүнг хангасан байна. Тухайлбал:

- 3.7.9.6 “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд нийт 31 байршлын 88 хэсэгчилсэн талбайд төсөл хэрэгжүүлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 167 блок орон сууцны барилга ашиглалтад оруулсан ба 17,984 өрх орон сууцны инженерийн шугам сүлжээнд холбосон байна.

1.92 “Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо”-ны хүрэх түвшинг 2021 онд 14476, 2022 онд 22476, 2023 онд 30476 гэж тодорхойлж, 2021 онд 13292, 2022 онд 20024, 2023 онд 35707-оор зорилтот үр дүнг хангасан байна.

Хүснэгт 12. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдрах нийт өрхийн эзлэх хувь

Хариуцагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	Агуулга	Хэмжих нэгж	Суурь түвшин	2021 он	2022 он	2023 он
БХБЯ	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдрах нийт өрхийн эзлэх хувь	хүрэх түвшин	Хувь	33.3	34	35	36
		хүрсэн түвшин			33.5	34.8	36
		зөрүү			-0.5	-0.2	0

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.93 “Эдийн засгийн бодлого”-ын 3.7 зорилгын БХБЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн 4 шалгуур үзүүлэлт 2021-2023 онд зорилтот үр дүнг хангаагүй байна. Тухайлбал:

1.94 Зорилго 3.7. “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ”-ын дараах шалгуур үзүүлэлтийн 2021-2023 оны хүрэх түвшин хангаагүй байна.

1.95 “Салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн 1:25000 масштабтай байр зүйн зураг”-ийн хүрэх түвшинг 2021 онд 60 хувь, 2022 онд 70 хувь, 2023 онд 80 хувь гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 45 хувь, 2022 онд 45 хувь, 2023 онд 45 хувиар зорилтот үр дүнг 2021, 2022, 2023 оны төсөвт тусгагдаагүйгээс шалтгаалан хангаагүй байна. Тухайлбал:

- 3.7.2.3 “Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна” арга хэмжээ

1.96 “Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, “Нэг газрын зураг” үйлчилгээний нэвтрүүлэлтийн хувь”-ийн хүрэх түвшинг 2021 онд 60 хувь, 2022 онд 70 хувь, 2023 онд 80 хувь гэж тодорхойлж, 2021 онд 60 хувь, 2022 онд 70 хувь, 2023 онд 70 хувиар зорилтот үр дүнг санхүүжилтийн асуудал шийдээгүйгээс шалтгаалан хангаагүй байна. Тухайлбал:

- 3.7.3.6 “Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ” арга хэмжээ
- 3.7.91 “Шинээр байгуулагдсан үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэр”-ийн хүрэх түвшинг 2021 онд 4, 2022 онд 5, 2023 онд 7 гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 3, 2022 онд 3, 2023 онд 4-өөр зорилтот үр дүнг санхүүжилтийн асуудал шийдээгүйгээс шалтгаалан хангаагүй байна. 3.7.13.2 “Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна” арга хэмжээ

1.97 “Шинээр баригдсан үерийн далан сувгийн урт”-ийн хүрэх түвшинг 2021 онд 473.3 км, 2022 онд 514.1 км, 2023 онд 554.9 км гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 440.5 км, 2022 онд 452.9 км, 2023 онд 485.9 кмээр зорилтот үр дүнг санхүүжилтийн асуудал шийдээгүйгээс шалтгаалан хангаагүй байна.

1.98 Харин “3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна” арга хэмжээний хамтран хэрэгжүүлэх байгууллага хоорондын уялдаагүй, хэрэгжүүлэгч байгууллага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж зорилтот үр дүнд хүрээгүй байна. /үр дүнгүй 20%, БХБЯ, ТӨБЗГ/

1.99 “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд 2021-2023 онд 19,190.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулснаас гадаадын зээл тусламжийн хөрөнгө 53.8 хувийг эзлэж байна.

1.100 Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 6 бодлого, 23 зорилго, 261 зорилтыг хэрэгжүүлэх 1046 арга хэмжээ, 152 шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг тусгаж, 835 арга хэмжээнд нийт 89,262.8 тэрбум төгрөг, 2,000.0 сая ам долларын хөрөнгийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын түншлэлийн байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

1.101 “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021-2023 онд хэрэгжүүлэх явцад “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд 2021-2023 онд нийт 236 арга хэмжээнд 20,263.7 тэрбум төгрөг батлагдаж, мөн онуудад 246 арга хэмжээнд нийт 19,190.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 13. Эдийн засгийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө

№	Эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	160	2,491.1	12.3	168	2,286.5	11.9
2	Гадаадын зээл, тусламж	38	12,619.1	62.3	41	10,316.4	53.8
3	Орон нутгийн төсөв	5	73.7	0.4	5	64.0	0.3
4	Өөрийн хөрөнгө	28	4,929.3	24.3	25	6,407.6	33.4
5	Бусад эх үүсвэр	0	-		3	60.1	0.3
6	ЗГТС	5	150.6	0.7	4	56.1	0.3
	Нийт дүн	236	20,263.7		246	19,190.7	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.102 “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд 2021-2023 онд улсын төсөв, гадаадын зээл тусламж, орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, хандив, ЗГТС-ийн хөрөнгөөс тус тус зарцуулснаас гадаадын зээл тусламжийн хөрөнгө 53.8 хувийг эзлэж байна.

1.103 Эдийн засгийн бодлоготой "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 7 шалгуур үзүүлэлтээс 2021-2023 оны үр дүнгээр 1 шалгуур үзүүлэлтийн үр дүн нь 2025 онд хүрэх зорилтот үр дүнг хангаж 14.3 хувийн хэрэгжилттэй, 6 шалгуур үзүүлэлтийн үр дүн хэрэгжих шатанд буюу 85.7 хувийг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 14. Эдийн засгийн бодлогын үндсэн чиглэлийн хүрсэн түвшин

Бодлогын дугаар	Бодлогын нэр	Зорилгын тоо	Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн Хүрэх түвшин(2025 он) шалгуур үзүүлэлтийн тоо	2021-2023 онд хүрсэн түвшин /тоогоор/	
				хүрсэн	хүрээгүй
Гурав	Эдийн Засгийн бодлого	4	7	1	6
	Нийт дүн	4	7	1	6

Эх сурвалж: УАГ-аас судалгааны нэгтгэл

1.104 Тухайлбал: 3.5 зорилгын 3.5.77. “Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь”-ын хүрэх түвшин 2020-2025 онд 95.5 хувь байхаар тогтоосон, 2023 оны байдлаар 99.2 хувьд хүрснээр таван жилийн үндсэн чиглэлд тусгасан хүрэх үр дүн 3.7 хувиар өсөж хүрэх түвшин хангасан байна” шалгуур үзүүлэлт нь 2025 оны хүрэх үр дүнг хангасан байна.

1.105 Зорилго 3.2 “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ”-ын Засгийн газар, УУХҮЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн 52, 58 дахь шалгуурын үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшин нь “Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн 2025 онд хүрэх түвшний 57.5-92.4 хувийг эзэлж байна. Үүнд:


Хүснэгт 15. Үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлт

Хариуцагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн Хүрэх түвшин (2025 он)	Хүрсэн түвшин /2023 он/	биелэлт
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	52.Уул уурхайн салбарын дотоодын бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	30.5	28.2	92.4
	58. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь	хувь	12	6.9	57.5

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

Дүрслэл 22.

1.106 Харин “Эдийн засгийн бодлого”-ын 3.2 зорилгын 60 дахь шалгуурын үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшин 11 хувьтай гарсан нь 2025 онд 80 хувьд хүргэх түвшнээс 13.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь гадаад хүчин зүйлс нөлөөлжээ.



Эх сурвалж: УАГ

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

1.107 “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан Засаглалын бодлогын 2021-2023 оны хэрэгжилт, үр дүн 74 хувийн биелэлттэй байна. Үүнд:

Хүснэгт 16. Засаглалын бодлого /тоо.хувь/

Бодлогын н дугаар	Бодлогын нэр	Зорилго	Зорилт	Арга хэмжээн ий тоо	Хэрэгжилтийн түвшин /тоогоор/				Бодлогын биелэл, үнэлгээ /хувь/
					Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Дөрөв	Засаглалын бодлого	6	70	275	98	95	65	17	74

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.108 Дээрх 6 бодлогын 70 зорилтын 275 арга хэмжээнээс 98 буюу 35.6 хувь үр дүнтэй, 95 буюу 34.5 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 65 буюу 23.6 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 17 буюу 6.2 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн ба “Засаглалын бодлого”-ын хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн байна.

1.109 Засаглалын бодлогын хүрээнд 46 зорилтын 96 арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

1.110 "Иргэний улсын бүртгэлийн дугаар, тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлэх" арга хэмжээг 2023 онд 20% байхаар хүрэх түвшинг тогтоож, хүрэх түвшинг хангасан ба "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийг 2021 онд баталж, иргэдэд тоон гарын үсэг олгосноор мэдээллийн аюулгүй байдал хангагдах, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээс цахим үйлчилгээ авах, банк санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд:

Зураг 1. Цахим гарын үсэг




- "4.1.1.7. Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлнэ" арга хэмжээний хүрээнд 2023 он байдлаар 965940 иргэнд тоон гарын үсэг, 276344 иргэнд иргэний бүртгэлийн 12 оронтой дугаар бүхий шинэчилсэн иргэний үнэмлэхийг олгосон байна,
- "4.1.1.8. Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн гадаад паспортын бэлдэцэд бичилт хийх үйлдвэрийн бүтцийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт байгуулан үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлнэ" арга хэмжээний хүрээнд 2023 оны байдлаар энгийн гадаад паспортыг 523518 иргэнд, цахим гадаад паспортыг 292901 иргэнд олгосон байна. /үр дүнтэй 100, ХЗДХЯ/

Зураг 2. Шинэчлэгдсэн иргэний үнэмлэх



1.111 "Цахим засаглалын хөгжлийн индекс"-ийг 2023 онд 0.61 байхаар хүрэх түвшинг тогтоосон ба НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд цахим засаглалын судалгааг гаргадаг бөгөөд 2022 оны байдлаар 0.7209 индекс тэй байна. Шинэ технологи, инновацид суурилсан цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж байгаа нь дээрх сайн үр дүн гарахад нөлөөлсөн байна. Тухайлбал: /4.1.3.1, 4.1.3.3/

Дүрслэл 23. Цахим засаглалын хөгжлийн индекс



Эх сурвалж: ЦХХХЯ-ны мэдээлэл

- "4.1.3.1. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ.", "4.1.3.3. Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна." арга хэмжээ /үр дүнтэй 100%, ЦХХХЯ/
- "4.1.2.1. Цахим засаглалын хөгжлийг дэмжсэн хуулийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно." арга хэмжээ /үр дүнтэй 100%, ЗГХЭГ/
- "4.2.2.3. "Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлнэ." арга хэмжээ /үр дүнтэй 100%, Сангийн яам/
- "4.1.4.4 Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болно" арга хэмжээ /үр дүнтэй 100, ШС, УИТ/
- "4.2.5.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмыг шинэчилнэ." арга хэмжээ /үр дүнтэй 100%, ЗГХЭГ/
- "4.2.7.6 "Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна" арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ, ЖҮХ/
- "4.3.2.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилсан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий

- боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах арга хэмжээ авна” арга хэмжээ /үр дүнтэй 100%, ХЗДХЯ/
- “4.3.8.3. Монгол төрийн баримтат аман өв төсөл”-ийг хэрэгжүүлнэ.” арга хэмжээ. /үр дүнтэй 100%, ХЗДХЯ/
- “4.3.18.1. Согтууруулах ундааны эргэлт болон хэрэглээ, архи дан согтуурлаас үүдэлтэй сөрөг үр дагаарыг бууруулах зорилгоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, ХЗДХЯ/
- “4.4.5.1. Хууль зүйн туслалцааны тухай хуулийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, ХЗДХЯ/
- “4.5.6.4. НҮБ-ын мандаттай олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлнэ. НҮБ болон ОУБ-уудын хүрээнд болох томоохон сонгуулиудад Монгол Улс хийгээд Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлснээр олон улсад нэр хүндээ өсгөх, байр сууриа бэхжүүлэх боломж бүрдэнэ” арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ/
- “4.6.1.2. Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох талаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ/
- “4.6.2.2. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд шилжүүлнэ.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ, ҮБХИС/
- “4.6.4.1 Барилга-инженерийн цэргийн удирдах газар, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийн командлалыг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ/
- “4.6.5.6 Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хээрийн холбооны зангилгааны техник хэрэгслийг шинэчлэх, тактикийн түвшний салбарыг холбоожуулна.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, /БХЯ/
- “4.6.6.4 БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулна.” Арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ/.
- “4.6.9.5 Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн БХУА, Номын сангийн барилгын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангана.” арга хэмжээ /үр дүнтэй 100%, БХЯ/

1.112 Тус бодлогын хүрээнд 48 зорилтын хүрээнд 97 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” хүрсэн байна. Тухайлбал:

- “4.1.1.4. Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийг хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд АЕГ-ын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийг гүйцэтгэгч БНСУ-ын “Эл Жи Си Эн Эс Консорциум”-тай 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр гэрээ байгуулсан. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 2023.09.30-ны өдөр дуусах байсныг 2024.12.31-ний өдөр хүртэл сунгасан. Төслийн хүрээнд худалдан авах барааны жагсаалт баталсан ба барилгын засвар үйлчилгээний төлөвлөгөөний дагуу засварын ажлыг эхлүүлсэн. Одоогоор техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байна. Гэрээ хэлэлцээр удааширсан. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ХЗДХЯ/
- “4.1.3.7 Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөн аймгийн төвүүдийг төв (Улаанбаатар хот)-тэй холбосон дэд систем, сүлжээг зохион байгуулна” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 93%, ТЕГ/
- “4.1.4.3 Төрийн байгууллагуудыг холбосон дүрст хурлын нэгдсэн системийг бий болгоно” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ТЕГ/
- “4.1.5.3 “Үндэсний дата төвийн техник, хүчин чадлыг сайжруулна” арга хэмжээний хүрээнд Мэдээллийн технологийн дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг бууруулах, төрийн цахим системүүдийн хэвийн ажиллагааг хангах, цахим үйлчилгээний чанар, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх суурь дэд бүтцийг бий болгох чиглэлээр Төрийн үүлэн тооцоолол (Төрийн клауд)-ын дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр Фибо глобал ХХК-тай хамтран “mCloud” системийг нэвтрүүлсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ЦХХХЯ/,
- “4.1.5.8 Харилцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, барилга байгууламж зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө” арга хэмжээний хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн багтай хамтран “Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зураг төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм”-ийг шинээр боловсруулсан. Газрын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Барилга, хот

байгуулалтын яаманд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1319 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн боловч хуулийн төсөл буцаагдсан. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ЦХХХЯ/

- 4.1.7.5 “Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулна.” арга хэмжээний хүрээнд Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулж, 2023 онд нийт 13090 иргэн хамрагдсан байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ЦХХХЯ/
- “4.3.6.3 Хориодлын биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.” арга хэмжээний хүрээнд байгууллагын онцлогт тохирсон нүүр царай таных телекамер, телехяналтын системийн шийдлийг судалж, “ITZONE” ХХК-тай хамтран БНХАУ-ын MEGVII брендийн нүүр царай таных Megeye-C3S-123 загварын телекамер, Megserver-S1C-L3-L1 загварын өгөгдөл боловсруулах сервер, Megbox-B1F-122 загварын дүрсний хайрцаг суурилуулж, програм хангамжийн систем хөгжүүлэлт /System installation and development/-ийг 407, 421 дүгээр нээлттэй хорих ангиуд болон Үйлдвэр, барилга аж ахуйн хэлтэст тус хүний нүүр царай танин бүртгэх телекамерыг суурилуулан туршиж, дүн шинжилгээ хийсэн. Мөн ШШГЕГ болон харъяа хорих анги /23/-д нүүр царай таных системийг нэвтрүүлэхэд шаардлагатай зардлын тооцоо, судалгааг хийсэн байна. Хөрөнгийн асуудал шийдвэрлэгдвэл тус хорих ангиудад суурилуулахад бэлтгэж байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, ХЗДХЯ/
- 4.3.7.1. “Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.” арга хэмжээний хүрээнд Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2023 онд нийт гадаад улс болон олон улсын байгууллагын шугамаар 134 алба хаагч сургалтад хамрагдсанаас 42 нь цахимаар бусад алба хаагчид биечлэн гадаад улсад сургалтад хамрагдсан байна. Дотоодод зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 397 алба хаагчийг хамруулсан байна. “Койка” олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн хүрээнд лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. / тодорхой үр дүнд хүрсэн 70%, ХЗДХЯ/
- “4.4.10.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.” арга хэмжээний хүрээнд хууль шинэчлэн батлагдаагүй байгаа ч 3 журам шинээр, 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна. /тодорхой үр дүнд хүрсэн 70%, ТӨБЗГ/
- “4.6.4.4 Барилга-инженерийн цэргийн ангийг байгуулах бүтээн байгуулалтын ажил” арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн 90%, БХЯ/
- “4.6.5.2 Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 80%. БХЯ/
- “4.6.6.3 НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд инженерийн рот, тусгай хүчний ротыг бэлтгэж оролцуулна.” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 70%. БХЯ/
- “4.6.7.5 Бага бууны сумны үйлдвэртэй болж, гүйцэтгэн цэнэглэсэн артиллер, пуужингийн сум, галт хэрэгслийг аюулгүй болгох замаар зэвсэг засварын хуримтлалын сан бий болгоно.” арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн 70%, БХЯ/
- “4.6.8.2 Их, дээд сургуулиудад “Цэргийн эрдмийн тэнхим” байгуулахад дэмжлэг үзүүлнэ.” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 70%, БХЯ/
- “4.6.9.6 Цэргийн төв эмнэлгийг орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үргэлжлүүлэн дуусгана.” арга хэмжээ /тодорхой үр дүнд хүрсэн 95%, БХЯ/.

Зураг 3. Оюутан цэрэг



1.113 Харин 6 зорилгын 43 зорилтын 82 арга хэмжээ 70-аас доош хувийн хэрэгжилттэй буюу нийт арга хэмжээний 29.8 хувийг эзэлж байгаа нь санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй, хамтран хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаагүй, үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын ажлын зохион байгуулалт буюу хэрэгжүүлэлтийн талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, газрын асуудал болон бусад шалтгаанаас “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй” хэрэгжсэн байна. Тухайлбал:

1.114 Санхүүжилт:


- 4.1.1.3 “Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулна.” арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу “Буянт-Ухаа спорт цогцолбор”-ын хойд талд “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, “Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийг хийж, Барилгын хөгжлийн төвөөс баталгаажуулан хүлээж авсан бөгөөд санхүүжилтээс шалтгаалж зорилтод түвшинд хүрээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 40%, ХЗДХЯ/
- 4.1.3.4 “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ.” арга хэмжээний хүрээнд Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцооллыг гаргаж, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх” төслийн хэрэгжүүлэхээр тогтсон байна. Уг төслийн хүрээнд “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх” төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Ажлын даалгаварт тоон гарын үсгийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх, цагийн бүртгэлийн системийг шинээр байгуулахад шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмж, хийгдэх ажлын жагсаалтыг тусгасан байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, ЦХХХЯ/
- 4.1.4.5 “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.” арга хэмжээ программ хангамж сайжруулах төлөвлөгөө гаргаж, техник хангамжийн төсвийг батлуулаагүй мэдээллийн санг бий болгох ажлыг шийдвэрлээгүй байна. /үр дүнгүй 0, ТӨБЗГ/
- 4.1.8.1. “Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоол, шийдвэрийн цахим системийн техникийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулах хуулийн зөвлөх үйлчилгээний болон мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2021 онд хүлээн авсан боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас систем хөгжүүлэлт хийгдээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ЗГХЭГ/,
- 4.1.8.2. “Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж, нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд 1956-1990 оны Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн шийдвэр, 1991-2021 оны Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, 2012-2021 оны Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, 2009-2021 он хүртэлх Тэргүүн шадар сайд, Шадар сайдын тушаал, “ЗГ-1”, “ЗГ-2”, “Х” албан бичиг, гадаад албан бичгийг баримтад нягтлан шалгалт хийж, бүртгэлтэй нь тулган, цахим хувь үйлдэж, цахим сан үүсгэсэн боловч санхүүжилт шийдэгдээгүйн улмаас цахим архивын систем хөгжүүлэх ажил хийгдээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ЗГХЭГ/,
- 4.1.8.3 “Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн шийдвэр гаргалтад иргэдээс санал авах цахим хэлэлцүүлгийн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд И-Монголиа, вэб хуудас, аппликейшн болон бусад хэлбэрээр иргэдээс санал авах ажил тодорхой хэмжээнд явагдаж байгаа хэдий ч төлөвлөгөөнд тусгасан тусгайлсан санал авах цахим хэлэлцүүлгийн систем санхүүжилтээс шалтгаалж хийгдээгүй байна. /үр дүнгүй 29, ЗГХЭГ/,
- 4.1.8.4 “Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ” арга хэмжээний хүрээнд санхүүжилтээс шалтгаалж тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлэх ажил хийгдээгүй байна. /үр дүнгүй 0, ЗГХЭГ/
- 4.1.9.2 “Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулна” арга хэмжээний хүрээнд “Мэдээлэл технологийн үндэсний парк ААТУУГ-ыг түшиглэн Мэдээлэл, хандалтын төвийг байгуулахаар шийдвэрлэж, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас засвар үйлчилгээний ажил, холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэн “Мэдээлэл хандалтын төв”-ийг байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Бүсчилсэн контент үйлдвэрлэлийн төв байгуулах санхүүжилтгүйгээс 3 төв байгуулагдаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, ЦХХХЯ/
- 4.3.11.2 “Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдэлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.” арга хэмжээг Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төслүүдийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр холбогдох төслийн зохицуулагч нарт хүсэлт хүргүүлж ажилласан боловч шийдэгдээгүй байна. /үр дүнгүй 0, БОАЖЯ/
- 4.6.2.5 “Цэргийн II шатны эмнэлэг байгуулах бүтээн байгуулалтын ажил” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2015 оны ...дугаар тогтоол, БХС-ын 2015 оны ...дүгээр тушаалаар

- "Цэргийн 2 дугаар шатны эмнэлэг"-ийг /Баян-өлгий аймагт/ байгуулах шийдвэрийг тус тус гаргаж, БХЯ-аас 2020 оны н/138 дугаар албан бичгээр Цэргийн 2 дугаар шатны эмнэлэгийн барилгад 13,402.5 сая, 2021 оны н/197 дугаар албан бичгээр 8,831.2 сая, 2022 оны н/288 дугаар албан бичгээр 14,041.6 сая төгрөгийн төсөвт өртгийн саналыг Сангийн яаманд тус тус хүргүүлсэн ч батлагдаагүй, 2022 онд "II шатны эмнэлгийн барилга ашиглалтад орсон байна" гэсэн зорилтот түвшин хангагдаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БХЯ/
- 4.6.5.4. "Зенитийн пуужингийн цогцолборын 2 дугаар шатны засвар үйлчилгээг хийнэ" арга хэмжээний засвар үйлчилгээг бие дааж хийх боловсон хүчний дутагдалтай, БХЯ-аас 2020 онд дугаар албан бичгээр ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл саналд "УТХО-аар 2021 онд 6,250.0 сая төгрөгийн төсөв шаардлагатай саналыг хүргүүлсэн ч батлагдаагүйгээс арга хэмжээ хэрэгжээгүй, 2022 онд "2 дугаар шатны засвар үйлчилгээ бүрэн хийгдэж, агаарын орон зай хамгаалагдана" хүрэх түвшинд хүрээгүй, агаарын хилийг хамгаалахад эрсдэл үүсэх үр дагавартай байна. /үр дүнгүй 20%, БХЯ/
 - 4.6.5.9. "Удаан хугацааны хадгалалтын зэвсэглэл, цэргийн техникийг сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ засварын ажлыг хэрэгжүүлнэ" арга хэмжээний хүрээнд ЗХЖШ-ын 2021 оны дугаар тушаалаар Удаан хугацааны хадгалалтын хэрэгсэл сэргээн сайжруулах засвар, үйлчилгээ хийсэн ч 2022-2023 онд Сэргээн сайжруулах засвар үйлчилгээний ажилд төсөв тавигдаагүйгээс 2023 оны "Сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ 15 хувьд хийгдэнэ" гэсэн хүрэх түвшин хангаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 33%, БХЯ, ЗХЖШ/
 - 4.6.7.2. "Үндэсний батлан хамгаалахын их сургуульд нэгдсэн лаборатори байгуулна" арга хэмжээний БХЯ-аас 2021 онд⁸ Сангийн яаманд 2022 оны төсвийн төсөлд "Нэгдсэн лабораторийн барилга барих 9,590.8 сая төгрөгийн төсвийн санал"-ыг хүргүүлсэн батлагдаагүйгээс 2023 онд "Лаборатори ашиглалтад орсон байна" гэсэн хүрэх түвшин хангагдаагүй байна. /үр дүнгүй 29%, БХЯ/
 - 4.6.9.3. "Зэвсэгт хүчний төв цэнгэлдэх хүрээлэнг Хужирбулан дахь сургалтын төвийн районд байгуулна. /биеийн тамир спортын төв/" арга хэмжээний хүрээнд өөөрсдийн хүч нөөц бололцоогоор "Удирдлага-хяналтын төв"-ийн байр, "Гар бууны буудлагын хэсэг", "Автомат-пулемётын буудлагын хэсэг", "Цамхагтай буудлагын хэсэг", "Ойрын зайн хурдан буудлагын хэсэг"-ийг засварласан ч төсөвт санал хүргүүлээгүйгээс 2023 онд "Зэвсэгт хүчний төв цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын ажил хийгдсэн байна" гэсэн зорилтот үр дүн хангагдаагүй байна. /үр дүнгүй 20%, БХЯ/

1.115 Зохион байгуулалт, хамтын ажиллагаа, үндсэн хэрэгжүүлэгч тодорхой арга хэмжээ аваагүй:

- "4.1.1.2 "Эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа тодорхой төрлийн хэргийн материалыг цахимжуулна." арга хэмжээний хүрээнд ЦБ-аас ЭХХША-аг хялбаршуулах зорилгоор төрийн үйлчилгээний нэгдсэн "e-Mongolia" системийн "lavlagaa.e-mongolia.mn" системийг шинээр нэвтрүүлж, цагдаагийн эрх бүхий алба хаагч иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 90 төрлийн лавлагаа, мэдээллийг авч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой болсон байна. Албан бичиг солилцооны дундын "docx.gov.mn" системд цагдаагийн "earchive.police.gov" программ хангамжийг холбосноор прокурорын байгууллагатай цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлсэн боловч дээрх программ нь ЭХХША-г цахимжуулсан программ хангамж биш ба лавлагаа, мэдээллийн сангууд байна. ЭХХШТХ-д тодорхой төрлийн хэргийн материалыг цахимжуулах талаар нэмэлт, өөрчлөлт ороогүй гэх шалтгаанаар арга хэмжээ авч ажиллаагүйгээс зорилтод түвшинд хүрээгүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ХЗДХЯ/

Зураг 4. Албан бичиг солилцооны дундын систем docx.gov.mn/



⁸ БХЯ-ны 2021.08.13-ны өдрийн н/197 дугаар албан бичиг

- 4.1.5.1 “Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын хэмжээнд Хөвсгөл аймгийн Ханх, Дорнод аймгийн Дашбалбар, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Баянжаргалан зэрэг 5 сум шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл” -ийн хүрээнд дээрх 5 сум болон Увс аймгийн Тэс сумын Тэс боомт, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Зэлтэр боомт, Дорнод аймгийн Баян-Уул сумын Ульхан зэрэг 3 боомтыг шилэн кабелийн сүлжээнд холбох төсөл хэрэгжихээр баримт бичгийн шатандаа явж байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, ЦХХХЯ/
- 4.1.4.1 “Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно” арга хэмжээ ТӨБЗГ-т хамааралгүй, энэ талаар жил бүрийн тайланд тусган ЗГХХГ-т хүргүүлдэг боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй, арга хэмжээ хэрэгжээгүй байна. /үр дүнгүй 0, ТӨБЗГ/
- 4.2.6.2 “Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим-сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулна” ажлын хүрээнд санхүүжилтийн эх үүсвэргүй, ТЭЗҮ боловсруулагдаагүй, зохион байгуулалт хангалтгүйгээс одоог хүртэл ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. /үр дүнгүй 0, ЗГХЭГ, УА/

1.116 Газрын асуудал:

Зураг 5. Газрын зураг /жишээ/



○ 4.6.2.6. “Баруун бүсэд галт хэрэглэлийн нөөцийн агуулахыг ашиглалтад оруулж, галт хэрэглэлийн нөөцийг шилжүүлэн байрлуулна” арга хэмжээний хүрээнд Завхан аймгийн ИТХ-ын даргын 2023 оны захирамжаар ангийн байрлалын 16,8 га, бүсийн сургалтын төвийн 1915,5 га газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах санал дэмжигдсэн бөгөөд 2023 онд “Галт хэрэглэлийн нөөцийн агуулахын барилгын ажлыг 70 хувьд хүргэнэ” гэсэн зорилтот түвшин хангагдаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БХЯ, ЗХЖШ/

○ 4.6.3.5. “Бүсийн сургалтын төвийг байгуулна” арга хэмжээний хүрээнд Хэнтий аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар тогтоолоор Хэнтий аймгийн сумд 11,2 га талбай, 21637 га талбай олгосон ч Сургалтын төв байгуулах байршил өөрчлөгдсөнөөс 2021-2022 онд “Бүсийн сургалтын төвийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлнэ” хүрэх түвшин, 2023 онд “Зүүн бүсийн сургалтын төвийг байгуулсан байна” гэсэн хүрэх түвшин хангагдаагүй байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БХЯ/

- 4.3.7.3 “Шүүх эмнэлгийн лабораторийн болон Цогцос хадгалах зориулалтын төвийг байгуулан, иммуногистохимийн зэрэг иж бүрэн шинжилгээний лабораторууд, үзлэг шинжилгээний орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын баруун болон зүүн хэсэгт шүүх эмнэлгийн лабораторийн болон Цогцос хадгалах зориулалтын төвийг барьж ашиглалтад оруулах ёстой ч зөвхөн Хан-уул дүүргийн 10 дугаар хороонд баригдах барилгын ТЭЗҮ хийгдэж зөвлөх компанийг шалгаруулан 2023 оны 06 дугаар сард гэрээ байгуулсан байна. Зөвлөх компаний зүгээс газар шаардлага хангахгүй байна гэж үзсэний үндсэн дээр газрын А зөвшөөрлийг дахин гаргуулахаар болж 2024.01 дүгээр сард авсан байна. Тус төслийг БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр болсон байна. Зүүн хэсэгт баригдах барилгын газрын асуудал шийдэгдээгүй байна. /үр дүнгүй 29%, ХЗДХЯ/

1.117 Бусад шалтгаан:

- 4.6.1.1. “Монгол Улсын хууль, тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр туссан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулна” арга хэмжээнд “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 33-36 жагсаалтад 4 хуулийг 2021-2023 онд өргөн мэдүүлэхээр заасан ч 3 хуулийг өргөн мэдүүлээгүй, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ байна. Үүнд:

1. 2021 онд “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах байтал Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 52 хуралдаанаар хэлэлцүүлсэн.

2. 2022 онд "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэх байтал /БХЯ-ны 2023.12.08-ны болон 2024.01.09-ний өдрийн албан бичгээр хуулийн төслийг "Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх" зөвшөөрөл олгох хүсэлтийг холбогдох байгуулагад хүргүүлж, ХЗДХЯ-аас 2023.12.15-ны өдөр, Сангийн яамнаас 2024.01.18-ны өдөр санал хүлээн авсан/ 2024.01.31-ний өдрийн байдлаар хуулийн төслийг Засгийн газарт хүргүүлээгүй байна.

3. 2023 онд "Дайны байдлын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заасан ч уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, салбарын бусад хууль тогтоомжтой уялдуулах, тэдгээрийн нийцлийг хангах тандан судалгаа, шинжилгээний ажлыг 2023 оны 11 сараас эхлэн хэрэгжүүлж байгаа нь гадаад, дотоодын хүчин зүйлсийн нөлөөллөөр УИХ-ын тогтоолд заасан хугацаанд хэрэгжээгүй байна.


- 4.6.4.3. "Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор /UBM/-ыг ашиглалтад оруулж, үйлдвэрлэлийг эхлүүлнэ" арга хэмжээнд Засгийн газрын 2015 оны 462 дугаар⁹, 2016 оны 60 дугаар тогтоолоор БХЯ-ны харьяа "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨҮГ-т ашиглах "барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор"-ын тоног төхөөрөмжийг¹⁰ худалдан авах зорилгоор Хөгжлийн банкнаас 7,055,255 ам.долларын зээлийг ТОСК ТӨХХК-ийн нэрээр гаргах шийдвэрийг гаргаж, Загийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор Барилгын хийц үйлдвэрлэх, хөдөлгөөнт цогцолбор UBM-ыг худалдан авахад зориулж Хөгжлийн банкнаас авсан зээл, зээлийн хүүгийн төлбөр болон холбогдох бусад зардал болон нийт 10,399,688.0 ам.доллар 153.1 сая төгрөгийг улсын төсөвт тусгахыг Сангийн сайдад, Барилгын хийц үйлдвэрлэх, хөдөлгөөнт цогцолбор UBM-ыг БХЯ-ны балансад шилжүүлэн тусгах арга хэмжээ авахыг БХС,ТӨБЗГ-т даалгасан ч аль аль нь шийдвэрлэгдээгүй, зорилтод түвшинг хангаагүй байна. /үр дүнгүй 0, БХЯ/

1.118 Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолын хавсралт 2-оор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд "Засаглалын бодлого"-ын 6 зорилгын 30 шалгуур үзүүлэлтээс 15 шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хүрсэн, 15 шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хүрээгүй нь гадны байгууллагаас тухайн шалгуур үзүүлэлтүүд гардаг ба 2022, 2023 оны үзүүлэлт гараагүй байгаатай холбоотой байна. Тухайлбал:

1.119 Зорилго 4.2." Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно"-ын:

Дүрслэл 24. ДБ-ны засаглалын үзүүлэлт

- 4.2.101. "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын хяналт", 4.2.102. "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө", 4.2.103. "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Зохицуулалтын чанар", 4.2.104. "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал", 4.2.105. "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба харууцлага" арга хэмжээний үзүүлэлтүүд 2022 оны байдлаар хүрэх түвшинд хүрээгүй байна. Тус үзүүлэлтүүдийг Дэлхийн банкнаас гаргадаг бөгөөд 2023 оны үзүүлэлт гараагүй байна.



Эх сурвалж: УАГ

⁹ Засгийн газрын 2015 оны 462 дугаар тогтоолоор БХЯ-ны харьяа "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨҮГ-ын худалдан авахаар шийдвэрлэсэн

¹⁰ Тоног төхөөрөмжийн үндсэн үнийн 85% болох 7,055,255 ам. долларыг хөгжлийн банкны 8 хувийн хүүтэй зээлийн санхүүжилтээр, үлдсэн 15% болох 1,245,045 ам. долларыг тус байгууллагын өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн.

1.120 Зорилго 4.3.”Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана”-ын 4 шалгуур үзүүлэлтээс 2 үр дүнд хүрч, 2 үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:


- 4.3.109. “Даяаршлын үзүүлэлт”-ийг 2023 онд индекс 59 байхаар хүрэх түвшинг тогтоосон ба Швейцарийн эдийн засгийн хүрээлэнгээс үзүүлэлтийг гаргадаг, 2021 оны байдлаар 61.3 индекстэй байна.
- 4.3.112. “Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 9.4, 2022 онд 9.2, 2023 онд 9 болгож бууруулахаар төлөвлөж “Яараад яахав дээ”, “Нэг зам-нэг соёл” зэрэг аяныг хэрэгжүүлсэн ба 2021 онд 7.1, 2022 онд 8.2, 2023 онд 8.1 байгаа нь зорилтот түвшинг хангасан байна. /ХЗДХЯ/

1.121 Зорилго 4.5. “Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ” зорилгын 6 шалгуураас 4 үр дүнд хүрч, 2 үр дүнг хангаагүй байна.

- 4.5.114 “Дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээ”-г 2021-2023 онд 72 удаа зохион байгуулахаар төлөвлөж, тайлант онуудад 106-г зохион байгуулсан байна. Ингэснээр гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлэх, хөгжлийн гадаад таатай орчин бүрдэх үр нөлөөтэй байна. /ГХЯ/

- 4.5.117 “Салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ЗГ хоорондын комиссын хуралдаан, ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалтын тоо”-г 2021-2023 онд 101 удаа зохион байгуулахаар төлөвлөсөн ч, тайлант онуудад 93-г зохион байгуулсан байна. Ковид-19 цар тахалтай холбоотой 2021 онд хуралдаан, уулзалт багасаж 2023 онд өссөн үзүүлэлттэй байна. /ГХЯ/

Дүрслэл 25. Салбар хоорондын зөвлөлдөх уулзалтын



Эх сурвалж: УАГ

1.122 Зорилго 4.6.”Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ”-ын 6 шалгуураас 3 үр дүнд хүрч, 3 үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- 4.6.123.”Улсын агаарын хилийн хяналтад технологийн шинэчлэлт хийж, системийн чадавхыг нэмэгдүүлсэн хувь” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2023 онд 3 хувиар зорилтот үр дүнг хангаагүй тус яамнаас 2023 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн ч батлагдаагүй, арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна. /БХЯ/
- 4.6.121.”Кибер аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг шинэчилж, анги, байгууллагын сүлжээний аюулгүй байдал хангагдсан хувь” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 10, 2022 онд 30, 2023 онд 50 хувьд хүрсэн зорилтот үр дүнг хангасан байна. /БХЯ/
- 4.6.122.”Тусгай хүчний цэрэг орчин үеийн зэвсэглэл, техник, хэрэгслээр хангагдах хувь” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 24.2, 2022 онд 37.8, 2023 онд 47.6 хувьд хүрсэн зорилтот үр дүнг хангасан байна. /БХЯ/
- 4.6.124.”Зэвсэгт хүчний анги, байгууллагыг холбоо, мэдээллийн суурь сүлжээ, өндөр хурдны өргөн зурвасын тоон техник, технологид шилжүүлсэн хувь” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2021 онд 20, 2022 онд 30, 2023 онд 40 хувьд хүрсэн зорилтот үр дүнг хангасан байна. /БХЯ/
- 4.5.125.”Оюутан цэрэг цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоо” 2022-2023 онд 1933 суралцагч хамрагдаж хүрсэн зорилтот үр дүнг хангасан байна. /БХЯ/

1.123 Харин Монгол Улсыг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэлд “Засаглалын бодлого”-ын 4 зорилгын 9 шалгуур үзүүлэлт тусгагдсан бөгөөд 2 нь хүрэх дүнг хангасан, 7 нь хэрэгжих шатанд буюу зорилтот түвшин хангагдаагүй байна.

1.124 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан “Засаглалын бодлого”-ын хүрээнд 676.7 тэрбум төгрөгийг төлөвлөж, 762.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 17. Засаглалын бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө /сая.төг/

№	эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	213	436.5	64.5	180	274.6	36.0
2	Гадаадын зээл, тусламж	18	121.3	17.9	21	247.9	32.5
3	Орон нутгийн төсөв	2	1.8	0.3	1	1.8	0.2
4	Өөрийн хөрөнгө	-	-	-	1	3.1	0.4
6	Хандив	-	-	-	3	104.5	13.7
7	ЗГТС	8	117.1	17.3	12	130.5	17.1
Нийт дүн		241	676.7		218	762.5	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.125 Ногоон хөгжлийн бодлогын 2021-2023 оны хэрэгжилт 67 хувьтай, зорилтот үр дүнд хүрээгүй байна.

1.126 Ногоон хөгжлийн бодлогын нийт 12 зорилтын хүрээнд 34 төсөл арга хэмжээнээс 13 буюу 38.2 хувь нь үр дүнтэй, 8 буюу 23.5 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 7 буюу 20.6 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 6 буюу 17.6 хувь нь үр дүнгүй хэрэгжсэн ба ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

1.127 Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 8-н зорилтын хүрээнд 13 арга хэмжээг “үр дүнтэй” хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл 26.



Эх сурвалж: БОАЖЯ

1.128 Тус бодлогын 5.1.1. “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авна” зорилтын хүрээнд “Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж”-ыг 2021 онд 11 мкг/м³, 2022 онд арга хэмжээний 9 мкг/м³, 2023 онд 5 мкг/м³-аар бууруулж 2023 онд хүрэх түвшнийг хангасан нь Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн (2025) хүрэх түвшинд хүрэх эерэг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 18. Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж

Шалгуур үзүүлэлт	Агуулга	2021 он	2022 он	2023 он
Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж (мкг/м ³ буурах үзүүлэлтээр)	Хүрэх түвшин	115	107	101
	Хүрсэн түвшин	89	88	82
	Эерэг үзүүлэлт	26	19	19

Эх сурвалж: УАГ

Тухайлбал:

- Зорилт 5.1.5 “Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” -ын хүрээнд туссан “5.1.5.1 Зориудаар ойжуулах, байгалийн сэргээн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлын үр дүн, чанарыг сайжруулж, мод тарьж ургуулахад мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн арга хэмжээг 2021-2023 онд нийт 19308 мянган га талбайд ойн нөхөн сэргээх ажил хийгдсэн байна. /үр дүнтэй 100%, БОАЖЯ/
- 5.1.5.4 “Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээ 2021-2023 онд 4 төслийн хүрээнд нийт 30 орчим га талбайд хамгаалалтын зурвас байгуулж, нийт 210 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгааллын арга хэмжээг зохион байгуулсан байна. /үр дүнтэй 100%, БОАЖЯ/

1.129 “Ногоон хөгжлийн бодлого”-ын зорилго 5.1 “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”-ын 6 шалгуур үзүүлэлт 2021-2023 оны зорилтод хүрэх түвшин хангагдсан байна.


1.130 Тус бодлогын хүрээнд 6-н зорилтын 8 арга хэмжээг “тодорхой үр дүнд хүрсэн” хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Зорилт 5.1.2 “Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна”-ын хүрээнд туссан “5.1.2.1 Хөвсгөл нуурын ёроолын судалгаа хийж, бохирдлын эрсдэлийг бууруулна” арга хэмжээний 2021-2023 онд хүрэх түвшин “Нуурын гүний зураглал, судалгааны хүрээнд нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын гүйцэтгэлийг 60-аас доошгүй хувиар хэрэгжүүлсэн байна”-д Хөвсгөл нуураас татан гаргасан “Сүхбаатар” хөлөг онгоц, 7 нэгж техник хэрэгслээс 34.7 тн бохир шатахуун, тос тосолгооны материал, Сүхбаатар хөлөг онгоцны ёроол хэсгээс 13 тн бохир, нийт 47.7 бохир шатахуун, тос тосолгооны материалыг гаргаж холбогдох дүрэм, зааврын дагуу устгах ажлыг зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, БОАЖЯ/
- Дээрх зорилтын “5.1.7.1 Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбоно” арга хэмжээний 2021-2023 онд хүрэх түвшин “Газрын доорх усны хяналт-шинжилгээний 20 цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан, сүлжээнд холбож, байнгын ажиллагааг хангасан байна”-д 2021-2023 онд улсын хэмжээнд 39 цооног 325 цэг сүлжээнд холбож тодорхой үр дүнд хүрсэн байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, БОАЖЯ/

1.131 Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 4-н зорилтын 7 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 3-н зорилтын 6 арга хэмжээ “үр дүнгүй” хэрэгжүүлсэн нь санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй, хамтран хэрэгжүүлэх байгууллагууд ажлын уялдаагүй, эргэх холбоогүй байдал, үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын ажлын зохион байгуулалт буюу хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй зэргээс шалтгаалсан нь дараах байдалтай байна.

Дүрслэл 27.


1.132 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 2021 онд 22%, 2022 онд 23%, 2023 онд 24%-д хүрсэн байх шалгуурыг хангаагүй, Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн хүрэх түвшин (2025 он)-г хангахад 77.8 хувийн хүлээлттэй байна.



Эх сурвалж: УАГ

- 5.1.128 “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь” зорилгын 2021 онд 22, 2022 онд 23, 2023 онд 24 хувиар өссөн байхаар хүрэх түвшин тодорхойлсон нь 2021 онд 21 хувь, 2022 онд 21 хувь, 2023 онд 21 хувьд байгаа нь зорилтод түвшин хангаагүй, хурал, хэлэлцээр хойшилсон, ... хилийн цэс батлагдаагүй зэрэг шалтгаантай
- 5.1.129 “Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь” зорилгын 2021 онд 50, 2022 онд 51, 2023 онд 52 хувиар өссөн байхаар хүрэх түвшин тодорхойлсон нь 2021 онд 50 хувь, 2022 онд 50 хувь, 2023 онд 50 хувьд байгаа нь зорилтод түвшин хангаагүй байна.
- 5.1.131 “Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь” зорилгын 2021 онд 15, 2022 онд 17, 2023 онд 19 хувиар өссөн байхаар хүрэх түвшин тодорхойлсон нь 2021 онд 17.2 хувь, 2022 онд 16.6 хувь, 2023 онд 17.3 хувьд байгаа нь зорилтод түвшин хангаагүй нь 2021 онд төсөв батлагдаагүй, 2022 онд 550.0 сая.төг-ийн төсөв батлагдсан нь судалгааны ажлыг 17% хүртэл, 2023 онд 300.0 сая.төг-ийн төсөв батлагдсан, судалгааны ажлыг 19% хүртэл талбайд хийж гүйцэтгэхэд төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар хүрэх түвшин хангаагүй байна.
- 5.1.132 “Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь” зорилгын 2021 онд 82.6, 2022 онд 83, 2023 онд 83.5 хувиар өссөн байхаар хүрэх түвшин тодорхойлсон нь 2021 онд 82.2 хувь, 2022 онд 82.1 хувь, 2023 онд 82.2 хувьтай байгаа нь зорилтод түвшин хангаагүй нь төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар хүрэх түвшин хангаагүй байна.

Дүрслэл 28.



1.133 Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь 2021 онд хүрэх түвшнийг 1%, 2022 оны хүрэх түвшнийг 2%, 2023 оны хүрэх түвшнийг 3%-иар хангаагүй нь Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн хүрэх түвшин (2025 он)-г хангахад 91%-ийн хүлээлттэй байна. Үүнд:

Эх сурвалж: БОАЖЯ

- 5.1.6.1 “Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, өргөжүүлнэ” арга хэмжээний 2021-2023 онд “Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авч, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд хүргэсэн байна” хүрэх түвшинд хүрээгүй нь ЗГ хуралдаан хойшлогдсон болон хэрэгжүүлэгч байгууллага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна. /үр дүнгүй 0%, БОАЖЯ/
- “5.1.11.2 Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” арга хэмжээний 2021-2023 онд хүрэх түвшин “Хэрлэн, Онги усан цогцолбор төслийн боомтын барилга усралтын ажлыг 50 хувьд хүргэсэн байна”-нд хүрээгүй, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй байна. /үр дүнгүй 0%, БОАЖЯ/
- “5.1.12.5 Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц байгуулна” арга хэмжээний 2021-2023 онд хүрэх түвшин “Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймагт радарын станц байгуулж, цаг агаарын аюулт үзэгдлийн эрсдэлээс хамгаалах чадавхыг нэмэгдүүлсэн байна”-д хүрээгүй, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймагт радарын станц байгуулахад шаардлагатай 17.7 тэрбум төгрөгийн зардлыг 2022, 2023 оны Монгол Улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч батлагдаагүй байна. /үр дүнгүй 0%, БОАЖЯ/

1.134 Зорилго 5.1 “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”-ын 8 шалгуур үзүүлэлтийн 2021-2023 оны хүрэх түвшин хангаагүй байна.

1.135 Төрийн байгууллагуудын уялдаа хангалтгүй

Зорилт 5.1.12 “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна”-ын 5.1.12.1 “Уур амьсгалын өөрчлөлтийн харилцааг зохицуулах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” арга хэмжээг БОАЖЯ, ХЗДХЯ хамтран хэрэгжүүлэхээр туссан бөгөөд БОАЖЯ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж дууссан ч ХЗДХЯ хамтран ажиллаж арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

1.136 Мөн “5.1.12.2 Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана” гэсэн арга хэмжээг БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ-д хамтран хэрэгжүүлэхээр туссан. Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Уур амьсгалын үндэсний хорооны 2021 оны 01/21 дүгээр тогтоолоор баталсан боловч арга хэмжээний хүрэх түвшинг хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх талаар дээрх байгууллагууд уялдаагүй ажилласан байна.

1.137 “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд “Ногоон хөгжлийн бодлого”-ын тэргүүлэх зорилт 5.1 “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”-ын хүрээнд төрийн байгууллагууд хариуцан хэрэгжүүлэх 14 шалгуур үзүүлэлт туссан байна.

1.138 Үүнээс зорилтот түвшинд хүрсэн 6 буюу 42.9 хувь, 8 буюу 57.1 хувь нь хүрэх түвшинд хүрээгүй байна.

Хүснэгт 19. Шалгуур үзүүлэлтийн арга хэмжээний биелэлт

Зорилгын нэр	Шалгуурын тоо	Хүрсэн түвшин /тоогоор/		Хүрсэн түвшин /хувиар/	
		Хүрсэн	Хүрээгүй	Хүрсэн	Хүрээгүй
Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ	9	4	5	44.4	55.6
	2	1	1	50	50
	1	-	1	-	100
	1	1	-	100	-
	1		1	-	100
Нийт болон дундаж хувь	14	6	8	42.9	57.1

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.139 Ногоон хөгжлийн бодлоготой "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний 14 шалгуур үзүүлэлтээс 2021-2023 оны үр дүнгээр 1 шалгуур үзүүлэлтийн үр дүн нь 2025 онд хүрэх зорилтот үр дүнг хангаж, 13 шалгуур үзүүлэлтийн үр дүн хэрэгжих шатанд буюу 92.8 хувийг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 20. Ногоон хөгжлийн бодлогын үндсэн чиглэлийн хүрсэн түвшин

Бодлогын дугаар	Бодлогын нэр	Зорилгын тоо	Монгол Улсын 2020-2025 оны Үндсэн чиглэлийн Хүрэх түвшин(2025 он) шалгуур үзүүлэлтийн тоо	2021-2023 онд хүрсэн түвшин /тоогоор/	
				хүрсэн	Хүрээгүй
Гурав	Ногоон хөгжлийн бодлого	1	14	1	13
	Нийт дүн	1	14	1	13

Эх сурвалж: УАГ-аас судалгааны нэгтгэл

1.140 “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд 85.1 тэрбум төгрөгийг төлөвлөж, 69.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 21. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө

№	эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	7	43.0	50.5	7	39.6	57.4
2	Гадаадын зээл, тусламж	2	0.2	0.2	2	0.3	0.5
3	Орон нутгийн төсөв	5	41.9	49.2	5	29.1	42.1
Нийт дүн		15	85.1		14	69.0	

Эх үүсвэр: УАГ-ын судалгааны нэгтгэл

ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.141 “Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого”-ын 2 зорилго, 27 зорилтын 45 арга хэмжээнээс үр дүнтэй 16 буюу 35.6 хувь, тодорхой үр дүнд хүрсэн 15 буюу 33.3 хувь, эрчимжүүлэх шаардлагатай 13 буюу 28.9 хувь, үр дүнгүй 1 буюу 2.2 хувиар хэрэгжиж, бодлогын нийт хэрэгжилт 73 хувьтай байна.

Хүснэгт 22. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	Зорилго	арга хэмжээний тоо	"үр дүнтэй" /100%/	"тодорхой үр дүнд хүрсэн" /70-99%/	"эрчимжүүлэх шаардлагатай" /30-69%/	"үр дүнгүй" /0-29%/
			Тоогоор			
	6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	29	12	12	4	1
	6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	16	4	3	9	0
	Нийт дүн	45	16	15	13	1

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.142 Үр дүнтэй хэрэгжсэн арга хэмжээнүүд:

- 6.1.9.2 “Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд төсөл бүрэн хэрэгжиж дууссан байна. /үр дүнтэй 100%, БХБЯ/
- 6.1.3.1 “Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ /Гадна инженерийн шугам сүлжээ/” арга хэмжээний хүрээнд Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 17984 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ ашиглалтад орсон байна. /үр дүнтэй 100%, НЗДТГ/
- 6.1.4.2 “Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангахад тээвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлнэ.”арга хэмжээний хүрээнд Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2021-2023 онд нийслэлийн гэр хорооллын 596675 айл өрхийг сайжруулсан түлшээр хангасан байна. /үр дүнтэй 100%, НЗДТГ/
- 6.2.6.1. “Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан сумдад өнгөрсөн оны ОНХС-ийн санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний “урамшуулал” олгоно. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийг боловсруулж, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг сайжруулна” арга хэмжээний хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилан

олгодог урамшууллыг тооцохдоо 2016-2019 онд өмнөх онд сумдад хуваарилагдсан ОНХС-ийн 25%-иар бодож дараа жилийн төсөвт оруулан олгодог байсан ба 2020 оноос урамшууллын интервалтай болсон. /үр дүнтэй 100%.Сангийн яам/

1.143 Тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээнүүд:

- 6.1.10.2 “Улаанбаатар хотын шинэ цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглалтад оруулна.” арга хэмжээний хүрээнд Төслийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл 100%, бараа материалын татан авалт 42%, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 40%, төслийн технологийн 35 байгууламжаас 19 барилга байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85%-тай байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, БХБЯ/
- 6.1.10.3 “Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах төслийг хэрэгжүүлнэ” арга хэмжээний хүрээнд Инженер геологийн судалгаа 100%, үйлдвэрийн шав тавих ёслолыг 2023.08.25-нд хийсэн. Үйлдвэрийн техникийн зураг төслийг 2022.09.19-нд хүлээн авсан; Хаягдал ус дахин боловсруулах төслийн ТЭЦ-3, 4-ийн даралттай шугамын ажлын зураг төслийг боловсруулж, ТЭЦ-3, 4-т тоног төхөөрөмж угсрах ажлууд эхэлсэн байна. / тодорхой үр дүнд хүрсэн 70%, БХБЯ/
- 6.1.3.2 “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлнэ.” арга хэмжээний хүрээнд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 1305 айлын орон сууц ашиглалтад орсон байна. /тодорхой үр дүнд хүрсэн 87%, НЗДТГ/
- 6.1.5.1 “Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.” Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 422 автобусаар парк шинэчлэлт хийгдсэн бөгөөд 2023 онд нийлүүлэгдсэн 314 автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нам шал, тавцан, гишгүүр, зориулалтын зорчих хэсэг болон дотор талын зорчих хэсгийн зарлан мэдээлэх, урсдаг лед дэлгэцийг суурилуулан ашиглаж байна. /тодорхой үр дүнд хүрсэн 90%, НЗДТГ/

1.144 “Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ” зорилго, “Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ” зорилгын нийт 11 зорилтын 13 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- 6.1.5.2 “Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ” арга хэмжээний хүрээнд Метро барих төсөл: Монгол Улсын Засгийн газраас Нийслэл Улаанбаатар хотод 2024-2028 онд багтаан Энхтайваны өргөн чөлөөг хамруулсан хөндлөн чиглэлд 17,7 км урт метро барьж байгуулахыг дэмжиж, 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 46 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/1336 дугаар захирамжаар метроны техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлан, боловсруулалтын ажлыг эхлүүлээд байна. /эрчимжүүлэх шаардлагатай 30%, НЗДТГ/;
- 6.1.13.1 “Сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжлүүлнэ” арга хэмжээ. /эрчимжүүлэх шаардлагатай 35%, НЗДТГ/
- 6.2.2.2 “Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БХБЯ/
- 6.2.2.3 “Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангана” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БХБЯ/
- 6.2.7.2 “Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна” арга хэмжээний хүрээнд 2023.12.04-ний байдлаар Төслийн 2023 оны барилга угсралтын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй, нийт төслийн ажлын гүйцэтгэл 50,9 хувьтай. /эрчимжүүлэх шаардлагатай 50%, БХБЯ/
- 6.2.11.1 “Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна.” арга хэмжээ /эрчимжүүлэх шаардлагатай 30%, БХБЯ/

1.145 Дээрх бодлогын зорилго, зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж, зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжүүлснээр дараах үр нөлөө гарах боломжтой байна. Үүнд:

- 6.2.2.2 “Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана” арга хэмжээний хүрээнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр аймгуудад баригдаж буй барилга байгууламжийн чанарт тавих хяналт сайжрана. /БХБЯ/
- 6.2.7.2 “Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.” арга хэмжээний хүрээнд Төслийн барилга угсралтын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр сумын төвийн иргэдийн амьдрах нөхцөл дээшлэнэ. /БХБЯ/
- 6.1.5.2 “Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ.” арга хэмжээний хүрээнд Метро барих төсөлд шаардлагатай байгаа санхүүжилтийг шийдвэрлэснээр төслийн үр нөлөө нэмэгдэж, Улаанбаатар хотын авто замын түгжрэл буурч, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл нэмэгдэнэ. /НЗДТГ/
- 6.1.13.1 “Сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжлүүлнэ” арга хэмжээний хүрээнд Сургуулийн автобусны парк шинэчлэлтэд шаардлагатай байгаа санхүүжилтийг шийдвэрлэснээр авто замын түгжрэл буурах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй байдалд эерэг нөлөөтэй /эрчимжүүлэх шаардлагатай 35, НЗДТГ/

1.146 Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын 45 арга хэмжээнд 13 арга хэмжээнд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлж 2021-2023 оны хооронд 7 шалгуур үзүүлэлт буюу 51.4 хувь нь үр дүнд хүрч, 6 шалгуур үзүүлэлт буюу 48.6 хувь нь зорилтот үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

Хүснэгт 23. Нийслэл ба бүс нутгийн хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлт

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан			Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
Бодлогын нэр	Зорилгын нэр	Шалгуурын тоо	Хүрсэн түвшин /тоогоор/		Хүрсэн түвшин /хувиар/	
			хүрсэн	хүрээгүй	хүрсэн	хүрээгүй
1	2	3	5	6	7	8
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.	9	5	4	55.6	44.4
	6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1	1	0	100	0
		2	1	1	50	50
		1	0	1	0	100
Нийт дүн		13	7	6	51.4	48.6

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

1.147 Нийт 13 шалгуур үзүүлэлтээс арга хэмжээний санхүүжилт шийдэгдээгүй, зохион байгуулалт удааширсан зэргээс шалтгаалан БХБЯ-ны хариуцан хэрэгжүүлж буй 1, НЗДТГ-ын хариуцан хэрэгжүүлсэн 5 шалгуур үзүүлэлт нь зорилтот үр дүнг хангаагүй байна.

1.148 Зорилго 6.1. “Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ”-ын НЗДТГ-ын хариуцсан хүрэх түвшин хангагдаагүй шалгуур үзүүлэлт:

- 6.1.141 “Хотын хөгжлийн үзүүлэлт”-ийн хүрэх түвшинг 2021 онд 0,517 индекс, 2022 онд 0,544 индекс, 2023 онд 0,558 индекс гэж тодорхойлж, 2021 онд 0,517 индекс, 2022 онд 0,557 индекс, 2023 онд 0,479 индекс буюу хүрэх түвшингээс 0,065-аар буурсан байна.
- 6.1.142 “ Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц”-ийн хүрэх түвшин 2021 онд 2475 орон сууц, 2022 онд 2475 орон сууц, 2023 онд 5000 орон сууц гэж тодорхойлж, 2021 онд 0 орон сууц, 2022 онд 2164 орон сууц, 2023 онд 1313 орон сууц

буюу хүрэх түвшингээ хангаагүй байгаа нь барилгын материалын үнэ өссөнөөс шалтгаалсан байна.

- 6.1.143 "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц"-ийн хүрэх түвшин 2021 онд 300 орон сууц, 2022 онд 600 орон сууц, 2023 онд 600 орон сууц гэж тодорхойлж, 2021 онд 387 орон сууц, 2022 онд 611 орон сууц, 2023 онд 307 орон сууц буюу хүрэх түвшингээ хангаагүй байгаа нь барилгын материалын үнэ өссөнөөс шалтгаалсан байна.
- 6.1.144 "Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын төслөөр баригдсан орон сууцны тоо"-ийн хүрэх түвшин 2022 онд 500, 2023 онд 2500 орон сууц гэж тодорхойлж, 2022 онд 0, 2023 онд 0 буюу хүрэх түвшингээ хангаагүй байгаа нь инженерийн шугам сүлжээ баригдаж дуусаагүйгээс шалтгаалсан байна.

1.149 Зорилго 6.2. "Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ"-ын БХБЯ-ны хариуцсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин хангагдаагүй байна.

- 6.2.152 "Хот, суурин газрын нийтийн халуун усны төвийг шинэчлэх, шинээр барьсан тоо"-ийн хүрэх түвшин 2021 онд 642, 2022 онд 652, 2023 онд 662 гэж тодорхойлж, 2021 онд 641, 2022 онд 656, 2023 онд 662 буюу суурь түвшингээс нэмэгдээгүй байгаа нь хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлээгүйгээс шалтгаалсан байна.
- 6.2.151 "Сумын хөгжил" арга хэмжээнд хамрагдсан сумд"-ийн хүрэх түвшин 2021 онд 45, 2022 онд 63, 2023 онд 81 гэж тодорхойлсон бөгөөд НЗДТГ нь Нийслэлийн нутаг дэвсгэрийн хүрээнд тус зорилтыг хангах боломжгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

1.150 Зорилго 6.1-ийн НЗДТГ-ын хариуцан хэрэгжүүлсэн 5 шалгуурын хүрсэн түвшин нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнг хангасан байна.

- 6.1.140 "Бүтээн байгуулалт хийсэн дэд төвийн тоо"-ны хүрэх түвшинг 2021 онд 2 дэд төв, 2023 онд 4 дэд төв гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 4 дэд төв, 2023 онд 4 дэд төвөөр хүрэх түвшинг хангасан байна.
- 6.1.145 "Сайжруулсан түлшээр хангасан өрхийн тоо"-ны хүрэх түвшинг 2021 онд 197000 өрхийн тоо, 2022 онд 187000 өрхийн тоо, 2023 онд 177000 өрхийн тоо гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 197000 өрхийн тоо 2022 онд 195992 өрхийн тоо, 2023 онд 203683 өрхийн тоогоор хүрэх түвшинг хангасан байна.
- 6.1.146 "Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглолтой шинээр нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо"-ны хүрэх түвшинг 2021 онд 80 автобус, 2022 онд 70 автобус, 2023 онд 90 автобус гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 35 автобус 2022 онд 73 автобус, 2023 онд 879 автобусаар хүрэх түвшинг хангасан байна.
- 6.1.147 "Шинээр нэмж барих дугуйн замын урт"-ны хүрэх түвшинг 2021 онд 10 км, 2022 онд 18 км, 2023 онд 18 км гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 19,5 км 2022 онд 20,4 км, 2023 онд 38 кмээр хүрэх түвшинг хангасан байна.
- 6.1.148 "Цэцэрлэгт хүрээлэнгийн тоо"-ны хүрэх түвшинг 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд 1 гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд 16 цэцэрлэгт хүрээлэнгээр хүрэх түвшинг хангасан байна.

1.151 Харин НЗДТГ-ын хариуцан хэрэгжүүлсэн 4 шалгуурын хүрсэн түвшин нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнг хангаагүй байна. Үүнд:

- 6.1.141 "Хотын хөгжлийн үзүүлэлт"-ны хүрэх түвшинг 2021 онд 0,517, 2022 онд 0,531, 2023 онд 0,544 гэж тодорхойлж, мөн онуудад 2022 онд 0,5571, 2023 онд 0,479 индекстэй гарч хүрэх түвшинг бүрэн хангаагүй байна.
- 6.1.142 "Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц"-ны хүрэх түвшинг 2021 онд 2475, 2022 онд 2475, 2023 онд 5000 гэж тодорхойлж, мөн онуудад 2022 онд 2164, 2023 онд 1313 орон сууцны тоогоор гарч хүрэх түвшинг бүрэн хангаагүй байна.
- 6.1.143 "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдсан орон сууц"-ны хүрэх түвшинг

2021 онд 300, 2022 онд 600, 2023 онд 600 гэж тодорхойлж, мөн онуудад 2021 онд 387, 2022 онд 611, 2023 онд 307 орон сууцны тоогоор гарч хүрэх түвшинг бүрэн хангаагүй байна.

- 6.1.144 “Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын төслөөр баригдсан орон сууцны тоо”-ны хүрэх түвшинг 2022 онд 500, 2023 онд 2500 гэж тодорхойлж, мөн онуудад 2022 онд 0, 2023 онд 0 орон сууцны тоогоор гарч хүрэх түвшинг хангаагүй байна.

1.152 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4, 7, 8, 9 дахь заалтуудыг баримтлан, батлагдсан хавсралт маягтын дагуу хүрсэн түвшин, үр дүнг тайлагнадаг байна.

1.153 “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын 6.1, 6.2. зорилгын хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн 10 арга хэмжээнээс 1 арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг аудитад ирүүлсэн нотлох баримтын дүнгээс 40%-иар зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал:

- 6.2.11.1 “Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 30 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 20%, БХБЯ/

1.154 Мөн “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын 6.1. зорилгын хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн 24 арга хэмжээнээс 10 арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг аудитад ирүүлсэн нотлох баримтын дүнгээс 10-65%-иар зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал:

- 6.1.3.4 “Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. /Гадна инженерийн шугам сүлжээ болон орон сууц” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 70 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 30%, НЗДТГ/
- 6.1.3.5 “Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж, төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 90 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 10%, НЗДТГ/
- 6.1.5.2 “Цахилгаан соронзон тээврийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 30 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 20%, НЗДТГ/
- 6.1.5.3 “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлнэ.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 30 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 15%, НЗДТГ/
- 6.1.11.1 “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 70 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 30%, НЗДТГ/
- 6.1.13.1 “Сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжлүүлнэ.” арга хэмжээ нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 35 хувийн хэрэгжилттэй байна. /зөрүү 65%, НЗДТГ/

1.155 Тус бодлогын хүрээнд 2021-2023 онд 3,108.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр баталж, 2,583.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 24. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгө

№	эх үүсвэрийн нэр	2021-2023 онд батлагдсан хөрөнгө			2021-2023 онд санхүүжүүлсэн хөрөнгө		
		арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь	арга хэмжээний тоо	мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	эх үүсвэрт эзлэх хувь
1	Улсын төсөв	13	1,514.5	48.7	15	1,367.3	52.9
2	Гадаадын зээл, тусламж	15	583.5	18.8	6	451.3	17.5
3	Орон нутгийн төсөв	17	1,010.4	32.5	17	765.2	29.6

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

5	Бусад эх үүсвэр	2	0.09				-
	Нийт дүн	47	3,108.5		38	2,583.8	

Эх сурвалж: УАГ-ын судалгааны нэгтгэл

БҮЛЭГ 2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРСЭН ТҮВШНИЙ ҮНЭН, ЗӨВ ЭСЭХИЙГ НЯГТЛАН ШАЛГААГҮЙ, НОТЛОХ БАРИМТАД ҮНДЭСЛЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

“Шилэн дансны хөтлөлтийн нэгдсэн үнэлгээ”-ний тайланг Сангийн яамнаас гаргасан байна

2.1 Төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.1¹¹-т заасны дагуу “шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ”-г тайлагнахаар журамласан ч 2021-2022 онд ЗГХЭГ-т хүргүүлээгүй, харин Сангийн яаманд 6 байгууллага нь шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний дүнг цаасаар хүргүүлж, 7 байгууллага “Шилэн дансны нэгдсэн” цахим системд тайлагнаж, 1 байгууллага шилэн данс хөтлөлтийн үнэлгээг гаргаагүй байна. Үүнд:

2.2 НЗДТГ, УУХҮЯ, БХЯ, БШУЯ, ЭХЯ, ЭЗХЯ, ХНХЯ -аас “Шилэн дансны нэгдсэн” системд шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг цахимаар тайлагнасан. ТӨБЗГ-аас шилэн данс хөтлөлтийн үнэлгээ хийгээгүй байна.

2.3 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайланг дараах байгууллагууд Сангийн яаманд цаасаар хүргүүлсэн байна. Үүнд:

- Соёлын яамнаас 2022.01.24-ний өдрийн 3/161 тоот албан бичгээр Сангийн яаманд “Шилэн дансны үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын тайланг хүргүүлсэн,
- БОАЯЖ-аас шилэн дансны мэдээлэлд хяналт хийсэн тайланг 2024.01.25-ны өдрийн 03/444 албан тоотгоор Сангийн яаманд хүргүүлсэн.
- ЗТХЯ-аас 2023 оны шилэн дансны цахим санд оруулах мэдээлэл, тайланг Сангийн яаманд 2024.01.25 10/361 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.
- БХБЯ -аас 2022 оны байгууллагын нэгдсэн тайланд шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайланг оруулан тайлагнасан байна.
- ЦХХХЯ нь 2022 оны байгууллагын нэгдсэн тайланд шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайланг оруулан тайлагнасан.

2.4 Харин Сангийн яамнаас 2020, 2021, 2022 оны үйл ажиллагааны үр дүнд шилэн дансны хөтлөлтийн нэгдсэн үнэлгээг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.8¹² дахь заалтын дагуу гарсан байна. Үүнд:

Хүснэгт 25. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

№	Төсвийн Ерөнхийлөн захирагч	Харьяа байгууллагын тоо			Шилэн данс хөтлөлтийн үнэлгээний хувь		
		2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он	2023 он
1	БОАЖЯ	95	98	93	95.4%	94.4%	97.2%
2	БХБЯ	33	34	33	90.2%	91.5%	94.7%
3	БХЯ	86	91	90	96.7%	92.6%	97.5%
4	БШУЯ	165	164	2176	91.6%	95.9%	92.1%
5	Соёлын яам	23	25	49	92.0%	97.2%	96.4%
6	ГХЯ	46	53	53	94.2%	92.3%	97.4%
7	ЗТХЯ	94	90	96	91.9%	92.7%	89.1%

¹¹ 9.1 Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг энэ журмын 6, 7 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мөн журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ. Тайлан нь дараахь хавсралттай байна: 9.1.1. төрийн захиргааны төв байгууллага: 9.1.1.4. шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;

¹² 9.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ. Уг үнэлгээ нь захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэг үзүүлэлт болно. (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

8	СЯ	77	79	83	97.4%	100.0%	99.9%
9	УУХҮЯ	22	26	29	90.2%	95.7%	93.9%
10	ХНХЯ	233	236	199	90.0%	89.8%	88.3%
11	ХЗДХЯ	225	277	227	95.3%	95.2%	96.3%
12	ХХААХҮЯ	73	63	67	93.1%	94.7%	90.3%
13	ЭМЯ	179	175	172	90.1%	91.2%	91.1%
14	ЭХЯ	51	46	48	91.8%	100.0%	97.3%
15	ЗГХЭГ	24	23	17	95.7%	92.8%	91.5%
16	ЭЗХЯ			1			95.9%
17	ЦХХХЯ			9			99.0%
		1426	1480	3442			

Эх сурвалж: Сангийн яамны үнэлгээний тайлан

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг бодитой тайлагнаагүй, арга хэмжээний хэрэгжилтийг баримт нотолгоонд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ дүгнэлтийг гаргаж хэвшээгүй байна

2.5 Засгийн газраас Төрийн мэдээллийн сүлжээ www.unelgee.gov.mn цахим программыг ашиглаж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ үнэлгээ, дүгнэлтийг үндсэн хариуцагч байгууллага, Засгийн газрын түвшинд нэгтгэн тайлагнаж байна.

2.6 Гэтэл Хүний хөгжлийн бодлогын 2.5.14. “Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.” зорилтын 2.5.14.1, мөн 2.5.15. “Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно” зорилтын 2.5.15.1 дэх арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тайлагнасан нь тухайн арга хэмжээний хүрсэн түвшинтэй хамааралгүй байна. /ХНХЯ/

2.7 Эдийн засгийн бодлогын 3.1.3. “Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно” зорилтын 3.1.3.1 дэх арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй асуудлыг тайлагнасан байна. Тухайлбал:

- 3.1.3.1. “Банкны тухай хууль, Төвбанкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг хууль, тогтоомж холбогдох журамд өөрчлөлт оруулна” арга хэмжээний 2020 онд эдийн засгийн өсөлтийг -4.6%, Төсвийн алдагдал ДНБ-ий -12.0% байсан бөгөөд 2021 оны төсвийн бодлогоор эдийн засгийн өсөлтийг 5.0%, Төсвийн алдагдлыг -5.1%-р тооцсон нь Эрдэс бүтээгдэхүүний үнэ өндөр, Төсвийн багц арга хэмжээ 2.4 их наяд, эдийн засгийг хагас нээж, 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн салбарын зардал нэмэгдэж, хүүхдийн мөнгө 100.000₮ болж хэрэгжүүлсэн... гэж тайлагнасан нь тухайн арга хэмжээний хүрсэн түвшинтэй огт хамааралгүй. /Сангийн яам/

2.8 Харин Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.6, 3.1.8, 3.1.13, 3.1.18, 4.1.4 дэх зорилтын дараах арга хэмжээний үндсэн хариуцагчийг “Сангийн яам”, “ТӨБЗГ” гэж баталсан байхад байгууллагын чиг үүрэгт хамааралгүй гэсэн үндэслэлээр Сангийн яам, ТӨБЗГ-ын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай гэж цахим системд тайлагнасан ч хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн нь бодитой бус байна. Үүнд:

- 3.1.6.1. “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулна” /Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай байна. Хамааралгүй. 100 хувь/

- 3.1.8.1. "Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ" /Сангийн яамны хариуцан биелүүлэх арга хэмжээнээс хасуулах саналыг дахин хүргүүлж байна.-Хамааралгүй, 100 хувь/
- 3.1.13.5. "Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг бий болгож, хүн амын хүнсний болон аюулгүй байдалд сөрөг нөлөөт зар сурталчилгааг таслан зогсоох, хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлнэ"./хамааралгүй, 100 хувь/
- 3.1.13.6. "Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF) нэвтрүүлнэ." / Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй, 100 хувь/
- 3.1.18.1 "Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна" арга хэмжээ
- 4.1.4.1. "Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно" арга хэмжээг үндсэн хариуцагч ТӨБЗГ-аас Засгийн газраас Төрийн мэдээллийн сүлжээ www.unelgee.gov.mn цахим системд тайлагнаагүй, "хугацаа болоогүй" гэсэн тайлбарыг оруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг гаргаагүй байна. /ТӨБЗГ/

2.9 Гэтэл "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд нэмэлт өөрчлөлт ороогүй, үндсэн хариуцагч байгууллага өөрчлөгдсөн зохицуулалтыг хийгдээгүй байхад 3.1.6.1, 3.1.8.1, 3.1.13.5, 3.1.13.6 дахь арга хэмжээг **"байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй", "хугацаа болоогүй"** гэсэн тайлбарыг оруулж ЗГХХГ-аас хяналт-шинжилгээ үнэлгээг хийгээгүй нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5.2¹³-ын 5.2.3 "хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах" гэсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.10 "Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого"-ын 6.2.11 зорилтын хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн 1 арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг нотлох баримтад үндэслэж дүгнээгүй байна. Тухайлбал:

- 6.2.11.1 "Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна" арга хэмжээний хүрээнд хүрэх түвшинг 2021 онд 6 аймгийн 6 сумын төв, 2022 онд 6 аймгийн 16 сумын төв, 2023 онд 6 аймгийн 6 сумын төвийг нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний төвтэй болгоно гэж тодорхойлсоноос 2021-2023 онд Булган, аймгийн 2 сум, Увс аймгийн 2 сум, Хөвсгөл аймгийн 3 сум, нийт 8 ажлыг эхлүүлж, 2 ажил дууссан байгааг 50 хувийн хэрэгжилттэй гэж үндэслэлгүй дүгнэсэн байна. /БХБЯ/

2.11 "Эдийн засгийн бодлого"-ын дараах арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг нотлох баримтад үндэслэж дүгнээгүй байна. Тухайлбал:

- 3.7.2.3 "Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна" арга хэмжээний хүрээнд хүрэх түвшинг 2021 онд 1914 хуудас байр зүйн зураг хийнэ, 2022 онд 3000 хуудас байр зүйн зураг хийнэ, 2023 онд 3000 хуудас байр зүйн зураг хийнэ гэж тодорхойлсоноос 2021-2023 онд 1:25000 масштабтай байр зүйн зураг зохиох ажлын даалгаврын төслийг боловсруулж Үндэсний Геологийн албанд хүргүүлснийг 50 хувийн хэрэгжилттэй гэж үндэслэлгүй дүгнэсэн байна./БХБЯ/
- 3.7.2.2 "Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана" арга хэмжээний хүрээнд хүрэх түвшинг 2022 онд 5 станцыг шинээр байгуулна, 2023 онд 10 станцыг шинээр байгуулна гэж тодорхойлсоноос 2021-2023 онд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийсэн бөгөөд станцуудыг байгуулаагүй байхад 30 хувийн хэрэгжилттэй гэж үндэслэлгүй дүгнэсэн байна. /БХБЯ/

¹³ 5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь дараах үүрэгтэй байна

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн нотлох баримтын 76.2 хувийг “Төрийн мэдээллийн нэгдсэн цахим сан”-д байршуулаагүй, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлтийг нотолгоонд үндэслэж гаргаагүй байна

2.12 ЗГХЭГ-аас “Төрийн мэдээллийн нэгдсэн систем”-д 2021-2022 онд дараах арга хэмжээг урьдчилан байршуулаагүйгээс үндсэн хариуцагч Шадар сайдын харьяа байгууллагууд арга хэмжээний хэрэгжилт, холбогдох нотлох баримтыг уг системд байршуулаагүй, тухайн хариуцагч байгууллага болон дээд шатны /Засгийн газар/ байгууллагаас 2023 онд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна. Үүнд:

- 3.1.19.1. “Замын-Үүд” чөлөөт бүсэд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулна;
- 3.3.12.4. Олон улсын жишигт нийцсэн тохирлын үнэлгээний мэргэжсэн байгууллагуудыг бий болгоно;
- 3.3.12.5. Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үр дүнг төрийн захиргааны болон холбогдох байгууллагууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэрэглэхэд дэмжлэг үзүүлнэ;
- 3.7.14.1.2 “Замын-Үүд” чөлөөт бүсийг нээж байнгын ажиллагаанд оруулна;
- 3.7.14.3. Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулна;
- 4.1.4.4. Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болно.

2.13 ЭХЯ болон ЗГХХГ-ын холбогдох ажилтан Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын 4.4¹⁴, 5.2.4¹⁵ дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Үүнд:

- “3.5.1.5. “Төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ” гэсэн зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЭХЯ-аас баталгаажуулж, ЗГХЭГ-т 2022.11.30-ны өдрийн а/4568, 2022.11.18-ны өдрийн ХЭГ/2814 албан тоотод хариу 2023.12.28-ны өдрийн в/4333 тоот албан бичгээр дээрх арга хэмжээг тусган хүргүүлсэн ч ЗГХХГ нь тус арга хэмжээг 2021-2023 онд /www.unelgee.gov.mn/-д байршуулаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

2.14 Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-гөөр баталсан 1046 арга хэмжээнээс “Төрийн мэдээллийн цахим систем”-д 783 арга хэмжээний нотлох баримтыг байршуулаагүйгээс “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.2.3-т “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах” гэсэн нөхцөл бүрдээгүй байна.

¹⁴ Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.

¹⁵ Тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах.



Эх сурвалж:

2.15 Тухайлбал: Төрийн мэдээллийн нэгдсэн системд дараах байгууллагууд нь хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний нотлох баримтыг байршуулаагүй байна. Үүнд:

- БХЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн нийт 50 арга хэмжээнээс 35 арга хэмжээ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан мэдээлэл бөгөөд 2021-2022 онд Төрийн мэдээллийн цахим системд илт тайлагнах 15 арга хэмжээний нотлох баримтаас 2023 онд 2 арга хэмжээний нотлох баримтыг бүрэн, 4 арга хэмжээний нотлох баримтыг дутуу, 9 арга хэмжээний нотлох баримтыг огт байршуулаагүй байна.
- Сангийн яамнаас 2021-2023 он тус бүр хариуцан хэрэгжүүлсэн нийт 57 арга хэмжээний нотлох баримт;
- УУХУЯ-аас 2021-2023 он тус бүр хариуцан хэрэгжүүлсэн нийт 72 арга хэмжээний нотлох баримт;
- БХБЯ нь 2021 онд 7 арга хэмжээний нотлох баримтыг Төрийн мэдээллийн нэгдсэн системд байршуулаагүй, 2022 онд 26 арга хэмжээний нотлох баримтыг Төрийн мэдээллийн нэгдсэн системд байршуулаагүй, 2023 онд 52 арга хэмжээний нотлох баримт;
- ЦХХХЯ нь 2021 онд нийт 29 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг цахим системд оруулахдаа нотлох баримтыг огт байршуулаагүй, 2022 онд 25 арга хэмжээний нотлох баримтыг, 2023 онд 12 арга хэмжээний нотлох баримт;
- БОАЖЯ 2021 онд 50 ТАХ-нээс 23, 2022 онд 49 ТАХ-ээс 8, 2023 онд 51 ТАХ-ээс 20 нотлох баримт;
- ЗТХЯ 2021 онд 55 ТАХ, 2022 онд 80 ТАХ, 2023 онд 95 ТАХ-нд нотлох баримт;
- ТӨБЗГ 2021 онд 11 ТАХ, 2022 онд 12 ТАХ, 2023 онд 12 ТАХ-нд нотлох баримт;
- ЗТХЯ-наас 2021-2023 он тус бүр хариуцан хэрэгжүүлсэн нийт 230 арга хэмжээний нотлох баримт;
- ТӨБЗГ-аас 2021-2023 он тус бүр хариуцан хэрэгжүүлсэн нийт 35 арга хэмжээний нотлох баримт.

Засгийн газраас хөтөлбөрийн биелэлтийг нотлох баримтад үндэслэж гаргаагүй, хүрсэн түвшний мэдээллийн үнэн, зөв эсэхийг бодитоор нягтлан шалгаагүй, үе шаттайгаар цогт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, арга хэмжээний үр дүн зорилтоо хангахад чиглэгдсэн эсэхийг нэгтгэн дүгнээгүй байна

2.16 “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан 6 бодлого, 23 зорилго, 261 зорилтын хүрээнд 2021-2023 онд хэрэгжүүлэх 1046 арга хэмжээний 2021, 2022 оны биелэлтийг ЗГХЭГ-аас, 2023 оны биелэлтийг ЗГХХГ-аас тус тус гаргасан байна.

2.17 Гэтэл ЗГХЭГ болон ЗГХХГ-аас Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021, 2022, 2023 он тус бүрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээний үнэлгээ,

дүгнэлтийг гаргахдаа хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн хариуцагч байгууллагаас “Төрийн мэдээллийн цахим систем”-д тайлагнасан тайланд үндэслэн журмын 5.2.3-т “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах”, 5.2.4-т “тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах” гэсэн үүргээ хэрэгжүүлэхгүйгээр бодитой бус хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байна. Тухайлбал:

- Мөн ЗГХХГ-аас УУХҮЯ, ТЕГ-аас арга хэмжээний нотлох баримтыг “Төрийн мэдээллийн цахим систем”-д огт байршуулаагүй байхад тухайн арга хэмжээний хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээг гаргасан нь нотлох баримтаар бүрэн дэмжигдэхгүй байна.
- ЦХХХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ зөвхөн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тайлагнасан тайланд үндэслэн дүгнэсэн
- НЗДТГ-ын Засгийн газрын хөтөлбөрийн арга хэмжээний тайланг хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тайлагнасан тайланд үндэслэн дүгнэсэн ба хэрэгжүүлээгүй арга хэмжээг тайлагнасан байхад Засгийн газраас хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ нотлох баримтад үндэслээгүй байна.

2.18 Харин Шадар сайдын ажлын албанаас Эдийн засгийн бодлогын 3.1.14, 3.1.17, 3.7.14, 4.1.1, 4.3.13 зорилтын 10 арга хэмжээний хэрэгжилтийг “Төрийн мэдээллийн цахим систем”-д “МУШС-ын эрхлэх асуудлын хүрээнд тухайн арга хэмжээ хамааралгүй байх тул холбогдох салбар, байгууллагад шилжүүлэх саналтай байна” болон “Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал МУШС бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн тул уг арга хэмжээний биелэлтийг ЭЗХЯ-аас гаргуулах саналтай байна” гэж оруулж 2023 онд Шадар сайдын ажлын алба, ЗГХХГ-аас дараах арга хэмжээнд **“хугацаа болоогүй”** гэсэн тайлбараар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна. Үүнд:

- 3.1.14.5. “Хил гаалийн шалган нэвтрүүлэх цогцолборын барилгын ажлыг хийлгэнэ”
- 3.1.17.1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн дохиолол хамгаалалтын нэгдсэн системийн ажлыг суурилуулж, дуусгана.
- 3.1.17.2. “Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийг өргөтгөнө (Сэлэнгэ, Алтанбулаг) (Батлагдсан зураг төсөвтэй)
- 3.1.17.3. “Алтанбулаг” чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно
- 3.1.17.4. “Алтанбулаг” чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно
- 3.1.17.5. Худалдаа, тээвэр логистик, гаалийн хяналтын талбай барьж байгуулна
- 3.1.17.6. Цахилгаан хангамжийг нэмэгдүүлнэ (Цахилгаан шугам, сүлжээ шинээр татах)
- 3.1.17.7. Цэвэр бохир усны байгууламжийн, ерөнхий шугамын зураг төсөв, бүтээн байгуулалтын ажил.
- 3.1.17.8. “Бүсийн төвлөрсөн уурын зуухны зураг төсөв, нэгдсэн халаалтын шугамын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил.
- 3.2.7.8. “Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Салбар лаборатори байгуулна./
- 3.7.14.1.1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.
- 3.7.14.2. “Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулна.

2.19 Ногоон хөгжлийн бодлогын 5.1.12. “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна” зорилтын 5.1.12.1 дэх арга хэмжээг 2021, 2022 онд 50% үнэлсэн, 2023 онд хугацаа болоогүй гэж нь бодит бус үнэлсэн байна. Үүнд:

- 5.1.12.1 арга хэмжээний үндсэн хариуцагч байгууллагаар БОАЖЯ, ХЗДХЯ-ыг баталсан ба ХЗДХЯ-ны 2021 оны жилийн эцсийн тайлагналаар “Тус асуудлаар эрхлэх асуудлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хариуцан боловсруулах бөгөөд одоогийн байдлаар тус яамнаас хуулийн төслийг боловсруулан ирүүлээгүй байна.” гэж тайлагнасан байхад 50%,

2022 оны жилийн эцсийн тайлагналаар “Уур амьсгалын өөрчлөлтийн харилцааг зохицуулах асуудал нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бөгөөд одоогоор тус яамнаас санал ирүүлээгүй байна.” гэж тайлагнасан байхад хэрэгжилтийг 50%-иар үнэлсэн нь бодитой бус байна. Мөн 2023 оны жилийн эцсийн тайлангаар “Уур амьсгалын өөрчлөлтийн харилцааг зохицуулах асуудал нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бөгөөд одоогоор тус яамнаас санал ирүүлээгүй болно.” гэж тайлагнасан буюу зорилгод түвшинг хангаагүй байхад “хугацаа болоогүй” гэсэн тайлбарыг оруулж хяналт-шинжилгээ үнэлгээг хийгээгүй нь журмын 5.2.3 “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах” гэсэн үүргээ хэрэгжүүлээгүй, арга хэмжээний үнэлгээг хийгээгүй байна.

2.20 ЗГХХГ-аас Төрийн мэдээллийн цахим систем”-д тайлагнасан тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг гаргаж байгаа нь журмын 7.2¹⁶-ын 7.2.1-д “мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх”, 7.2.2-т “зорилтын биелэлтийн дүнг үнэлэх”, 7.2.3-т “биелэлтийн үр нөлөөг үнэлэх”, 7.2.4-т “гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх”, 7.2.5-д “төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх”, 7.2.6-д “биелэлтийн түвшинг үнэлэх”, 7.2.7-т “бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах” гэсэн үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ гэсэн зарчмыг баримтлаагүй, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн нь зорилтоо хангахад чиглэгдсэн эсэхэд нотолгоонд суурилан нягтлан шалгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, нэгтгэн дүгнээгүй байна.

¹⁶ 7.2. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

Дүгнэлт: Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бодлого, 23 зорилго, 261 зорилт бүхий 1046 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилтэд аудит хийхэд хөтөлбөрт оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, арга хэмжээнд шаардлагатай төсөв хөрөнгө нь батлагдаагүйгээс тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, хөтөлбөрийн биелэлт **70.5 хувьтай** байна.
2. Дээрх 6 бодлогын 2021-2023 оны хэрэгжилтийг авч үзэхэд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого **83**, Хүний хөгжлийн бодлого **67**, Эдийн засгийн бодлого **59**, Засаглалын бодлого **74**, Ногоон хөгжлийн бодлого **67**, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого **73 хувийн** биелэлттэй байна.
3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021-2023 онд Улсын төсөв, гадаадын зээл тусламж, Засгийн газрын тусгай сан, хувийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж зэрэг санхүүгийн эх үүсвэрээр 835 арга хэмжээг нийт 89,262.8 тэрбум төгрөг шаардлагатай гэж төлөвлөснөөс мөн онуудад 728 арга хэмжээнд нийт 34,803.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан ч эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээ 396 буюу 37.9 хувийг эзэлж байна.
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгийн хэрэгжилтийн нотлох баримтыг Засгийн газрын Төрийн мэдээллийн нэгдсэн цахим системд оруулж хэвшээгүй, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд үндэслэдэг, нотлох баримтад тулгуурлан нягтлан шалгахгүйгээр шат шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтийг гаргаж байгаа нь хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг бодитой үнэлж дүгнэх үндэслэл болж чадаагүй, хяналтын тогтолцоо сул байна.
5. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллага, түүний дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч газар нь хөтөлбөрийн үр дүнд бий болсон бүтээн байгуулалт, түүнд зарцуулсан хөрөнгийг нэгтгэн тайлагнаагүй байна.
6. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 154 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 61 шалгуур үзүүлэлт уялдаж хэрэгжсэнээс 2021-2023 оны үр дүнгээр 17 шалгуур үзүүлэлтийн үр дүн нь хангагдаж 27.9 хувийн хэрэгжилттэй байна.
7. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад босоо болон хэвтээ тогтолцоондоо төрийн захиргааны төв байгууллага хамтарч ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс зарим зорилт, арга хэмжээ зорилтот үр дүнд хүрээгүй байна.

ЗӨВЛӨМЖ: Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.
Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танаа:

1. Цаашид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулахдаа оролцогч талуудын чиг үүрэгт нь нийцүүлэн харилцан уялдаатай хамтран ажиллахаар төлөвлөж, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвлөлтийн шинжилгээ хийж, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрэн дайчилж хэвших;
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусган хэрэгжиж буй 44 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин, үр дүнг нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хангахуйцаар бүрэн хэрэгжүүлэх;
3. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээг бүрэн хамруулж, хүрсэн үр дүнг нотлох баримтад үндэслэн үнэн зөв, бодитой тайлагнаж байх;
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавихдаа хүрсэн үр дүнг нотлох баримтад үндэслэн нягтлан шалгаж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 7.2-т заасны дагуу цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт гаргах.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон хэрэгжүүлэгч байгууллагын дарга нарт:

1. Цаашид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа тухайн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр илэрхийлж, хамтран хэрэгжүүлэгч талуудтай харилцан уялдаатай, хамтран ажиллах чиглэл, саналыг тусгаж байх;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвлөлтийн шинжилгээ хийж, төсөв хөрөнгийг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусгах саналыг хүргүүлж, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрэн дайчилж хэрэгжүүлэх;
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хүрсэн үр дүнг нотлох баримтын хамт Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд үнэн зөв тайлагнаж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 5.2.3-т заасан үүргийг хэрэгжүүлж ажиллах.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.03.14 № ХТ/486
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЗАГДЖАВ ТАНАА

Санал, тайлбар хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дараах мэдээлэл, санал, тайлбарыг хүргүүлж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Манай улсад одоо мөрдөгдөж буй зарим хуульд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэршлийг хамтад нь хэрэглэж, төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх хэвшмэл ойлголт, хандлага, дадал тогтсон байна. Олон улсын байгууллага, дэлхийн улс орнууд бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төсвийн зардлыг үр дүнтэй удирдах, ухаалаг засаглалыг дэмжихэд үнэлгээ, мониторингийг ашиглахад ихээхэн ач холбогдол өгч байгаатай холбогдуулан Монгол Улсад үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын тогтолцоог бий болгох, энэ хүрээнд үнэлгээ, мониторингийг үндсэн агуулгаар нь ялгамжтай, харилцан хамааралтай, хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлттэй нягт уялдаатай хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна.

Түүнчлэн хөгжлийн бодлогын урт, дунд, богино хугацааны баримт бичиг хоорондоо уялдаагүй, бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн, арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилттой нийцээгүй, бодлогын арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг хэрэгжүүлэх үе шат, цаг хугацааны нөөцөд тохируулан бүрэн, оновчтой тодорхойлоогүй, тайлан, мэдээлэл нь арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг бүрэн илэрхийлдэггүй зэргээс шалтгаалан хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой, үр дүнтэй хийхэд хүндрэл учруулж байна.

Иймд дээр дурдсан хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, шалгуур үзүүлэлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үр дүнд суурилсан үнэлгээг нэгдмэл тогтолцоотой, харилцан уялдаатай хэрэгжүүлэх, удирдлагын нэгдсэн цахим

070245002215

системийг хөгжүүлэх, өгөгдлийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх, энэ талаар эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байна.

Мөн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар яам, агентлаг, аймаг, нийслэлээс хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тул хэрэгжилтийн үнэлгээнд 2024 оны хүлээгдэж ажлын хэрэгжилт тооцогдоогүй тул нэгдсэн үнэлгээнд харгалзан үзэхийг хүсье.

"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: *...*жуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



... Б.ГАНБАТ

Үзүүлэлт	Ирүүлсэн санал, тайлбар
Тайлбар 1-г үзнэ үү	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн ХЭГ/312 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн "18.5. Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбатад Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт хүргүүлсэн бөгөөд энэхүү тайланд дурдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно. Иймд 2.12 дахь дүгнэлт үндэслэлгүй байна
Тайлбар 2-г үзнэ үү	3.3.4.4. 2021-2023 онд Улсын төсөв болон төсөл, хөтөлбөрийн 453.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 аймгийн 74 сумын 382 бэлчээрийн газарт уст цэг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж шинээр өрөмдөх худгийн найдвартай цэгийг нэмэгдүүлэв. Шинэ бэлчээр, отрын нөөц нутгийг ашиглах чиглэлээр зун, намрын бэлчээр болон сум дундын отрын нөөц нутагт уст цэг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсөв болон гадаадын төсөл, хөтөлбөрийн 453.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд, Өмнөговь, Дундговь, Дорнод, Завхан, Сүхбаатар аймгийн 74 сумын 382 бэлчээрт шинэ уст цэг тогтоох хайгуулын ажлыг гүйцэтгэж инженерийн хийцтэй худгийн нөөц цэгийн тоог нэмэгдүүлэв. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай
Тайлбар 3-г үзнэ үү	3.3.4.5. УИХ-ын 2022 оны 36 дугаар, Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ХХААХҮЯ, Арилжааны 10 банкт "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө" - ийн болон "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл" - ийн гэрээнүүдийг байгуулсан. Эдгээр гэрээний хүрээнд сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд 44,038.5 сая төгрөгийн зээл олгох ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд шингэн сүү үйлдвэрлэлийн хэмжээг 14.0 гаруй сая литрээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. - Монгол банкны 2023.12.14-ний албан мэдээгээр Сүүний чиглэлийн ЭМАА эрхлэгч 44 аж ахуйн нэгж, иргэнд 5.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон, одоо 17 зээлдэгчид 9.5 тэрбум төгрөгийн зээл батлагдсан. Энэ ажлын үр дүнд жилд 6.0 сая литр сүү боловсруулах боломж бүрдсэн. - Дэлхийн банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг сайжруулах" төслийн "Бүтээмжит түншлэлийн хамтын шийдэл" төрөлд "Энх-сүү" түншлэлтэй гэрээ байгуулах хэлцэл хийж, хөрөнгийн дэмжлэг үзүүлж гэрээ байгуулсан. Төслийн хүрээнд Багануур дүүрэг, Төв Баяндэлгэр сумдаас сүү бэлтгэн нийлүүлэх сүлжээг бий болгоно. - Нүүдэлчин "Агро ферм" ХХК 2023 оны эхний хагас жилд Франц улсын "Экспортыг дэмжих" банкнаас хүүгүй зээлээр "Монбелард" үүлдрийн мах сүүний хосолмол ашиг шимтэй 320 үхрийг импортлон 400 үнээний сүүний кластер байгуулах ажлыг бүрэн дуусгасан. Улаанбаатар хотын сүүний хэрэгцээг 2 аж ахуйн нэгж 4.3 сая литрээр нэмэгдүүлсэн. - Манай улсын сүүний нөөц 2022 оны байдлаар 990.4 сая литр, 113.6 сая литр үйлдвэрийн аргаар, үүний 63.6 сая литрийг ЭМАА-аас, 20.0 сая литрийг хөдөө, орон нутгаас, 30.0 сая литрийг импортын хуурай сүү ашигласан. - Засгийн газрын дэмжлэг, хувийн хэвшлийн хүрээнд 14.0 сая литр сүү үйлдвэрлэх боломж бүрдүүлэв. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 4-г үзнэ үү	3.6.4.1.1. АНУ-тай "Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Вашингтон хотноо 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр гарын үсэг зурсан. Хэлэлцээрийг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан. Грек: "Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Бүгд Найрамдах Грек Улсын Афин хотноо 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан. Унгар: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрхийг Ерөнхий сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 25 дугаар захирамжаар Зам, тээврийн хөгжлийн сайдад олгосон. Катар: "Агаарын харилцааны тухай" хэлэлцээрт 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурж, Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 157 дугаар тогтоолоор баталсан. Кувейт: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад олгосон. ИБУИНХУ: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, ИБУИНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад олгосон. Латви: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Латви Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн Ерөнхий сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 105 дугаар захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад тус тус олгосон. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.

Тайлбар 5-г үзнэ үү	1.1.7.2. “АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “ Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”- ийн хүрээнд улсын төсвөөс олгосон хүүхдийн мөнгөний нөхөн санхүүжилтэд 2020 онд 60.7 тэрбум, 2021 онд 119.5 тэрбум, 2022 онд 82.6 тэрбум төгрөгийг олгосон байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 6-г үзнэ үү	2.1.7.4. УНТЭ, УГТЭ, АӨСҮТ, Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 9 байгууллагад ТУЗ байгуулагдан ажиллаж байна. УНТЭ, УГТЭ, АӨСҮТ-ийн хамт олны болон олон нийтийн төлөөлөл, АӨСҮТ-ийн ТББ, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн зарим гишүүдийн хугацаа дууссантай холбоотойгоор шинээр нэр дэвшүүлэх хурал, сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж, шинэ гишүүдийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/161, А/251, А/372 дугаар тушаалаар тус тус батламжилсан. ХСҮТ, ГССҮТ, УХТЭ, Дорнод аймаг дахь БОЭТ, Архангай аймгийн нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах үйл ажиллагаа дуусаж батламжлахад бэлэн болсон. Орхон, Дорнод аймаг дахь БОЭТ-д ТУЗ-д гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн гишүүдийн хувийн ашиг сонирхлын зөрчилгүй дүгнэлтийг АТГ-аас 2023 оны 01/16641 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд ТУЗ байгуулах үйл ажиллагаа төгсгөлийн шатандаа байна. Баянхонгор, Дундговь, Баян-Өлгий, Дархан-Уул, Сүхбаатар, Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг, Өмнөговь, Ховд аймаг дахь БОЭТ-д ТУЗ байгуулах үйл ажиллагаа эхэлсэн. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 7-г үзнэ үү	2.1.11.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн эмнэлгийн барилга нь 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, “Ихбазар констракшн” ХХК-тай гэрээ байгуулж, барилга угсралтын ажил 2023 оны 12 дугаар сарын байдлаар 80.0 хувьтай байна. Мөн БОЭТ-ийн ачааллыг бууруулах зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин суманд 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилга барих ажил 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдсан бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Би энд Би констракшн” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажил 2023 оны 12 дугаар сарын байдлаар 70.0 хувьтай байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай
Тайлбар 8-г үзнэ үү	2.1.12.3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн Эрүүл мэндийн сайдын багцад 70 шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв барих төсөл, арга хэмжээ батлагдсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/615 дугаар тушаалаар “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. Нэгдсэн эмнэлэг 10, үүнээс шинээр барих 7, өргөтгөх 3, сумын болон өрхийн эрүүл мэндийн төв 60, үүнээс шинээр барих 35, өргөтгөх 25 барилга байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар тушаалаар БНБД 31-22-21 Эмнэлгийн барилгын норм, дүрмийг батлуулан, 2022 оноос хойш Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгагдсан Сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн зураг төслүүдийн төлөвлөлтөд мөрдөгдөж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 5 өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын хөрөнгө батлагдсан. Үүнээс: - 2 өрхийн эрүүл мэндийн төв ашиглалтад орсон, 100%; - 2 өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил 40%-тай үргэлжилж байна; - 1 өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил 15%-тай үргэлжилж байна; 2022 оноос шилжих 4 сумын эрүүл мэндийн төвийн барилга 2023 онд ашиглалтад орно. 4 сумын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил 70-89 хувийн гүйцэтгэлтэй байна. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд: Өрхийн ЭМТ-ийн барилга: ӨЭМТ-үүдэд LCT барих газрын тооцоолол хийснийг үндэслэн бүх ӨЭМТ-ийн газрын кадаструудыг шинэчилж, нийслэлийн ЗД-ын захирамж, бүх барилгын архитектурын төлөвлөлтийн А даалгаврууд гарсан. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 9-г үзнэ үү	2.3.2.6. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)” “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 онд БШУЯ-ны хариуцах, бусад яам, хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 10 арга хэмжээний биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна. Эдгээр арга хэмжээ тус бүрийн дэлгэрэнгүй тайланг хавсралтад орууллаа. Төлөвлөгдсөн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол Улсын бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээний салбарын уялдаа хангагдаж, төрөөс бага насны хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанарт ахиц гарах боломж бүрдсэн. Үндэсний сүлжээ байгууллагууд БШУЯ, БЕГ, ХНХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран “Бага насны хүүхдийн хөгжилд эцэг, эх асран хамгаалагчдын оролцоо, дэмжлэг” сэдэвт сургалт хэлэлцүүлгийг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулсан. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагын 48 оролцогч хамрагдсан. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 10-г үзнэ үү	2.6.3.2. Оросын Холбооны Улсын Засгийн газрын тэтгэлгээр соёл, урлагийн мэргэжлээр 34 оюутан элсэн суралцуулж байна. -Тайваны Боловсролын яамнаас 2023 онд зохион байгуулсан Хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт Соёлын яамны харьяа Чингис хааны өв, соёл судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нэр дэвшиж шалгарсан. -Соёлын

	<p>салбарын албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, чадавхжуулах 6 сургалтыг зохион байгуулан 370 гаруй албан хаагчдыг хамруулсан. Соёлын өвийн үндэсний төв соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр Япон улсын Осака, Нара, Киото хотын урлаг дизайны их сургуулийн судлаач багш мэргэжилтнүүдтэй хамтран 2023 оны 8 дугаар сарын 14-24-ний өдрүүдэд онол, дадлагын сургалт зохион байгууллаа. - БНСУ-ын Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн "Соёлын түншлэл" хөтөлбөр, "Соёлын салбарын албан хаагч болон соёлын мэргэжилтнийг дадлагажуулах сургалт" хөтөлбөрт 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд БНСУ-д яамны 3 албан хаагч мэргэжил дээшлүүллээ. - Соёлын яам болон соёл, урлагийн байгууллага, бусад холбогдох байгууллагуудын 10 гаруй сургалт зохион байгуулагдаж, 250 гаруй албан хаагчдыг мэргэжлийг дээшлүүлж, сургалтад хамрууллаа. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>
<p>Тайлбар 11-г үзнэ үү</p>	<p>2.6.3.1. Кино урлагийг дэмжих тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдсан. -Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкнийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих журмыг Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 132 дугаар тогтоолоор батлагдсан. -Кино урлагийн үндэсний зөвлөлөөс кино урлаг дэмжих сангийн төслийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 21-ээс 2022 оны 11 дүгээр сарын 21-ыг хүртэл 2 үе шаттай олон нийтэд нээлттэй зарласан. Соёлын сайдын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/78 тушаалаар дараах 11 төсөл, арга хэмжээг Эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүжүүлэхээр шийдвэрлэгдсэн. -Кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын дэргэд "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулах төслийг 2022.07.01-ээс эхлэн хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд шинэ байгууламжийн зураг төслийг хийж гүйцэтгэхээр "Урбанвижн" ХХК шалгарч гүйцэтгэж байна. Нийт хийж гүйцэтгэх ажлын хүрээнд "Олон талт арга хэмжээний танхим" /EVENT HALL/-ийн барилга баригдах ба одоо байгаа Монгол кино үйлдвэрлэлийн төв байрын засвар шинэтгэл, тус үйлдвэрийн газрын агуулах, мужаан цехийн барилгын засвар шинэтгэл болон гадна зам, талбайн тохижилтыг хийх зураг, төсвийг боловсруулах чиглэлээр гэрээнд тусгагдан 295,167,985 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлж байна. - Монгол уран бүтээл "ТРИО" уран сайхны кино 2022 оны 10 сард болсон 38 дахь удаагийн Варшавын олон улсын кино наадамд урилгаар оролцлоо. Мөн Варшав, Таллин, Тайланд, АУН-ын болон Улаанбаатар зэрэг олон улсын 7 кино наадмаас шагнал хүртсэн. Швейцарийн Женев хот дахь НҮБ-ын байранд 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Трио киног гаргасан. - Каннын кино наадмын 2023 оны "Un Certain Regard" төрөлд "If Only I Could Hibernate" буюу "Баавгай болохсон" кино 2023 оны 4 сарын 13-ны өдөр албан ёсоор нэр дэвшсэн. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>
<p>Тайлбар 12-г үзнэ үү</p>	<p>3.2.3.4. "Ховд-2020" 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны ажил: Төслийн 104044 кв.км талбайн хэмжээнд: -Нийлбэр соронзон орны эрчимжилтийн зураг; -Туйлын засвар хийсэн нийлбэр соронзон орны зураг; -Нийлбэр цацраг идэвхжилийн зураг (Tcmt); -Газрын калийн агуулгын зураг (K); -Газрын торийн агуулгын зураг (Th); -Газрын ураны агуулгын зураг (U) буюу нийт 6 төрлийн зураг тайлбар бичгийн хамт зохиогдож, үр дүнгийн тайлан Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаж, хурлын товгыг хүлээж байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>
<p>Тайлбар 13-г үзнэ үү</p>	<p>3.2.3.8. Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ ба БНКаЗУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн V үе шат хэрэгжиж байна. /2021-2024 он/. Төсөлд хамтран оролцогч улсууд геологийн бүх төрлийн мэдээллийг нэгтгэж буй нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой ажил юм. Төслөөр Алтайн нурууны үргэлжлэл Говийн Алтайн уулсын хэмжээнд судалгааны ажил гүйцэтгэж, геологи болон холбогдох зургуудыг зохиосон. Мөн төслийн талбайн хэмжээнд 252 тодорхойлолт бүхий үнэмлэхүй насны санг бүрдүүлсэн байна. Төслийн ажлын үр дүнгийн тайлан болон хавсралт зургуудыг зохиосон. ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хийж байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>
<p>Тайлбар 14-г үзнэ үү</p>	<p>3.4.5.1. .БНСУ-д 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр, Япон улсад 5 дугаар сарын 14-ний өдөр, БНХАУ-д 6 дугаар сарын 29, 9 дүгээр сарын 03-10-ны өдрүүдэд Монгол Улсыг сурталчлах эвент арга хэмжээг зохион байгуулж нийт 10,000 орчим хүнд мэдээлэл өгч сурталчилсан. 2. Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлэх ажлын хүрээнд Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын дагуу Хөх сувд мөсний баяр, Мөнгөлөг шагшуурга цас мөсний баяр, Тэмээний баяр, Бүргэдийн баяр, Талын түмэн адуу, Торгоны зам-Хархорин, Айрагны баяр, Морин хуур уртын дууны их наадам, Айс фестиваль олон улсын мөсөнд авиралтын тэмцээн, Монгол туургатны Харвуул их наадам зэрэг 11 эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажилласнаас гадна бусад 58 эвент арга хэмжээтэй хамтран ажилласан болно. Нийт дотоодын 69 эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх болон хамтран ажилласан. 3. Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилго бүхий "Нүүдэлчин Монгол-2023" дэлхийн соёлын фестиваль Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд 2023 оны 08 дугаар сарын 18-20-нд зохион байгуулагдсан. Фестивальд 21 аймаг болон нийслэлийг хамруулсан 22 отог бүхий Монгол Улсын биет соёлын өвийн долоон ай савд хамаарах 362 өвийг танилцуулж байгаагаараа онцлог болсон. Фестиваль зохион байгуулагдах хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс</p>

	урьдчилан сэргийлэх, харуул хамгаалалт, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх, эрүүл ахуйн хяналт тавих, хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ авч, ирсэн жуулчид, аялагчид, иргэдэд "Welcome to Mongolia" цогц арга хэмжээний талаар болон фестивалийн талаар мэдээлэл өгөхөөр Мэдээллийн төв ажиллуулсан. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 15-г үзнэ үү	3.6.2.3.1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төлбөр авах цэг барьж, 2022.08.17-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн. Улсын чанартай Даланзадгад-Гурвантэс-Шивээхүрэн чиглэлийн авто зам, Даланзадгад хотод орон нутгийн төсвийн хөрөнгөөр төлбөр авах цэг барьж, ашиглалтад оруулсан. Улсын төсөв, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Говьсүмбэр аймгийн Чойр хотод төлбөр авах цэг барихаар төлөвлөн ажиллаж байна. Автотээврийн хөдөлгөөний эрчим бага, улсын төсөв, авто замын санд төвлөрүүлэх орлогын хэмжээ багатай, урсгал зардал их байгаа тул Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Увс аймгийн Хяргас нуур орчимд төлбөр авах цэг барих ажлыг түр хойшлуулаад байна. Дорнод аймгийн Хэрлэн, Хэнтий аймгийн Мөрөн, Улаанбаатар хотын Түргэний гүүр, Булган аймгийн Баяннуур, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Төв аймгийн Эрдэнэсант, Хөвсгөл аймгийн Мөрөн, Архангай аймгийн Тариат, Завхан аймгийн Их-Уул, Сонгино, Баян-Өлгий аймгийн Сагсай, Ховд аймгийн Манхан, Говь-Алтай аймгийн Есөн булаг суманд тус тус төлбөр авах цэг шинээр барьж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Мөн Налайх, Хоолт, Айраг, Гурт, Онги төлбөр авах цэгт засвар үйлчилгээ хийсэн байна. Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Баруунтуруун, Налайх, Хоолт, Түргэний гүүр, Хөшгийн хөндийн төлбөр авах цэгт цахимаар төлбөр авах үйл ажиллагааг 2022.10.22-ны өдрөөс нэвтрүүлсэн. Бусад орон нутагт байгаа 25 төлбөр авах цэгийг шилэн кабельд холбох ажил 75%-тай хэрэгжиж байна. Орон нутгийн төлбөр авах цэгийг цахимжуулж, 2024 онд багтаан олон улс, улсын чанартай авто замд байрлах бүх төлбөр авах цэгт цахим систем нэвтрүүлнэ. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 16-г үзнэ үү	3.7.3.6. Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг батлуулсан. 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/129 дугаар тушаалаар "1:25000 масштабтай байр зүйн тоон зургийг нэгтгэх" ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтад Геосан ХХК шалгарч, 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 2023/164 дугаартай гэрээг байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Гэрээт ажил гүйцэтгэгчийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн эцсийн тайланг ГЗЗХ-2023/40 дугаартай дүгнэлтээр АМХ-т хүлээн авсан. Нэгтгэсэн 1:25000-ны масштабтай 7328 хуудас байр зүйн зургийг Геоорталд оруулах ажлыг Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс гүйцэтгэсэн байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 17-г үзнэ үү	4.2.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг МУЗГ-аас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд УИХ-д өргөн мөдүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023.11.06-ны өдөр Ажлын хэсгээс зохион байгуулсан.ЗГ-ын 2023 оны 312 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ХААГ-ыг шинээр байгуулж, ОНӨГ-ын чиг үүргээс холбогдох чиг үүргийг салгасан. Үүнтэй холбоотойгоор ОНӨГ-ын бүтцийн жишиг загвар, албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт хамаарах чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх хуулийн шаардлагын талаар зөвлөмж боловсруулж,ТӨБЗГ-ын 2023 оны А-1/1819 дугаар албан бичгээр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 18-г үзнэ үү	4.2.4.2. ТӨБЗГ-аас төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа болон эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төрийн өмчит 6 үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 18 компанид баримтын, төрийн өмчит төсөвт 10 байгууллагад системийн, нийт 34 хуулийн этгээдэд төлөвлөгөөт (төлөвлөгөөнд өөрчлөлт орсон) хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 4, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалтын ажлыг төрийн өмчит хуулийн этгээдэд гүйцэтгэсэн бөгөөд нийт дүнгээр 48 хяналт шалгалт хийв. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 24 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалтыг хийж, 14 хуулийн этгээдийн дүн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Нийт дүнгээр 11,677.58 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын тогтоолоор баталгаажуулсан байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 19-г үзнэ үү	4.2.4.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 онд хэрэгжүүлэх төрийн өмчийн хяналт шалгалтын төлөвлөгөө, газрын даргын баталсан удирдамжийн дагуу төрийн өмчит төсөвт 10 хуулийн этгээдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлэв. Тэдгээрээс 8 хяналт шалгалтын ажлын дүн, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, нийт дүнгээр 679,241.1 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг тогтоолоор баталгаажуулаад байна. 2 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын дүнг бэлтгэсэн, 2024 оны 1 дүгээр сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн. Хяналт шалгалтын дүн, тайланг тогтоолын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авав. 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн Гаалийн ерөнхий газар, түүний

	харьяа 10 салбар нэгжийн өмчийн захиран зарцуулалтад хийсэн системийн хяналт шалгалтын дүн, тайланд тусгагдсан 113.7 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 96 дугаар тогтоолоор баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авсан байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 20-г үзнэ үү	4.5.5.2. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Япон Улсад 2022.11.29-30-нд хийх төрийн айлчлалын үеэр Монгол, Японы Стратегийн түншлэлийг “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай Стратегийн түншлэл” болгож шат ахиулах тухай хамтарсан мэдэгдэлд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд Ф.Кишида нар гарын үсэг зурав. Мөн энэхүү төрийн айлчлалын үеэр Монгол Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн Монгол Японы “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай Стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөр байгуулав. Шинэ хөтөлбөрийг 2022-2031 он хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд хоёр талын хамтын ажиллагаа, олон улс, бүс нутаг ялангуяа дэлхий нийтийн өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт зэрэг нийтлэг нийтлэг асуудлын хүрээнд хамтран ажиллахаар тусгасан болно. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 21-г үзнэ үү	6.1.13.1. Сургуулийн автобусны парк шинэчлэлтийн хүрээнд 2020 онд 5 автобус, 2022 онд 20 автобус, 2023 оны 1 дүгээр улиралд 50 автобус нийлүүлэгдсэнээр нийтдээ сургуулийн 75 автобус шинээр нийлүүлэгдсэн. - 2023 онд шинээр нийлүүлэгдсэн сургуулийн 50 автобусыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжаар 9 дүүрэгт хуваариллаа. - 2022-2023 оны хичээлийн жилд 96 сургуулийг хамруулан хүүхдийн 72 автобусаар өдөрт 12859, давхардсан тоогоор 742736 сурагчийг тээвэрлэсэн. 2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлуудын хүрээнд сурагчдыг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан автобусаар тав тухтай, аюул осолгүй тээвэрлэх зорилтын хүрээнд “Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартад тавигдсан шаардлагуудын хүрээнд ажиллаж байна. - 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчит 56 сургуулийг хамруулан 58 чиглэлд хүүхдийн 58 автобусаар давхардсан тоогоор өдөрт 10386 хүүхэд тээвэрлэж байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 22-г үзнэ үү	3.1.6.1. “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийн төслийг эцэслэн боловсруулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг ханган 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/990 дүгээр албан бичгээр хууль санаачлагч болох Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан байна. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 23-г үзнэ үү	2.3.10.3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2022 онд 30 сургуульд 78.4 сая төгрөгийн 80 ширхэг ус шүүгч төхөөрөмж нийлүүлсэн. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 98 сургуульд 112.7 сая төгрөгийн 145 ширхэг ус шүүгч төхөөрөмж нийлүүлсэн. 2022 онд улсын төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр 128 сургуульд стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлж үлдсэн сургуулиудад НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр ус цэвэршүүлэгч төхөөрөмж нийлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар дунд ангийн сурагчдын үдийн хоолны үйлчилгээнд шилжих хугацааг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдэх хүртэл үе шаттайгаар эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 24-г үзнэ үү	3.6.2.1.4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөө”-ний хавсралтаар “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засвар, ашиглалтыг сайжруулж, чадавхыг бэхжүүлэх дэд хөтөлбөр” батлагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: - Төлөвлөгөөний дагуу замын засвар арчлалтын шинэ технологи болох нөхөөсний засварыг хэрхэн хийх талаар Беларусь улсаас ирсэн мэргэжилтэн зам хариуцагч төрийн өмчит 20 компанийн ажилтнуудад үзүүлэх сургалтыг зохион байгуулж, чадавхыг бэхжүүлсэн. - Беларус улсын МАЗ үйлдвэрээс зам хариуцагч төрийн өмчийн компаниудад замын засвар арчлалтын тусгай зориулалтын 42 техникийг хүлээлгэн өгч чадавхыг бэхжүүлсэн. - Лазераар авто замын хучилтын эвдрэл, хагарлыг хэмжигч буюу Romdas системийг нэвтрүүлснээр орчин үеийн дэвшилтэт аргаар замын хучилтын эвдрэлийн хэмжээ, засвар арчлалтын хэрэгцээ, ажлын тоо хэмжээг нарийвчлалтайгаар тодорхойлох нөхцөлийг бүрдүүлсэн. - Гадаргуун боловсруулалтын машин 2/Chip sealer, Slurry sealer/ зэрэг шинэ орчин үеийн техник, төхөөрөмжийг АХБ-ны Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлсэн ба тус техник, тоног төхөөрөмжийг ашиглах ээлжит засварыг гүйцэтгэх, замын ашиглалтын хугацааг уртасгах нөхцөлийг бүрдүүлсэн. - Нийт давхардсан тоогоор засвар арчлалтын байгууллагуудын 48 инженерийг мэргэшсэн, дадлагажигч инженерийн болон төсөвчний анхан шатны сургалтад хамруулсан зэрэг байна. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах асуудлыг хэлэлцэж, “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК байгуулах тухай 220 дугаар тогтоол баталсан. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.
Тайлбар 25-г үзнэ үү	4.3.13.2. 2022 онд хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториудаас 3 аймгийн МХГ-ын лабораторид тоног төхөөрөмж, 1 аймагт лабораторийн байр болон тоног төхөөрөмж шинэчлэхээр улсын болон орон нутгийн төсөв батлагдсанаас -Архангай аймгийн МХГ-ийн

	<p>лабораторид 4200000төгрөг, /улсын төсөв/ -Дундговь аймаг 44640000 төгрөг /орон нутгийн төсөв/ -Орхон аймаг 90150000 төгрөг /орон нутгийн төсөв/-ийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. 2/ Дархан-Уул аймаг 2231314800 төгрөгийн барилга угсралт тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төсөвлөгдсөн ч өнөөдрийн байдлаар барилгын гүйцэтгэл 40%-тай үр дүн багатай байна. Үүнээс гадна Завхан аймгийн МХГ лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж хяналт шалгалтыг үр дүнг дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор Аймгийн Засаг даргад хүсэлт тавьж орон нутгийн хөгжлийн сангаас лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд 15.0 сая төгрөг, байгууллагаас 2.0 сая нийт 17.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 нэр төрлийн /автоклавын, усанд цианит илрүүлэгч, сүүний лактоскан хэмжигч, ногооны писцитид илрүүлэгч/ багаж, тоног төхөөрөмж, Говьсүмбэр аймгийн МХГ орон нутгийн хөрөнгө оруулалтаар 22 нэр төрлийн 59 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, мөн Баян-Өлгий аймгийн МХГ орон нутгийн хөрөнгө оруулалтаар лабораторийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 19 сая 800 мянган төгрөг шийдвэрлүүлсэн. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>
<p>Тайлбар 26-г үзнэ үү</p>	<p>4.1.4.5. УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд уг асуудал тусгагдсан. УИХ-ын 2023.11.10-ны өдрийн чуулганаар баталсан МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсөвт уг арга хэмжээний зардалд 1,200,0 сая төгрөг тусгагдсан. Иймд холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах зэрэг ажлуудыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж эхлээд байна. Хууль тогтоомжийн дагуу ТӨБЗГ-ын 2023.12.13-ны өдрийн А/101 дугаартай тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем”, тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг сонгон сонгон шалгаруулах үнэлгээний хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.ТӨБЗГ-ын 2023.11.30-ны өдрийн хуралдаанаар “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн болон эд хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайлангийн тухай” асуудлыг хэлэлцээд “...Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг бий болгох ажлыг 2024 онд эхлүүлж, 2025 онд багтаан дуусгах, Сангийн яам, УБЕГ, ГЗБГЗЗГ, АТҮТ зэрэг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй” гэж 41 дүгээр тэмдэглэлд тусгасан. Иймд тус арга хэмжээний үнэлгээг өөрчлөх шаардлагатай.</p>



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,
Цахим шуудан: info@aga.gov.mn,
Цахим хуудас: www.aga.gov.mn

2024.03.24 № 01/155
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.ЭНХБОЛД
ТАНАА**

Тайлбар, санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд танай байгууллагаас хийсэн аудитын тайлан, албан шаардлагын төсөлтэй танилцаж, аудитаар илэрсэн алдаа, зөрчил гэж үзсэн асуудлын хүрээнд дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

Тайлбар
27-г
үзнэ үү

1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 8 дугаар сарын 22, мөн оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллах болсонтой холбоотойгоор зарим төрийн байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний "Эдийн засгийн бодлого"-д тусгагдсан Шадар сайдын алба, Эдийн засаг, хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнд өөрчлөлт ороогүй тул Шадар сайдын ажлын албанд хамааралгүй арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзсэн. Иймд Эдийн засаг, хөгжлийн яаманд "Мэдээлэл ирүүлэх тухай" 2024 оны 01/155 дугаар албан бичиг хүргүүлж, дээрх 13 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, Улсын Их Хуралд өргөн барихаар хүргүүлсэн тайланд тусгасан болно.

Тайлбар
28-г
үзнэ үү

2. Албан шаардлагын төсөлд заасан 3.1.13.5, 3.2.7.8, 5.1.11.2, 6.2.10.1, 6.2.14.2 зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг хариуцагч байгууллагаас цахим системд тайлагнасан, тус газраас 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг үнэлсэн байгаа болно. Төлөвлөгөөний 5.1.11.2, 6.2.10.1, 6.2.14.2 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч нь Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар бөгөөд эдгээр байгууллагуудаас хэрэгжилтийг тайлагнаж, тус газраас хэрэгжилтийн үнэлгээг хийсэн болно.

Тайлбар
29-г
үзнэ үү

3. "Ногоон хөгжлийн бодлого"-ын 5.2.3 болон 5.1.11.3 дугаар бүхий арга хэмжээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-д тусгагдаагүй байна.

15160 0 0632

Тайлбар
30-г үзнэ үү

4.Үндэсний аудитын тайланд тусгагдсан асуудлаар:

- Тайлангийн 2.7-д заасан Эдийн засгийн бодлогын 3.1.3."Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно" зорилтын 3.1.3.1 дэх арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй асуудлыг тайлагнасан гэж дүгнэсэн байна. Энэ асуудлыг нягтлан үзэхэд, хяналт-шинжилгээ, үнэлгээний (mew.unelgee.gov.mn) цахим системд байхгүй хэрэгжилтийн тайланг үндэслэн "хамааралгүй" гэж дүгнэсэн байна.

Тайлбар
31-г үзнэ үү

- Тайлангийн 2.13-д заасан "3.5.1.5. Төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ" гэсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Эрчим хүчний яамнаас баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн а/4568, 2022 оны 11 дүгээр 18-ны өдрийн ХЭГ/2814а албан тоотод хариу 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн в/4333 дугаар албан бичгээр дээрх арга хэмжээг тусган хүргүүлсэн ч Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар тус арга хэмжээг 2021-2023 онд /www.unelgee.gov.mn/-д байршаагүй, үнэлээгүй байна гэж дүгнэсэн байна. Энэ асуудлыг нягтлан үзэхэд, Эрчим хүчний яамны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн в/4333 дугаартай албан бичигт тус яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем (www.unelgee.gov.mn)-д байршуулсан тухай дурдаж, хавсралтаар дэлгэрэнгүй тайланг ирүүлээгүй байна.

Тайлбар
32-г үзнэ үү

- Тайлангийн 2.20-д заасан Ногоон хөгжлийн бодлогын 5.1.12."Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна." зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5.1.12.1."Уур амьсгалын өөрчлөлтийн харилцааг зохицуулах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно." арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг үнэлэхдээ Хууль зүй, дотоод хэргийн яамны үнэлгээг "хугацаа болоогүй" гэж бодитой бус үнэлсэн гэж дүгнэсэн байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д "Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална." гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр зохицуулсан байгааг үндэслэн үнэлсэн болно. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3 дахь хэсэгт "Засгийн газраас санаачлах хуулийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ." гэж тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд боловсруулсан хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам эцэслэн хянах чиг үүрэгтэйг тусгайлан зохицуулсан байна.

Тайлбар
33-г үзнэ үү

Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн илэрсэн алдааг арилгуулах зорилгоор тус байгууллагад

Тайлбар
34-г үзнэ
үү

албан шаардлага хүргүүлэхээр тайланд тусгасныг бодит нөхцөл байдлыг үнэн зөв, үндэслэл бүхий үнэлж, зөвлөмж болгон өөрчлөх үндэслэлтэй гэж үзэж байна. Тухайлбал, дээрх хуулийн 21.1-д "шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж зааснаас гадна Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4-т заасан албан шаардлага тогтоох үндэслэл бүрдээгүй гэж үзэж байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас бодлогын баримт бичигт хийх хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог шинэчлэх, эрх зүйн орчныг сайжруулах, бодит үр дүнд тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар олон арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний бодит үр дүн гарахад тодорхой хугацаа зарцуулах шаардлагатай байгааг харгалзан үзэж, үнэлэлт дүгнэлт өгч, шийдвэр гаргах үндэслэлтэй гэж үзэж байна.

Монгол Улсын хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог шинэчлэх, цахим системийг боловсронгуй болгохтой холбоотой дэлгэрэнгүй саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэгтгэн хүргүүлж байгаа болно.

Холбогдох дэлгэрэнгүй тайлбар, нотлох баримтыг хавсаргав.

Хавсралт 18 хуудастай.

ДАРГА



Б. БААСАНДОРЖ

Үндэсний аудитын газрын тайлбар

ЗГХЭГ-аас 26, ЗГХХГ-аас 8 санал, тайлбар ирүүлснийг хянаж, тайлангийн 2.12 дахь заалт болон холбогдох дүгнэлтэд найруулгын өөрчлөлт хийж, нийт 19 саналыг хүлээн авч, 15 санал, тайлбарыг хүлээн авах боломжгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайлангийн 2.12 дахь заалтаас 3 арга хэмжээг хасч найруулгын өөрчлөлт хийсэн.
Тайлбар 2	Нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул үнэлгээг хэвээр үлдээв.
Тайлбар 3	3.3.4.5 дахь арга хэмжээ 2023 онд “Шинээр байгуулагдсан 5 фермийн нийт 3300 үнээнээс 20.1 сая литр сүү үйлдвэрлэж, хуурай сүүний импортыг 47 хувиар бууруулна.” гэсэн зорилтот түвшинг хангаагүй тул үнэлгээнд өөрчлөлт оруулаагүй.
Тайлбар 4	ЗГХХГ-аас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “үр дүнгийн шинжилгээ хийсэн” талаарх зарим үр дүнг нотлох баримтаар 2024.03.14-ний өдөр ирүүлсэнд үндэслэн 3.6.4.1.1 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 5	1.1.7.2 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилтийг нотлох баримтад үндэслэн 90 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 6	Нийт 26 эрүүл мэндийн байгууллагаас 9 нь ТУЗ байгуулан ажиллаж байгаа, нэмж нотлох баримт ирээгүй тул үнэлгээг хэвээр үлдээв.
Тайлбар 7	Тайлбар, нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул үнэлгээг хэвээр үлдээв.
Тайлбар 8	Нэмэлт тайлбарыг үндэслэн хэрэгжилтийн үнэлгээ 30 байсныг 50 болгож өөрчлөв.
Тайлбар 9	ЗГХХГ-аас ирүүлсэн 2024.03.14-ний өдрийн ирүүлсэн нотлох баримтад үндэслэн 2.3.2.6 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 10	ЗГХХГ-аас ирүүлсэн 2024.03.14-ний өдрийн ирүүлсэн нотлох баримтад үндэслэн 2.6.3.2 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 11	ЗГХХГ-аас ирүүлсэн 2024.03.14-ний өдрийн ирүүлсэн нотлох баримтад үндэслэн 2.6.3.1 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 12	Саналыг хүлээн авч 3.2.3.4 арга хэмжээний хэрэгжилтийг 66 хувийн биелэлттэй гэж өөрчилсөн.
Тайлбар 13	Саналыг хүлээн авч 3.2.3.8 арга хэмжээний хэрэгжилтийг 69 хувийн биелэлттэй гэж өөрчилсөн.
Тайлбар 14	3.4.5.1 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, нотлох баримтад үндэслэн 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 15	3.6.2.3.1. арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилт зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй, нотлох баримтад үндэслэн 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 16	3.7.3.6 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, нотлох баримтад үндэслэн 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 17	4.2.4.1 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, нотлох баримтад үндэслэн 30 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 18	ЗГХЭГ-аас 2024.03.14-ний өдөр ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн 4.2.4.2 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 19	ЗГХЭГ-аас 2024.03.14-ний өдөр ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн 4.2.4.3 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 20	Нэмж ирүүлсэн тайлбар, нотлох баримтыг үндэслэн хэрэгжилтийн үнэлгээг 100 болгож өөрчлөв.
Тайлбар 21	6.1.13.1 арга хэмжээний 2021-2023 оны хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй, нотлох баримтад үндэслэн 35 хувийн биелэлттэй гэж үнэлсэн тул арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 22	ЗГХЭГ-аас 2024.03.14-ний өдөр ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн 3.1.6.1 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 23	ЗГХХГ-аас ирүүлсэн 2024.03.14-ний өдрийн ирүүлсэн нотлох баримтад үндэслэн 2.3.10.3 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 24	ЗГХХГ-аас ирүүлсэн 2024.03.14-ний өдрийн ирүүлсэн нотлох баримтад үндэслэн 2.3.10.3 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 25	Аймгуудын лабораториудад тодорхой тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн байх тул үнэлгээг 25 болгож өөрчлөв.
Тайлбар 26	ЗГХЭГ-аас 2024.03.14-ний өдөр ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн 4.1.4.5 арга хэмжээний үнэлгээнд өөрчлөлт оруулав.
Тайлбар 27	ЗГХЭГ-ын 2024.02.01-ний өдрийн ХЭГ/213 дугаар албан бичгээр ...Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн

	тайланд үндэслэн аудитын дүгнэлт гарсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 28	Саналыг хүлээн авч албан шаардлагад өөрчлөлт оруулсан.
Тайлбар 29	ЗГХХГ-аас ирүүлсэн саналыг хүлээн авч 5.1.11.2 арга хэмжээний дугаарт өөрчлөлт оруулав.
Тайлбар 30	Саналыг хүлээн авч Эдийн засгийн бодлогын 3.1.3.1 дэх арга хэмжээг тайлангийн 2.7 дахь заалтаас хасав.
Тайлбар 31	Тайлбар, нотлох баримтаар дэмжигдээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 32	Тайлбар, нотлох баримтаар дэмжигдээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 33	МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” тогтоогдсон тул тайлбар үндэслэлгүй.
Тайлбар 34	Саналыг хүлээн авах боломжгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “эрчимжүүлэх шаардлагатай” арга хэмжээний жагсаалт

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөөр баталсан				Хүрсэн түвшин	Аудитын үнэлгээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага
зорилтын нэр	Арга хэмжээний нэр		Хэрэгжих хугацаа			
1	2	3	4	5	6	7
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.						
2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	4	“Хавдрын эсрэг” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2020-2024	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар "Хавдрын эсрэг" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 12 сарын байдлаар 30.0 хувьтай байна.	50	ЭМЯ
	5	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны 12 сарын байдлаар 42.4 хувьтай байна.	50	ЭМЯ
	6	“Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ 2023 оны 12 сарын байдлаар 39.2 хувьтай байна.	56	ЭМЯ
	7	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021-2024	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ 2023 оны 12 сарын байдлаар 43.0 хувьтай байна. 2023 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд улсын 22 эрүүл мэндийн байгууллагад урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагаас нийслэлд 11, аймагт 11 байна.	61	ЭМЯ
2.1.4. Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.	4	Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.	2021-2024	Нийт 300 эрүүл мэндийн байгууллагад автомашин олгохоос 155 байгууллагад олгосон байна. (2021 онд 26, 2022 онд 50, 2023 онд 79)	51.7	ЭМЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.	4	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна.	2021-2023	УИХ-ын 2024.01.12-ны өдрийн чуулганаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг баталсан байна.	60	ЭМЯ
	6	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	2020-2024	ТХТХ-ийн үзэл баримтлалыг 2023.4.26-ны өдөр шинэчлэн батлуулсан. Тамхины хяналтын тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бүх яамдаас санал авсан.	30	ЭМЯ
2.1.6.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	1	Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний дэд бүтцийг бий болгоно.	2021-2024	Эрүүл мэндийн салбарын "VPN" хамгаалагдсан мэдээллийн сүлжээний дэд бүтцийг Мобиком, Юнител зэрэг байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулж, нийт 76 байхаас 48 эрүүл мэндийн байгууллагыг холбосон сүлжээний дэд бүтэц бий болсон.	63	ЭМЯ
	5	Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна.	2021-2024	"Эрүүл мэндийн мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг Эрүүл мэндийн яамны харьяанд байгуулахаар засгийн газрын тогтоолын төсөл шинэчлэн боловсруулсан. ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлж, дэмжигдсэн.	50	ЭМЯ
2.1.7.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	1	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна.	2021-2024	2023 оны төсвийн тухай хуульд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийг 1,603.4 тэрбум төгрөгөөр төсөвлөж, эрсдэлийн санг 40.0 тэрбум төгрөгөөр баталсан. Энэ нь даатгалын санхүүжилтийн ердөө 2.5 хувийг эзэлж байна.	31.2	ЭМЯ
	3	Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-гаас санхүүжүүлнэ.	2022-2024	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар сэргээн засах тусламж, үйлчилгээний 260,069 тохиолдолд 46.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс хувийн хэвшилд 4.7 мянган тохиолдолд 18.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	50	ЭМЯ
	4	Эмнэлгийн хагас бие даасан байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ.	2020-2024	УНТЭ, УГТЭ, АӨСҮТ, Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 9 байгууллагад ТУЗ байгуулагдан ажиллаж байна.	35	ЭМЯ
2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртгэмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	1	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ.	2021-2024	Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/509, А/60 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд Эмийн чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой эмийн мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Үндэсний ДАТА төв, И-Монгол академитай хамтран Licemed программын үндсэн өгөгдлийн сан болон программ	30	ЭМЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

				ажиллах 2 ширхэг Dell gold серверийг Үндэсний ДАТА төвд байршуулсан. E-Mongolia системээр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах үйл ажиллагааг тус системд оруулж цахимжуулсан. Ингэснээр эм ханган нийлүүлэх 100 гаруй байгууллага эдгээр үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн.		
2	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийнэ.	2022-2023	МУШСайд болон ЭМС-ын хамтарсан 2023 оны 20/а/95 дугаар "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Хяналт шалгалт, үнэлгээнд нийт 368 байгууллагыг хамруулснаас 223 эмийн сан, 109 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 19 эмийн үйлдвэр, 12 аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 аймаг дахь БОЭТ хамрагдсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийн Долоо дугаар бүлэгт "Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохицуулалт"-ыг тусгасан байна.	65	ЭМЯ	
4	Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2024	2023 оны байдлаар Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэх ажлын хүрээнд WHONET үндэсний сүлжээг өргөжүүлж, 20 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 7 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 19 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн 4 лаборатори зэрэг нийт 50 эрүүл мэндийн байгууллагын нян судлалын лабораторид WHONET-ийн программ суулгасан. Мэдээлэл хэрхэн ирүүлсэн талаар тайланд дурдаагүй.	30	ЭМЯ	
7	Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.	2021-2024	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2021 онд тэжээлт орчны үйлдвэрлэл 5 хувиар өссөн. 2022 онд НЭМҮТөвд 24 төрлийн тэжээлт орчин үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. 2023 оны байдлаар ЗӨСҮТ-д 182 нэр төрлийн 1457.4 литр микробиологийн тэжээлт орчин үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	53.3	ЭМЯ	
9	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.	2021-2024	2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан буюу www.heps.hdc.gov.mn цахим программд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 588 эрүүл мэндийн байгууллагын 1,181 хэрэглэгч, 31,163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн байна. БНПУ-ын ЗГ болон МУЗГ хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд Польш Улсын Storalczyk Mirosław Technologia Pozarnicza компанитай МОН/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулж, гэрээний дагуу 2022 оны 06 дугаар сараас автомашины нийлүүлэлт эхлэхээр байсан боловч Украин Улсад болж буй дайны улмаас тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн эд ангиудын нийлүүлэлт тасалдаж, гэрээний нийлүүлэлтийн хугацаа хойшилсон.	50	ЭМЯ	

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	4	Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цалин урамшуулалттай уялдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.	2022-2024	ЭМС-ын 2023 оны А/77 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна. СаСайд болон ХНХСайдад 2023 оны 1а/5460 дугаар албан бичгээр "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын төслийг боловсруулж санал авахаар хүргүүлсэн. СаСайдын 2023 оны 01/9321 дугаар албан бичгээр саналаа ирүүлсэн байна.	65	ЭМЯ
2.1.10. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1	Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулна.	2021-2022	ЭМС-ын 2023.02.13-ны өдрийн А/53 дугаар " Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" тушаалаар "Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулалтын шатанд байна.	30	ЭМЯ
2.1.11. Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна.	1	Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ.	2021-2024	Дорнод аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн эмнэлгийн барилга 80%, БОЭТ-ийн ачааллыг бууруулах зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин суманд 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилга 70%-тай байна.	30	ЭМЯ
2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	3	Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилгыг шинэчилнэ.	2021-2024	Тайлант 2021-2023 онд нийт 33 сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн барилгыг ашиглалтад оруулсан байна. Харин ХУД, ЧД-ийн нэгдсэн эмнэлэг баригдаж эхлээгүй. Зорилтот түвшнийг хангаагүй байна.	50	ЭМЯ
	4	Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ.	2021-2024	Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тушаалаар Эмнэлгийн барилгын норм, дүрмийг баталсан байна. Дээрх норм, дүрмийн дагуу тайлант онуудад 33 төсөл, арга хэмжээ ашиглалтад орсон байна.	38.8	ЭМЯ
2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.	1	Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ.	2021-2024	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн батлуулсан. ӨЭМТ-үүдийн нөөцийг үр ашигтай зарцуулах, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор хэвтээ болон босоо интеграчлалын хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрүүдийг сонгон нэвтрүүлэхээр АХБ-ны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд үнэлгээ хийж, ЧД, ХУД-ийн нэгдсэн эмнэлгийн дэргэд Эрүүл мэндийн нэгдмэл тусламж үйлчилгээг зохицуулах зөвлөлийг НЭМГД-ын 2023 оны А/140 дүгээр тушаалаар байгуулсан байна.	50	ЭМЯ
	3	Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно.	2021-2024	Азийн хөгжлийн банкны "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" төслийн хүрээнд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн байдалд түргэвчилсэн үнэлгээг "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил" зөвлөх багаар 2022 онд гүйцэтгүүлсэн байна. 2021, 2023 онд уг үнэлгээг хийлгээгүй байна.	30	ЭМЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

Зорилго: Биеийн тамир, спорт. 2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.						
2.2.2.Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.	3	Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно.	2021-2024	Олон улсын брэнд наадмыг зохион байгуулах хөтөлбөрийн төсөл боловсруулалтын шатанд байна. Зохион байгуулалтын ажил удаашралттай байна.	30	ЗГХЭГ, БТСУХ
Зорилго: Боловсрол. 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.						
2.3.2.Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	4	Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ.	2020-2024	Төсөв тодорхойгүй, нотлох шаардлага хангахгүй "10 бүлэг нээж 250 хүүхдийг элсүүлсэн" гэсэн хүрэх түвшинтэй уялдуулаагүй, санхүүжилт шийдэгдсэн эсэх нотлогдохгүй байна.	30	БШУЯ
	5	Цэцэрлэгийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулна.	2020-2024	Сургуулийн өмнөх насны хүүхдийн тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 4952 багш, удирдах ажилтныг сургалтад хамруулан мэргэшүүлсэн.Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, ажилтанд зориулсан “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй” гарын авлагыг боловсруулан хэвлүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа 320 багшид хүргүүлсэн. Цэцэрлэгийн багшийн өөрийн хүсэлтэд тулгуурлан 2022-2023 оны хичээлийн жилд 47 ээлжийн багш, 2023-2024 оны хичээлийн жилд 44 ээлжийн багш (Орхон аймаг, Төмөр замын цэцэрлэг) тус тус ажилласан байна. $44+47/300*100 = 30.3$ хувьтай хэрэгжсэн байна	30	БШУЯ
2.3.5.Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.	4	Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгоно.	2020-2024	Улсын хэмжээнд их сургуулийн нэг эндоумент сан байгуулагдсан бөгөөд анхны эндоумент санг МУИС 2022.09.16-нд байгуулсан. Тус сургууль эндаумент сангаасаа 2022 онд судалгаа, шинжилгээний 8 ажлын санхүүжилтэд 32,3 сая төгрөг олгосон бол 2023 онд 24 төсөлд 530.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2/МУИС-н эндоумент сан байгуулсан туршлага, эндоумент сан байгуулах эрх зүйн зохицуулалтыг хөндсөн хэлэлцүүлгийг 2023.03.10-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээг зохион байгуулж байгаа боловч 2023 онд тодорхойлсон "Их сургуулийн Эндоумент, Венч сангуудын санхүүжилтээр судалгаа шинжилгээний ажлуудыг	50	БШУЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

				санхүүжүүлж эхэлсэн байна. "хүрэх түвшинд хүрээгүй. бэлтгэл ажлын шатанд байна.		
	6	Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулна.	2020-2024	Иргэд, олон нийтийн инновацын санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "МОН ИКС ПРАЙЗ" арга хэмжээг 2022 онд зохион байгуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 52 сургалт зохион байгуулж, 1000 гаруй иргэнд инновац гэж юуг хэлэх, санаагаа хаанаас, хэрхэн олох, Стэнфордын их сургуулийн дизайн сэтгэлгээ, аргачлалын анхан шатны мэдлэг, бусдын технологи, инновацыг бүтээлчээр, хуулийн хүрээнд оновчтой ашиглах соёлыг түгээсэн. Тус хөтөлбөрт 21 аймаг, нийслэлээс нийт 251 төслийн санал хүлээн авсан. Эдгээрээс 19 баг эцсийн шалгаруулалтад оролцож, 9 багт Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022.12. 05-ны өдрийн "Грант олгох тухай" А/520 дугаар тушаалаар 180,0 сая төгрөгийн грант буюу урамшуулал олгосон.	30	БШУЯ
2.3.6.Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.	2	Засгийн газрын тэтгэлэг, зээлээр гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллуулах зохицуулалт хийнэ.	2020-2024	МУИС-ын ахисан түвшний сургуулийн захирлын 2021.11.04-ний өдрийн "Журам батлах тухай" Б/06 дугаар тушаалаар "Ахисан түвшний сургуульд суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих тэтгэлгийн журам"-ыг баталсан. энэхүү журмын дагуу 3 төрлийн тэтгэлэг олгож байна.	50	БШУЯ
2.3.7.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	1	Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийнэ. (Дархан, Сэлэнгэ, Орхон, Багануур, Дорнод, Ховд, Завхан)	2020-2024	2021-2023 оны улсын төсөвт бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт тусгагдаагүй. Дархан-Уул аймагт их сургуулийн цогцолборын газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023.01.31-ний өдөр 01/А-22 дугаартай захирамжаар Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багт 300,000 кв газрыг боловсролын байгууллагын зориулалтаар 2 жилийн хугацаатайгаар олгосон. Ховд аймаг дахь "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ын газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Ховд аймгийн Засаг даргын 2023 оны	30	БШУЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

				A/147 тоот захирамжид үндэслэн 2005716 м.кв газрыг 15 жилийн хугацаатайгаар олгосон.		
2.3.8.“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.	1	Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2020-2024	БШУ-ны сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар "Чадварлаг багш" арга хэмжээний хөтөлбөр /2021-2024/- ийг баталж, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн "2.1.Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн олон хувилбарт, уян хатан үйл ажиллагааг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд ерөнхий боловсролын салбарт дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих журам, Багшийн хөгжлийн төвийн журам, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулсан.	50	БШУЯ
	6	Сургуулиудын эрүүл мэндийн боловсролын хичээлд суурилан амьдралын ур чадварыг сайжруулна. (багш нарт зориулсан сургалт, сургалтын материал боловсруулалт)	2020-2024	2023 оны 3-4 дүгээр улиралд зохион байгуулж, сургалтад нийт 1079 байгууллагын 1206 эмч, багш, удирдах ажилтан хамрагдсан. Мөн төвөөс 2023-2024 оны хичээлийн жилийн эхний улиралд анги удирдсан болон эрүүл мэндийн багш нарт зориулсан "хүүхдийн дархлаанд цахим хэрэгсэл нөлөөлөх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. БШУЯ, ЭМЯ хамтран 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэн суралцаж буй 54,758 суралцагчдын дунд эрт илрүүлэг, үзлэг, оношилгоог сургуульд суурилан харьяа өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан.	50	БШУЯ
2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүргэмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах хөгжих боломжийг	5	Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	2020-2024	Тус арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч 2023 онд тавьсан "Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилга, тусгай 25, 63 дугаар сургуулийн барилгын өргөтгөлийг барьж дууссан байна" гэсэн хүрэх түвшин хангагдаагүй, гүйцэтгэл 50 хувьтай гэсэн байна	50	БШУЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх, Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох	6	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллийн төв байгуулна.	2020-2024	Тус арга хэмжээнд "Ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх чиглэлээр 60 багшийг чадавхжуулах сургалтад хамруулсан" гэх хүрэх түвшин хангаагүй, эрчимжүүлэх шаардлагатай.	30	БШУЯ
2.3.12.Цахим сургалтын платформ хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.	6	Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.	2020-2024	Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв"-ийн барилга угсралтын ажил дараах үе шатыг дамжин хэрэгжиж байна. Барилгын каркас төмөр угсрах ажил 2023 оны 9 дүгээр сараас эхэлсэн хийгдэж байна. Барилгын ажлын гүйцэтгэгч Р.К Saxena ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дуусаж ажил удаашралтай байгаа тул 2023.09.07-нд гэрээний хугацааг 2024.10.31 хүртэл сунгасан. 2-р багцын гүйцэтгэгчийн нийлүүлэх тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх хугацаа 2024 он хүртэл хойшилсон. Тус ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.	50	БШУЯ
	8	Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020-2024	ШУ-ны академийн тэргүүлэгчдийн хурлын 2022.12.26-ны өдрийн А/20 дугаар тогтоолд үндэслэсэн ХЗХ-ын захирлын 2023.06.30-ны өдрийн Б/51 тушаалаар Компьютер хэл шинжлэлийн лабораторийг байгуулсан. Тус лаборатори нь цахим хэл шинжлэлийн МУ-д хөгжүүлж, их өгөгдөл, цахим бичвэрт суурилсан хэлний мэдээллийн боловсруулалт, салбар дундын судалгааг хөгжүүлж, Монгол толь /mongoltoli.mn/, www.dict.ac.mn цахим толь бичгүүдийн хэвийн аюулгүй ажиллагааг хангаж, жил бүр шинэчлэн баяжуулах ажлыг гүйцэтгэсэн. Энэ онд Монгол толь /mongoltoli.mn/-ийн цахим бичвэрийн 60,000 гаруй толгой үгэнд ОУ-ын дуудлагын (IPA) галиг хадах Монгол толь, 120,000 орчим холбоо үгийн монгол бичгийн бичлэгийг шинээр нэмэх, мөн ШУ-ны түлхүүр нэр томьёоны өгөгдлийн санг www.dict.ac.mn химийн ШУ-ны нэр томьёогоор баяжуулах ажил хийсэн. Цахим толь бичгийг 1924 онд “Судар бичгийн хүрээлэн”-гийн дэргэд “Нэр томьёоны комисс” байгуулагдсан цагаас боловсруулж байсан үе үеийн нэр томьёочдын бүтээлд тулгуурлан хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс санаачлан ШУА-ийн ХЗХ болон бусад байгууллагын эрдэмтэн судлаач нартай	50	БШУЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

				хамтран боловсруулсан “Монгол Орос нэр томъёоны толь бичиг” 4 боть бүтээлийн үгийн санд түшиглэн шинэчлэн бүтээсэн.		
2.3.16.Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1	Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2020-2024	ШУ-ны академийн тэргүүлэгчдийн хурлын 2022.12.26-ны өдрийн А/20 дугаар тогтоолд үндэслэсэн ХЗХ-ын захирлын 2023.06.30-ны өдрийн Б/51 тушаалаар Компьютер хэл шинжлэлийн лабораторийг байгуулсан. Тус лаборатори нь цахим хэл шинжлэлийн МУ-д хөгжүүлж, их өгөгдөл, цахим бичвэрт суурилсан хэлний мэдээллийн боловсруулалт, салбар дундын судалгааг хөгжүүлж, Монгол толь /mongoltoli.mn/, www.dict.ac.mn цахим толь бичгүүдийн хэвийн аюулгүй ажиллагааг хангаж, жил бүр шинэчлэн баяжуулах ажлыг гүйцэтгэсэн. Энэ онд Монгол толь /mongoltoli.mn/-ийн цахим бичвэрийн 60,000 гаруй толгой үгэнд ОУ-ын дуудлагын (IPA) галиг хадах Монгол толь, 120,000 орчим холбоо үгийн монгол бичгийн бичлэгийг шинээр нэмэх, мөн ШУ-ны түлхүүр нэр томъёоны өгөгдлийн санг www.dict.ac.mn химийн ШУ-ны нэр томъёогоор баяжуулах ажил хийсэн.	50	БШУЯ
Зорилго: Шинжлэх ухаан, технологи, инновац. 2.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.						
2.4.1.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.	1	Салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлнэ.	2020-2024	2022 оны төсвийн тодотголоор эрдэм шинжилгээний зардлыг төсвийн хэмнэлттэй холбоотойгоор 5 тэрбум, ШУТ-ийн салбарын хөрөнгө оруулалтыг 18 тэрбумаар танасан нь судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар үр дүн, салбарын хөрөнгө оруулалт/ШУТИ-ийн судалгааны орчин бүхий нэгдсэн цогцолборын барилгын санхүүжилтээс танагдсан/ гүйцэтгэл болон Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.54 хувьд хүргэх зорилгот түвшинд хүрэх боломжийг хязгаарласан байна.	30	БШУЯ
2.4.2.Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.	2	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборыг олон улсын стандартад нийцүүлж, нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн судалгааны нэгдмэл байдлыг хангана.	2020-2024	Улсын төсвийн санхүүжилт гүйцэтгэх хугацаанаас хоцорч төсөвлөгдсөнөөс шалтгаалж байна. 2021, 2022, 2023 онд хэрэгжүүлэхээр хүрэх түвшиний шалгуур хангагдаагүй байна. Тус арга хэмжээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшинтэй уялдахгүй байна. Тайлагнал хангалтгүй. Гадна цахилгааны ажлыг дуусгаж улсын комисс хүлээж авсан гэх боловч нотлогдохгүй байна. Тус 3 лабораториг 2024 оны 2-р улиралд хүлээн авах төлөвлөгөөтэй байгаа гэв. 2.4.3.2-р арга хэмжээнд тайлагнасан нь давхардсан байна.	30	БШУЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

	3	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина.	2020-2024	2021 онд зураг төсөл хийгдсэн. Барилгын явц, улсын төсвөөс хамааралтай удаашралтай байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэх талаар хэлэлцэж байна. Дээрх хуулийн дагуу журмын төсөл боловсруулагдсан, батлагдаагүй байна. Хүрэх түвшин хангахгүй байна.	50	БШУЯ
	4	Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны үндэсний төвүүдийг байгуулж, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлнэ.	2020-2024	ЭЗ-н орчин бүрдсэн, Хамтарсан судалгааны төв байгуулах бэлтгэл хийсэн. ЗГ-ын тогтоолоор судалгааны их сургууль байгуулах төсөл боловсруулж хяналтад хүргүүлсэн. 2022-2023 хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт хангаагүй байна.	50	БШУЯ
Зорилго: Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. 2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ						
2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.	3	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2020-2024	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 11 бүлэг, 60 зүйлтэйгээр боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна.	50	ХНХЯ
2.5.3. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.	1	Хуримтлалын нэгдсэн сан бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2020-2022	ХНХЯ Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2023.11.30-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. МУ-ын онцлогт нийцсэн Хуримтлалын тогтолцоог бий болгох Хуримтлалын нэгдсэн сангийн хууль, эз-н орчныг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрийн хамт боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Хуримтлалын нэгдсэн сангийн орлого, зарлагын хэтийн төлөвийг тооцох актуар тооцооллыг хийж байна.	50	ХНХЯ
2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	1	Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.	2020-2024	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран баталахаар ХЗДХЯ-нд 2023.12.01-ний өдрийн 01/3132 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон зардлын тооцоог боловсруулж байна.	50	ХНХЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

2.5.7. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.	1	Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.	2020-2024	Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, тандан судалгааг яамны холбогдох газруудад танилцуулж санал авсан. Үзэл баримтлалын төслийг ХЗДХ-ийн сайд, Сангийн сайдтай хамтран батлуулахаар хүргүүлээд байна.	50	ХНХЯ
2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	2	Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих асуудлаарх эрх зүйн орчныг шинэчилж, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2021-2024	Холбогдох хуулиудыг шинэчлэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулж Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг батлуулсан байна. Соёлын тухай хууль шинэчлэн найруулагдсан, 2022 оны Төсвийн тухай хуультай холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 заалтад эмэлт өөрчлөлт оруулж, 2 журам, 1 аргачлалыг батлуулж, 27 журам, 8 стандарт, 1 нийтлэг шаардлага, 2 хүүхэд хамгааллын бодлого боловсруулахаар төлөвлөсөн байна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 27 зүйл, заалтад өөрчлөлт оруулж, Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах журмыг батлуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийт 8 удаа нэмэлт болон өөрчлөлт оруулсан, хуулийн шинэчилсэн найруулга боловсруулалтын шатанд байна.	50	ХНХЯ
	3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2021-2024	"Саадгүй байдал, хүртээмжийн тухай" хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна. Хугацааны хоцрогдолтой, мөн хууль батлагдаагүй тул ямар нэгэн журам батлаагүй байна.	50	ХНХЯ
	4	Хүн амын амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн Хүний амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	Хөтөлбөрийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн ч буцаагдсан байна. Хөтөлбөрийн төсөл боловсруулалтын шатанд.	30	ХНХЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

	5	Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ.	2021-2024	Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр ХНХЯ, ЭМЯ хамтран 3 зорилтын хүрээнд 24 үйл ажиллагаа бүхий “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар баталсан байна. Төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлуудыг тайлагнасан хэдий ч төлөвлөгөөний биелэлтийг тусгаагүй, түүнд хяналт хэрэгжүүлж үнэлээгүй байна. Зорилтод түвшинг хангасан эсэх нь тодорхойгүй.	50	ХНХЯ, ЭМЯ
	8	Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн үйлчилгээг хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.	2021-2024	Зураг төсөл, төсвийг БХТ-ийн 2022 оны 2415/2022 дугаартай МЭД-ээр баталгаажуулсан. Газрын маргаантай, ХАА-г 3 удаа зарласан ч гүйцэтгэгч шалгараагүй байна.	30	ХНХЯ
			2021-2024	Улаанбаатар хотод байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын угсралтын ажлыг 2022 оноос “Би энд Би” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга угсралтын ажил 83 хувийн гүйцэтгэлтэй байна.	50	ХНХЯ
			2021-2024	Зураг төсөл боловсруулалтын шатанд, ТЭЗҮ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээг 2022 онд, техникийн нөхцөлийн үнэлгээг 2019 онд авсан. БНХАУ-ын санхүүжилт хүлээгдэж байна.	30	ХНХЯ, БТСУХ
2.5.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.	2	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг НОГООН ХӨГЖИЛ-ийн үзэл баримтлалд тулгуурлан санхүүгийн олон эх үүсвэртэй болгож салбарын хэрэгцээнд нийцүүлэн төрөлжсөн салбар дундын үйлдвэрлэл, дадлагын баазыг байгуулж, шинэ хотхоныг бий болгоно.	2020-2024	Хүрэх түвшинд тодорхойлсон барилгын ажил 60хувь хүрсэн " байх ажил хийгдээгүй байна. Тус арга хэмжээнд , чадамжийн төвүүдийг байгуулсан тухай тайлагнасан нь хүрэх түвшинтэй уялдахгүй байна. Мөн барилгын ажил эхлүүлсэн тооцоо, зураг, төсөв санхүүгийн эх үүсвэр, зардалын тооцоо, зарцуулалт тодорхойгүй.	50	БШУЯ
2.5.12.“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий	1	Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгоно.	2021-2024	Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталж эрх зүйн орчинг бүрдүүлсэн боловч 2023 онд хүчингүй болсноор арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон.	50	ХНХЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.						
2.5.14.Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.	1	Эдийн засгийн загварчлалд суурилсан бүтээн байгуулалт, салбар дундын зохицуулалтыг бий болгож, тогтолцоог хөгжүүлнэ.	2020-2024	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг 2021 онд хийсэн гэх боловч тус ажлыг хэрэгжүүлснээр ямар ахиц гарсан, ямар ажлыг тус загварын тусламжтай оновчтой хийж гүйцэтгэж байгаа нь тодорхой бус байна. Мөн эдийн засгийн загварчлалд суурилсан бүтээн байгуулалт, салбар дундын зохицуулалтыг бий болгоогүй, туршин хэрэгжүүлээгүй байна.	30	ХНХЯ
2.5.15.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	2	Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж ажиллах, тэдний ур чадварыг нутагшуулахыг бодлогоор дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хөдөлмөр зуучлалын бирж байгуулна.	2020-2024	"Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь" төслийг боловсруулан хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэлийг ханган ажилласан байна."Ejob" платформд гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдэд зориулсан сан бүхий хэсгийг хийхээр мөн гадаадад амьдарч байгаа иргэдийг эх орондоо буцан ирэхийг дэмжихэд зориулж "Зөгийн үүр-2" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	30	ХНХЯ
Зорилго: Үндэсний бахархал, өв соёл. 2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно						
2.6.1.Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна.	2	Байгалийн түүхийн шинэ музей	2020-2023	БСПУЯ, ТХААГ нийт 9 удаа тендер зарласан ч шаардлага хангаагүй эсвэл тендер амжилтгүй болж байсан. Тус арга хэмжээнд төлөвлөсөн хүрэх түвшинг хангаагүй. 2020 онд улсын төсвөөс 18.0 тэр бум, 2021 онд 13.3 тэр бум төгрөг төсөвлөгдсөн боловч 8 удаагийн тендер худалдан авах ажиллагааг шаардлага хангалтгүй явдагсаны улмаас хэрэгжээгүй байна гэж тайлагнасан байна. 2020,2021,2022,2023 оны хүрэх түвшинд хүрээгүй хэрэгжээгүй байна. Шалтгаан нь цар тахалын үеийн хүндрэл, тендер амжилтгүй болсон.	50	Соёлын яам
	4	Үндэсний урлагийн их театрын шинэ барилга	2020-2023	Тус арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гэх боловч , хүрэх түвшинд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй байна.	30	Соёлын яам
	6	Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”	2021-2023	2023 онд тодорхойлсон хүрэх түвшинд хүрээгүй, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 дугаар тушаалын жагсаалтад "Хөвсгөл нуурыг түшиглэсэн Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв"-ийн зураг төслийг хэрэгжүүлэх 120.0 сая төгрөг батлуулж шийдвэрлэсэн.	30	Соёлын яам
	7	Хүүхдийн номын сан, хүүхэддэйн театр	2021-2024	"Хүүхдийн номын сан хүүхэддэйн театр барих зураг төсвийг 2022-2023 оны Улсын төсөвт 1,078.9 сая төгрөгөөр баталж, төслийн зураг төсөв баталгаажуулсан. Хүүхдийн номын сангийн барилгын МЕД нь 19,908,576,588 төгрөгөөр, Хүүхэддэйн театрын барилга 29,240,701,486 төгрөгөөр, Хүүхдийн номын сан, хүүхэддэйн театрын гадна шугам сүлжээ 5,020778,626 төгрөгөөр нийт 54,170.056,700	30	Соёлын яам, БХБЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

				төгрөгөөр баталгаажсан. Барилга угсралтын ажил 60 хувьд хүргэсэн байна гэсэн түвшинд хүрээгүй байна.		
	11	Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ.	2021-2024	Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлсэн байна.	50	БХБЯ
2.6.2.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ.	1	"Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2023	Соёлын сайдын 2023.05.01-ний өдрийн А/150 тушаалаар ажлын хэсгийг байгуулан "Цахим соёл" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, ТНБД-аар батлан хэрэгжилтийг хангасан. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн Creativehub.mn системийн хөгжүүлэлтийг дуусгасан. Одоогоор 149 байгууллага, 436 уран бүтээлчийн 573 уран бүтээлийг оруулсан. Номын сангийн бүртгэл мэдээллийн систем болон Соёлын өвийн бүртгэл мэдээллийн систем хөгжүүлэлт, серверийг үндэсний дата төв дээр байршуулж, Хур системийн холболтыг ажил хийгдэж байна.	50	Соёлын яам
	7	Соёлын өвийг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ.	2021-2024	Соёлын салбарт хамтран ажиллах тухай МУСЯ, БНТУ, УСАУЖ-ын яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-т "Соёлын төвийг байгуулах асуудлыг ЗГ-ийн газар хоорондын тусгайлсан хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэнэ" гэж тусган оруулсан бөгөөд цаашид судалгаан дээр үндэслэн "Монголын соёлын төв"-ийг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Соёлын өвийг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ гэж зориж байна.Зорилтод түвшин хангаагүй байна.	50	Соёлын яам
2.6.3.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1	Монгол хэл, бичиг, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх “Монголын соёлын төв”-ийг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудыг түшиглэн байгуулна.	Гадаадад монголын соёлын төвийг үе шаттай байгуулах талаар судалгаа хийж, шийдвэрийн төслийг боловсруулж, шаардагдах төсвийг батлуулна.	МУ-ас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Монголын соёл, мэдээллийн төвийг байгуулан үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёлын яам, БНТУ-ын Улсын Соёл, аялал жуулчлалын яамд хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг"- т "Соёлын төвийг байгуулах асуудлыг судалгаан дээр үндэслэн "Монголын соёлын төв"-ийг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Монгол хэл, бичиг, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх “Монголын соёлын төв”-ийг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудыг түшиглэн байгуулна гэсэн зорилтод түвшнийг хангаагүй байна.	69	Соёлын яам, ГХЯ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

	2	Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.	2021-2025	"Гадаадын их дээд сургуульд 20-оос доошгүй оюутан, дотоодод 250-аас доошгүй соёлын ажилтныг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна" гэсэн ажил хэрэгжсэн боловч 2021 онд Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн барилгын зураг төслийг боловсруулсан байна, 2022 онд Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн БУА-ыг эхлүүлнэ, 2023 онд соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн барилгыг ашиглалтад оруулна гэсэн төлөвлөлт хэрэгжээгүй байна.	69	Соёлын яам, БХБЯ
	3	Үндэсний кино урлагийг дэмжинэ.	2021-2025	Гадаадад кино урлагийн чиглэлээр 2 -оос доошгүй мэргэжилтэн бэлтгэх зорилтот түвшинд хүрсэн эсэх талаар тайлагнаагүй, хүрэх түвшинг бүрэн хангаагүй.	50	Соёлын яам
	3.1	Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.	2021-2025	Тайз, хөгжим, дэлгэц медиа, дүрслэх урлагаар дамжуулан хүүхдэд урлагийн боловсрол олгох "Урлагийн боловсролын хөтөч" сургалт, мэдээллийн төв байгуулах зорилтот түвшинд хүрсэн эсэх нь тодорхойгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй, Хүрэх түвшинг бүрэн хэрэгжүүлээгүй шалтгаан нь яамны чиг чиг үүрэгт хамаарахгүй зорилт дэвшүүлсэн нь байна.	50	Соёлын яам
	4	Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг буй болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	2021-2025	ОУ-ын стандартад нийцсэн виртуал галерейг бий болгоно. Урлагийн нарийн мэргэжлээр гадаадад 10-аас доошгүй оюутан сургана. 2023 онд тодорхойлсон хүрэх түвшинг бүрэн хангаагүй	50	Соёлын яам
	5	Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.	2021-2025	2021-2023 онд аймаг, нийслэлд нийтдээ 77 төсөлд 349.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгаж, үүнээс 2023 оны байдлаар ашиглалтад орсон 47 төсөл арга хэмжээ байна. Бүтээн байгуулалтын ажилд 2022 онд 4,726.7 сая төгрөгийг улсын төсөв, 2023 онд 14,901.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн ч 2023 онд "11 аймагт Соёл, урлагийн газрын барилгыг барьж ашиглалтад оруулна. 10 аймагт Соёл, урлагийн газрын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ" зорилтод түвшинд хүрсэн эсэх, бүтээн байгуулалтыг хэдэн аймагт хийснийг тайлагнаагүй байна.	69	Соёлын яам, Сангийн яам

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Зорилго: Санхүү, төсвийн зохицуулалт. 3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

3.1.4.Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.	1	Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.”	2020-2024	2023 онд Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан" гарсан, УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 49 дүгээр зүйлд “Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2022 онд багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх.. гэж заасан хугацаанд хэрэгжээгүй байна.	30	Сангийн яам
3.1.5.Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	2020-2024	УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 49 дүгээр зүйлд “Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2022 онд багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх.. гэж заасан хугацаанд хэрэгжээгүй байна.	30	Сангийн яам
3.1.13 Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.	1	Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ	2020-2021	Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсронгуй болгох саналыг тусгуулахаар ШСАА-д 2023 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. Хуулийн төсөл УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдсан.	30	ШСАА, ШӨХТГ
	2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ	2020-2021	2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн А/49 тоот тушаалаар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хуулийн төслийг боловсруулах ажлыг хийж байна. Хүрэх түвшин шалгуур үзүүлэлт хангаагүй.	30	ШСАА, ШӨХТГ
	3	Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээ (үндэсний хөтөлбөр) боловсруулна	2021-2024	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичигт Өрсөлдөөний чиглэлээр хэрэгжүүлэх 3 арга хэмжээг Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгот хөтөлбөрт тусган, ЭЗХЯ-д батлуулахаар 2022 онд хүргүүлсэн. Хүрэх түвшин шалгуур үзүүлэлт хангаагүй.	30	ШСАА, ШӨХТГ
	4	Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна	2020 -2024	2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн А/49 тоот тушаалаар Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хуулийн төслийг боловсруулах ажлыг хийж байна. Хүрэх түвшин шалгуур үзүүлэлт хангаагүй.	50	ШСАА, ШӨХТГ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан

